

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

ЭМХЭТГЭЛ 5



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэл 5

С.СҮХЧУЛУУН, LL.M

МУ-ын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвийн судлаач

Л.ОТГОНДОРЖ

Таванлекс ХХН-ийн өмгөөлөгч

Улаанбаатар хот

2020 он

ННА 67.3
ДАА 340.009
С-86



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эмхэтгэл 5

Судлаачид:

С.Сүхчулуун, LL.M
МУ-ын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвийн судлаач
Л.Отгондорж
Таванлекс ХХН-ийн өмгөөлөгч

Эмхэтгэлийг хянан тохиолдуулсан:

Т.Мөнх-Эрдэнэ, Хууль зүйн ухааны магистр (LL.M - University of Vienna, Austria),
МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш
П.Бадамрагчаа, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

Судалгааны хүрээнд гаргасан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд
Нээлтэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг
шууд илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9645-8-0

© Нээлтэй Нийгэм Форум, 2020

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ГАРЧИГ

Удиртгал	8
НЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР, ДҮН ШИНЖИЛГЭЭ	11
Дүн шинжилгээ 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй байгаа сумын Засаг даргын татгалзал хууль бус болохыг тогтоож, уг төлөвлөгөөг батлахыг сумын Засаг даргад даалгах тухай	11
Дүн шинжилгээ 2. Иргэн С.Доржпүрэвийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох захиргааны хэрэг	24
Дүн шинжилгээ 3. Нэр бүхий хоёр компанид олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг илт хууль бус захиргааны акт болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргуулах тухай	33
Дүн шинжилгээ 4. Нэр бүхий компаниудын тусгай зөвшөөрлүүдийг цуцлахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгах шаардлага бүхий хэрэг	50
Дүн шинжилгээ 5. Иргэн Н.Эрдэнийн нэхэмжлэлтэй Баянзүрх дүүргийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг	58
ХОЁР. ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ АСУУДЛААР НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	69
Дүн шинжилгээ 1. “Онги голынхон хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлтэй Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд холбогдох шүүхийн маргаан	69
Дүн шинжилгээ 2. “Хөвсгөл далайн эзэд” ТББ, иргэн Г.Даваачулуун, Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн даргад холбогдох шүүхийн маргаан	77

Дүн шинжилгээ 3. НУАХ ТББ нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн даргад холбогдох шүүхийн маргаан	86
Дүн шинжилгээ 4. Дэлхийн Монгол Ногоон нэгдэл ТББ нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн даргад холбогдох шүүхийн маргаан	92
Дүн шинжилгээ 5. “Ангир нүдэн мөндөөхэй хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлтэй Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл	95

ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 103

Дүн шинжилгээ 1. “Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ-ын нэхэмжлэлтэй “Петрочайна дачин тамсаг” ХХК-д холбогдох иргэний хэрэг	103
Дүн шинжилгээ 2. “Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ-ын нэхэмжлэлтэй “Таван толгой” ХК, “Нүүрсний зам” ХХК, “Энержи ресурс” ХХК-д холбогдох шүүхийн маргаан	115
Дүн шинжилгээ 3. “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох шүүхийн маргаан	123
Дүн шинжилгээ 4. “Эрүүл байгаль, энх амьдрал, энэрэнгүй үйлс” НҮТББ-ын нэхэмжлэлтэй “Рэдхил Монголиа” ХХК-д холбогдох шүүхийн маргаан	130
Дүн шинжилгээ 5. Прокурорын газрын нэхэмжлэлтэй нэр бүхий иргэдэд холбогдох байгаль орчинд учруулсан хохиролд нөхөн төлбөр гаргуулахыг хүссэн иргэний хэрэг	134

ДӨРӨВ. ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ 140

ХАВСРАЛТ.

Хавсралт 1. Дүн шинжилгээ хийхээр сонгосон шүүхийн шийдвэрийн хялбарчилсан хүснэгт	150
Хавсралт 2. Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах үед тулгардаг бэрхшээлүүд (Холбогдох төрийн бус байгууллагаас утсаар холбогдож авсан судалгааны товч үр дүн)	169

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМтХ	Ашигт малтмалын тухай хууль
АМГТГКХ	Ашигт малтмал газрын тосны газар, Кадастрын хэлтэс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОХтХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
БОНБУтХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
ГтХ	Газрын тухай хууль
ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
ГУУКХ	Геологи уул уурхайн кадастрын хэлтэс
ГХОтХ	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗХХШтХ	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХ	Иргэний хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МУЗЗНДНТУтХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТББтХ	Төрийн бус байгууллагын тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ДҮН ШИНЖИЛГЭЭНД ХЭРЭГЛЭСЭН ЗАРИМ ТЭМДЭГЛЭЛ:

- Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг гүйцэтгэхдээ нийтлэг тогтсон жишигт үндэслэн нэхэмжлэгч талыг “Х”, хариуцагч талыг “Ү”, хэд хэдэн нэхэмжлэгч болон хариуцагч оролцсон бол “Х1, Х2, ...”, “Ү1, Ү2, ...”, гуравдагч этгээдийг “А”, “Б”, “В” гэх дарааллаар тэмдэглэсэн болно.
- Шүүхийн шийдвэрт дурдагдаж буй ач холбогдол бүхий хууль тогтоомжийн зүйл заалтыг эшлэл хэлбэрээр оруулав.
- Зарим шүүхийн шийдвэрийн үндэслэлийг танилцуулах хэсэгт тоон дугаарлалт хийсэн нь тухайн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд тусгагдсан дугаарлалт бус, дүн шинжилгээ хийхэд маргааны үндсэн асуудалд холбогдолтой ач холбогдол бүхий үндэслэл гэсэн агуулгаар хийсэн болохыг тэмдэглэх нь зүйтэй.

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний энэ удаагийн эмхэтгэлээ сэдэвчилсэн байдлаар буюу байгаль орчныг бохирдуулсантай холбоотой иргэний болон захиргааны шүүхээс гаргасан шийдвэрүүдийн бэсрэг шинжилгээг нэгтгэн уншигч Танд танилцуулж байна.

Байгаль орчны холбогдолтой хэрэг маргаан нь хохирлын шинжээрээ хүний эрүүл орчинд амьдрах эрхийг хөнддөг, хохирол тодорхойлох, тооцох аргачлал хангалтгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, түүнд тулгуурлан шийдвэр гаргах үйл явцад олон талын оролцоо шаарддаг. Энэхүү нарийн төвөгтэй байдал нь хууль хэрэглээний, шүүхийн харьяалалтай холбоотой маргаан түгээмэл үүсэхэд хүргэдэг байна. Тус эмхэтгэлд орсон 15 дүн шинжилгээ нь дээр дурдсан олон асуудлыг судлан дүгнэж, тодорхой зөвлөмж дэвшүүлэх гэж зорьсныг тэмдэглэх нь зүйтэй.

Шүүхийн шийдвэрийн сэдэвчилсэн эмхэтгэл нь байгаль орчны маргааныг шийдвэрлэхэд бүх шатны шүүгчдэд төдийгүй энэ төрлийн маргааны оролцогч тал болох хуульчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүдээс гадна байгаль орчны бохирдолд өртөж, хохирсон хохирлоо нөхөн төлүүлэхээр, эрх ашгаа хамгаалуулахаар шүүхэд хандахыг хүссэн хэн бүхэнд хэрэгтэй эх сурвалж болно хэмээн найдаж байна.

Уншигч Таныг судалгаа шинжилгээний чанар, үр нөлөөг нэмэгдүүлэхтэй холбоотой санал шүүмжээ бидэнтэй харамгүй хуваалцаж, шүүхийн практик судалгааны хөгжилд хувь нэмэр оруулахыг хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын уул уурхайн салбар эрчимтэй хөгжихийн хэрээр улс орны эдийн засгийн чадавх дээшлэн, дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх зэрэг сайн тал ажиглагдаж байгааг судалгаа шинжилгээний дүнгүүд харуулж байгаа билээ. Үүнтэй зэрэгцэн байгаль орчны бохирдол, ялангуяа уул уурхайн үйл ажиллагаанаас улбаалан ундны ус, гол мөрөн ширгэх зэрэг бэрхшээл, сорилт ч мөн тулгарч эхэллээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах, экологийн тэнцвэр алдагдахаас хамгаалуулах эрх зөрчигдөх суурь шалтгаан болж байна.

IRIM судалгааны хүрээлэнгээс 2011 онд бичил уул уурхайн үйл ажиллагааны талаар хийсэн нэгэн судалгааны тайланд “алтны орд бүхий Заамар, Мандал, Тариалан сумуудад усны ундарга багасах, урсац нарийсан тасрах, усыг ундандаа хэрэглэж чадахаа болих, гол ширгэх, мөнгөн ус илрэх, ахуйн хог хаягдлаар бохирдох зэрэг хамгийн олон шинж тэмдэг илэрч байгаа” гэж тэмдэглэжээ. Үүнээс үүдэн уул уурхайн олборлолт хийж буй бүс нутгийн ард иргэд болон хүрээлэн буй орчныг бохирдлоос хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд хамтран байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах болсон.

Харамсалтай нь, байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл нь нэгэнт байгаль орчин сүйтгэгдэж, экологийн тэнцвэрт байдал алдагдсаны дараа мөнгөн дүнгээр нэхэмжилж буй шаардлага тул үр дүн багатай. Харин хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулсан уул уурхайн компанийн эсрэг байгаль орчинд хохирол учруулж буй үйлдлийг нь таслан зогсоох тухай нэхэмжлэл гаргах нь илүү үр дүнтэй. Гэвч бодит байдалд шүүхээр шийдвэрлэгдэж байгаа энэ төрлийн хэрэг маргааныг авч үзэхэд, байгаль орчинд учирсан хохирлыг мөнгөөр тооцон нэхэмжлэл гаргахаас бус хохирол учруулж буй тухайн буруутай үйл ажиллагааг таслан зогсоох тухай нэхэмжлэл гаргадаггүй байна. Энэ нь нэг талаас, манай улсын хувьд эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох талаарх нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой юм.

Иймээс энэхүү судалгаагаар байгаль орчны бохирдолтой холбогдон шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаанд дүн шинжилгээ хийж, тухайн шүүхийн шийдвэрт хөндөгдөж болох эрх зүйн асуудлыг нэгтгэн дүгнэж, судлаачийн байр сууриа илэрхийлэхийг зорьсон болно.

Бид судалгааны хүрээнд байгаль орчин, түүний бохирдолтой холбогдуулж гаргасан иргэний болон захиргааны нэхэмжлэлтэй тус бүр 5 хэрэг, хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн захиргааны нэхэмжлэлтэй 5 хэрэг, нийт 15 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Эдгээр сонгосон шийдвэрийн хувьд байгаль орчин, түүний бохирдолтой холбоотой шүүхийн шийдвэр дотроос тухайн маргаан дээр онолын маргаан бүхий асуудлыг дэвшүүлж болохоор хийгээд процесс ажиллагааны хувьд ач холбогдолтой шийдвэрүүдийг багтаахыг зорьсон болно. Тодруулбал, иргэний хэргийн хувьд байгаль орчны бохирдлыг нөхөн төлүүлэх эрх зохицуулалтын хувьд маргаантай асуудал байдаг бол захиргааны хэргийн хувьд байгаль орчны үнэлгээ, тусгай зөвшөөрөлтэй холбоотой онолын маргаантай асуудал юм. Харин хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэргийн хувьд нэхэмжлэгч болох төрийн бус байгууллагын нэхэмжлэл гаргах эрх нь маргаантай асуудал хийгээд бусад шүүхийн процесс ажиллагааны ач холбогдлыг тодруулах үүднээс дүн шинжилгээ хийх шийдвэрийг сонгон авч судаллаа. Шийдвэр тус бүрийн дүн шинжилгээг гүйцэтгэхдээ тухайн хэргийн хувьд эцсийн шийдвэр болох холбогдох шатны шүүх хуралдааны шийдвэрийг сонгож авсан болно. Гэхдээ зарим хэргийн хувьд хяналтын шатны шүүх хуралдаанаар хэрэг хянан хэлэлцээд анхан шатны шүүх рүү дахин хянуулахаар буцаасан тохиолдолд тухайн хэргийн эцсийн шийдвэр гараагүй байгаа гэж үзэн Улсын дээд шүүхээр хянагдсан тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн тохиолдол байгааг анхаарна уу.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь эрх зүйн салбарт шинэ тутам хөгжиж буй судалгааны ажлын нэгэн төрөл болохын хувьд уг судалгааны ажлаар байгаль орчин, түүний бохирдолтой холбоотой шүүхийн шийдвэр хэмээн хамрах хүрээг тодорхойлж, тухайн хэрэг дээр үүсэж болох онолын маргаантай асуудал болон хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагаа зөв хийгдсэн эсэх зэрэг асуудлыг авч үзэв. Уг судалгааны ажилд хамрагдсан зарим шүүхийн шийдвэрийн хувьд өөр

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

судалгаанд эшлэгдэх, жишээ, тохиолдол байдлаар дурдагдах зэргээр тус шийдвэрт хамаарах бусад судлаачийн үзэл санаа тусгагдсан шүүхийн шийдвэр багтсан боловч тэдгээр судалгааны бүтээл нь шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хэлбэрээр өмнө нь бичигдээгүй байна. Эндээс харахад байгаль орчин, түүний бохирдолтой холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгаа, шинжилгээ урьд нь ховор хийгдэж байсан болов уу.

Байгаль орчны болон хүрээлэн буй орчны эрх зүйн чиглэлээр судалгаа шинжилгээний бүтээл хийх сонирхолтой оюутан, судлаач хэн бүхэнд энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь нэгэн эх сурвалжийн түвшинд ашиглагдаж, Та бүхний ажилд бага ч гэсэн тус нэмэр болох аваас бид баяртай байх болно. Түүнчлэн байгаль орчин, түүний баялгийг хамгаалах зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөлийн зүгээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хүрээлэн байгаа орчны асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэгт уг шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь бага боловч тус нөлөө үзүүлэх болов уу гэж найдаж байна.

Энэхүү судалгааны ажилд алдаа оноо гарсан байх аваас Та бүхэн санал, бодлоо уг тайланд хавсаргасан судлаач нарын цахим шуудангийн хаягаар ирүүлэхийг хүсье. Бидний зүгээс Та бүхний ирүүлэх санал шүүмжийг хүндэтгэлтэйгээр хүлээн авч, цаашид тус судалгааны ажлыг чанаржуулахад анхаарч ашиглах болно.

Төгсгөлд нь энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Нээлттэй Нийгэм Форумд гүн талархал илэрхийлье.

НЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дүн шинжилгээ 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй байгаа сумын Засаг даргын татгалзал хууль бус болохыг тогтоож, уг төлөвлөгөө батлахыг сумын Засаг даргад даалгах тухай¹

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч Чулуун цаг ХХК (цаашид нэхэмжлэгч Х ХХК гэх) нь хайгуулын тусгай зөвшөөрлийн сүүлийн 3 жилийн хугацаа сунгуулахыг үндэслэлгүйгээр татгалзаж буй Завхан аймгийн Сантмаргаз сумын Засаг дарга (цаашид хариуцагч Ү Засаг дарга гэх)-ын хууль бус үйлдэхүйг тогтоож, хайгуулын тусгай зөвшөөрлийн сүүлийн 3 жилийн сунгалт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахыг хариуцагч Ү Засаг даргад даалгаж өгнө үү? гэсэн шаардлага гаргажээ.

– Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл²

Нэхэмжлэгч Х ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Ашигт малтмалын тухай хууль (АМТХ)-ийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.3³, 38 дугаар зүйлийн 38.2⁴, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.3⁵ дахь хэсгүүдэд заасныг баримтлан нэхэмжлэгч Х ХХК-ийн

¹ 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 540 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1160/view>

² 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, дугаар 60, <http://new.shuukh.mn/zahirgaahan/3642/view>

³ 22 дугаар зүйл. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

⁴ 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.3, 38.1.6-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаасаа хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

⁵ 40 дүгээр зүйл. Байгаль орчны нөлөөллийн шинэчилсэн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөг хянуулах (Энэ зүйлийн гарчигт 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

байгаль орчны төлөвлөгөөг батлахгүй байгаа хариуцагч Засаг дарга Ү-ийн татгалзал хууль бус болохыг тогтоож, нэхэмжлэгч Х ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахыг хариуцагч Ү Засаг даргад даалгасугай. Шийдвэрийн үндэслэл нь:

1. АМТХ-иар байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хүргүүлэх, батлах нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч, хайгуулын талбай байршиж буй сумын Засаг дарга нарын хуулиар хүлээсэн үүрэг, зөвхөн тэдгээрийн хооронд үүсэх эрх зүйн харилцаа байх тул хариуцагч Ү Засаг дарга нь Х ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлаагүй шалтгаанаа сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдийн шийдвэрийг биелүүлсэн гэж тайлбарлаж, хуулиар өөрт тухайлан олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь хууль бус байна.
 2. Хариуцагч Ү Засаг дарга нь нэхэмжлэгчийг АМТХ-ийн 38.1.8-д⁶ заасан үүргээ биелүүлээгүй, 2014 онд буюу ганцхан удаа мөнгөн хөрөнгийг байршуулсан баримт байдаг тул байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлаагүй гэж тайлбарлажээ. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн хайгуулын ажлын хүрээнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг сумын Засаг даргын нээсэн тусгай дансанд шилжүүлэх бөгөөд байгаль орчинд нөлөөлөхүйц хайгуулын өрөмдлөгийн болон хээрийн ажил хийгээгүй бол уг зардлыг байршуулах шаардлагагүй байна.
- Давж заалдах шатны шүүхийн шийдвэр, үндэслэл⁷

Давж заалдах шатны шүүхээс хариуцагч Ү Засаг даргын давж заалдах гомдлыг хангалгүй анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгээс “22 дугаар зүйлийн 22.1, 22.1.3⁸” гэснийг хасаж, шийдвэрийн бусад

⁶ 38.1.8. байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.

⁷ 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 0750 <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1673/view>

⁸ 22 дугаар зүйл. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

заалтыг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхижээ. Магадлалын үндэслэл нь:

1. АМтХ-ийн 38 дугаар зүйлийн 38.2-т⁹ зааснаар сумын Засаг дарга тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах бөгөөд түүнийг батлахаас татгалзсан тохиолдолд ийнхүү татгалзсан үйлдэл нь хуульд нийцсэн байх учиртай.
2. Хариуцагч Ү Засаг дарга нь “хайгуулын үйл ажиллагааг зогсоохыг шаардсан малчид, иргэдийн санал шаардлага болон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол”-ыг үндэслэж, нэхэмжлэгч Х ХХК-ийн менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзжээ.
3. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудалд хориг тавьж ажиллахыг сумын Засаг даргад үүрэг болгожээ. Тусгай зөвшөөрөл олгох, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах асуудлууд нь өөр хоорондоо ялгаатай бөгөөд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахыг хориглоогүй байна.
4. Төлөвлөгөөг батлахаас татгалзсан албан бичигт тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэзээний, ямар тогтоолыг үндэслэн татгалзсан болохыг тодорхой заагаагүй, “Ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулахыг эсэргүүцсэн Баяннуур багийн иргэдийн жагсаалт” гэх баримтад зурагдсан иргэдийн гарын үсэг нь хэзээ зурагдсан болох нь тодорхойгүй байна.

22.1. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө түүнийг эзэмшигч нь хугацааг сунгуулах тухай өргөдлийг төрийн захиргааны байгууллагад гаргаж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана: ... 22.1.3. байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн батлуулсан баримт (Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

⁹ 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.3, 38.1.6-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаасаа хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

5. Захиргааны ерөнхий хууль (ЗЕХ)-ийн 24 дүгээр зүйлд¹⁰ зааснаар захиргааны байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай үндэслэл бүрийг нарийвчлан судалж, холбогдох нотлох баримтуудыг цуглуулан, ач холбогдол бүхий бодит нөхцөл байдлыг тогтоосны эцэст түүнд үндэслэж шийдвэр гаргах учиртай.

Хоёр. Шүүхийн шийдвэрийн агуулга

Улсын дээд шүүхийн шийдвэр, үндэслэл¹¹

Хариуцагч Ү Засаг даргын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангалгүй давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах гэж шийджээ. Тогтоолын үндэслэл нь:

1. Нэхэмжлэгч Х ХХК нь хайгуулын ажлын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хариуцагч Засаг дарга Ү-аар батлуулахаар 2017 оны 3 дугаар сард хүргүүлсэн боловч сумын Засаг даргын 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1/70 тоот албан бичгээр “Танай компанийн хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа талбай нь тус сумын өвөлжөө, хаваржааны гол нутаг юм. Хайгуулын үйл ажиллагааг зогсоохыг шаардсан малчид, иргэдийн санал шаардлага, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол зэргийг харгалзан үзэж танай компанийн менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзаж байна” гэсэн хариу ирүүлжээ.

Дээрх 1/70 тоот албан бичиг нь тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ямар тогтоолыг үндэслэсэн нь тодорхойгүйгээс гадна захиргааны байгууллагын үндэслэл болгон тайлбарлаж байгаа тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 09, 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 18, 2017 оны 5 дугаар 11-ний 4/01 дүгээр тогтоолууд нь нэхэмжлэгч Х-ийн үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг

¹⁰ 24 дүгээр зүйл. Нөхцөл байдлыг тогтоох

¹¹ 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 540 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1160/view>

батлуулах асуудалтай шууд холбоогүй байна.

Тухайлбал, 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 09 тогтоолоор “Суманд ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа цаашид явуулахгүй байхыг дэмжиж, хурлаас гарсан тогтоол, багуудын иргэдийн гарын үсгийн баталгаажуулалт бүхий хавсралтууд, холбогдох бусад бичиг баримтыг бүрдүүлж зохих шатны эрх бүхий байгууллагад уламжлах”-ыг, 18 дугаар тогтоолоор “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудалд хориг тавьж ажиллах”-ыг сумын Засаг даргад үүрэг болгосон агуулгатай байх боловч эдгээр нь шинээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой гарсан гэж үзэхээр, түүнчлэн 4/01 дүгээр тогтоол нь нэхэмжлэгч компанийн ашигт малтмалын хайгуулын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан үйлдлээс цаг хугацааны хувьд хойно гарсан байв.

2. Ашигт малтмал, газрын тосны газрын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 4/3501 тоот албан бичиг болон бусад нотлох баримтаар нэхэмжлэгч Х ХХК нь 2008-2017 онд хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлангаа цаг хугацаандаа гаргаж, байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан нь тогтоогджээ.
3. Хариуцагч Ү Засаг дарга нь АМТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.2-т “Сум, дүүргийн Засаг дарга нь энэ хуулийн 38.1.3¹², 38.1.6¹³-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаасаа хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ” гэж заасан үүргээ хэрэгжүүлээгүй, нэхэмжлэгч Х-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан 2017 оны 1/70 тоот албан бичиг нь хууль бус, мөн хариуцагчаас

¹² 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.3. энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах

¹³ 38.1.6. энэ хуулийн 38.1.5-д заасан тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналыг тусгаж уг өөрчлөлтийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулах

нэхэмжлэгч Х ХХК-ийн менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан үндэслэлээ “тус компани тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө шилжүүлэх, менежментийн төлөвлөгөөний биелэлт болон хайгуулын ажлын жилийн тайланг жил бүр гаргаж хүргүүлэх үүргээ биелүүлээгүй, жил бүр төлбөрөө хэрхэн төлсөн нь тодорхойгүй” гэж албан бичигт заагаагүй шалтгаан, үндэслэлээр нэхэмжлэгчийг буруутгасан нь үндэслэлгүй талаар хоёр шатны шүүх зөв дүгнэлт гаргажээ.

4. Анхан шатны шүүх маргааны үйл баримтад шууд хамааралгүй хуулийн зүйл, заалтыг шийдвэрийн тогтоох хэсэгт баримталсныг давж заалдах шатны шүүхээс зөвтгөж, шүүхийн шийдвэрийн өөрчлөлт оруулсан нь үндэслэлтэй байна.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. Сумын Засаг дарга байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан тухай шийдвэр, эсхүл батлахгүй байгаа эс үйлдэхүй нь захиргааны акт болох эсэх тухай

АМТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтаар Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тусгай зөвшөөрөл авах, хугацаа сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, мэдээ, тайланг хянуулах ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлнэ¹⁴. Харин Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг

¹⁴ 10 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1. Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.4. тусгай зөвшөөрөл авах, хугацааг нь сунгах, шилжүүлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлүүлэх, хайгуулын ажлын төлөвлөгөө, мэдээ, тайланг хянуулах ажиллагааны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох

хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ¹⁵. Ингэхдээ Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох гэж зааснаас бус хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах чиг үүргийг хамааруулаагүй байна. Гэхдээ хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай нарийвчилсан зохицуулалтыг АМТХ-ийн 22 дугаар зүйлд хуульчилсан бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн хайгуулын зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах тухай өргөдлөө төрийн захиргааны байгууллага буюу дээр дурдсанаар Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж, ингэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан баримтыг хавсаргах ёстой. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл сунгуулах тухай өргөдлийг хүлээж авсны дараа ажлын 10 өдөрт багтааж тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийг сунгах тухай шийдвэр гаргах юм¹⁶. Эндээс ашигт малтмалын хайгуулын тусгай

¹⁵ 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

11.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.15. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх

¹⁶ 22 дугаар зүйл. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

22.1. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө түүнийг эзэмшигч нь хугацааг сунгуулах тухай өргөдлийг төрийн захиргааны байгууллагад гаргаж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана: 22.1.1. хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар (баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ), хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар; (Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан) 22.1.2. үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөр төлсөн, түүнчлэн хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс багагүй хэмжээний ажил гүйцэтгэсэн тухай баримт; 22.1.3. байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн батлуулсан баримт (Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан); 22.1.4. хайгуулын тухайн үе шатны ажлыг гүйцэтгэсэн тухай тайлан, түүнийг

зөвшөөрлийг сунгах тухай шийдвэрийг гаргах эрх бүхий этгээд нь Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болох нь харагдаж байна.

Нөгөө талаас, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайд хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сум, дүүргийн Засаг даргад батлуулахаар хүргүүлнэ (АМтХ 40.1). Сум, дүүргийн Засаг дарга АМтХ-ийн 38.1.3, 38.1.6-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ (АМтХ-ийн 40.3, 38.2). АМтХ-ийн 38.1.3 дахь заалтад зааснаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар АМтХ-ийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах үүрэгтэй. АМтХ-ийн 38.1.1 дэх заалтад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах үүрэг хүлээнэ (АМтХ 38.1.1). АМтХ-ийн 38.1.1 дэх заалтаас үзвэл “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” гэх томъёолол нь “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэх томъёололтой ижил утгыг илэрхийлж буй эсэх нь ихээхэн эргэлзээтэй юм. Учир нь АМтХ-д “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” гэх

хүлээлгэн өгсөн баримт. 22.2. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 22.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтааж тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуулийн 21.1.5-д заасан хугацаагаар сунгаж энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ (Энэ хэсэгт 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан); 22.3.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгамагц энэ тухай мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ. 22.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол төрийн захиргааны байгууллага хугацаа сунгахаас татгалзаж энэ тухай өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

томъёолол нийт хоёр удаа (28.1.3¹⁷, 38.1.1¹⁸) орсон байдаг бол “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэх томъёолол нийт 22 удаа орсон байна. Түүнчлэн АМТХ-ийн 38.1.1 дэх заалтад заасан “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” нь “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” гэж үзэх үндэслэл нь АМТХ-ийн 28.1.3-т зааснаар “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт”-ыг хугацаа сунгуулах хүсэлтэд хавсаргана гэж, 38.1.4 дэх заалтад “энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх” гэж, мөн 39.1.1-д “энэ хуулийн 24.1-д заасан этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах” гэж тус тус хуульчилжээ. Үүнээс дүгнэхэд АМТХ-ийн 38.1.1 дэх заалтын “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” болон “байгаль орчны менежментийн төлөвлөгөө” нь ижил утга бүхий томъёолол гэж ойлгогдохоор байна. Тус хоёр ойлголт, томъёолол ижил гэж үзвэл, анхнаасаа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн боловсруулсан байх ёстой бөгөөд энэ утгаараа тухайн төлөвлөгөөг хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах журамтай. Сум, дүүргийн Засаг даргын хувьд нэгэнт тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн байгаль орчны менежментийн

¹⁷ 28 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

28.1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2-оос доошгүй жилийн өмнө түүнийг эзэмшигч нь төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу хугацаа сунгуулах тухай өргөдөл гаргаж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана: 28.1.3. байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт

¹⁸ 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 38.1.1. тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

төлөвлөгөө нь сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албатай зөвшилцсөний үндсэн дээр боловсруулсан байх тул тухайн шинэчлэн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах учиртай. Хууль тогтоогч энэ утгаараа сум, дүүргийн Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзах тухай нарийвчилсан зохицуулалтыг тусгалгүйгээр нэг талаас хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах үүрэгтэй, нөгөө талаас сум, дүүргийн Засаг дарга тухайн боловсруулсан төлөвлөгөөг батлах чиг үүрэгтэй байхаар зохицуулсан байж болно. Тус маргааны анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт “...Ашигт малтмалын тухай хуулиар байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хүргүүлэх, батлах нь хайгуулын тусгай зөвшөөрөл, эзэмшигч, хайгуулын талбай байршиж буй сумын Засаг дарга нарын хуулиар хүлээсэн үүрэг, зөвхөн тэдгээрийн хооронд үүсэх эрх зүйн харилцаа байх тул хариуцагч Засаг дарга, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Х ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлаагүй шалтгаанаа сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдийн шийдвэрийг биелүүлсэн гэж тайлбарлаж, хуулиар өөрт тухайлан олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь хууль бус байна...” гэжээ. Түүнчлэн сум, дүүргийн Засаг дарга тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан шийдвэр гаргаснаар хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдах үр дагавар шууд үүсэхгүй бөгөөд дээр дурдсанчлан тус чиг үүргийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх юм.

Харин дүн шинжилгээ хийж буй тус маргааны хувьд сумын Засаг дарга АМтХ-ийн 40.1 дүгээр зүйлд заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталсан, эсхүл батлахгүй байгаа эс үйлдэхүй гаргасан нь Захиргааны хэргийн шүүхэд хянагдах захиргааны акт болох эсэх дээр онолын маргаан үүсэх боломжтой. Учир нь сумын Засаг дарга Ү тухайн хэрэг дээр нэхэмжлэгч Х ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах тухай шийдвэр гаргасан гэж тооцвол нэхэмжлэгч Х ХХК-ийн хувьд тухайн хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан тухай эцсийн шийдвэр биш учраас хайгуулын талбайг үргэлжлүүлэн ашиглах эрх, үүрэг шууд үүсэхгүй байх онцлогтой. Дээр дурдсанчлан

хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгах тухай эцсийн шийдвэр буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч Х ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх, үүрэг бүхий харилцаа үүсгэх шийдвэрийг Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргах учиртай.

Гэхдээ уг маргааны хувьд шүүхээс сумын Засаг даргын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах тухай захиргааны шийдвэр нь Захиргааны хэргийн шүүхэд хянагдах захиргааны эрх зүйн акт болох эсэх дээр маргаан үүсээгүй бөгөөд давж заалдах шатны шүүх хуралдааны явцад ЗЕХ-ийн 24 дүгээр зүйлд зааснаар захиргааны байгууллага албан тушаалтан шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай үндэслэл бүрийг нарийвчлан судалж, холбогдох нотлох баримтуудыг цуглуулан, ач холбогдол бүхий бодит нөхцөл байдлыг тогтоосны эцэст түүнд үндэслэж шийдвэр гаргах учиртай гэж үндэслэл хэсэгт тэмдэглэснээс харж болно. Тухайлбал, ЗЕХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт зааснаар тухайн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг захиргааны байгууллага нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно гэсэн нь захиргааны байгууллага гарч болох өргөдөл, гомдлыг урьдчилан тооцоолох боломжит судалгааг бүхэлд нь хийж, тухайн шийдвэрийн улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийн хувьд түүнд нөлөөлж болох бодит нөхцөл байдлыг тодорхой болгох шаардлагатай¹⁹.

ЗЕХ-ийн 37.1 дэх хэсэгт захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно гэж заасан. Захиргааны актад тавигдах үндсэн шаардлага болох захиргааны байгууллагаас гаргасан байх, тодорхой тохиолдлыг зохицуулсан байх, нийтийн эрх зүйн хүрээнд гарсан байх, гадагш чиглэсэн байх, эрх зүйн үр дагавар шууд бий болгосон байх, захирамжилсан шинжтэй байх гэсэн шалгууруудыг

¹⁹ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний) Анхны хэвлэл, УБ., 2017. 135 дахь тал

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

тус хэргийн хариуцагч болох сумын Засаг дарга Ү-ийн байгаль орчны менежментийг батлахаас татгалзсан шийдвэр хангаж байгаа эсэх дээр онолын маргаан үүсэх боломжтой байжээ. Хэрэв аль нэг захиргааны байгууллага захиргааны акт гаргахдаа жишээ нь, иргэнд барилга барих зөвшөөрөл олгохдоо өөр захиргааны байгууллагаас заавал зөвшөөрөл авах шаардлагатай бол нөгөө захиргааны байгууллагын гаргасан акт нь захиргааны актад тооцогдохгүй, харин захиргааны дотоод үйл ажиллагаа болно. Гагцхүү иргэний өргөдөлд татгалзсан хариу өгсөн тэрхүү шийдвэр нь захиргааны актад тооцогдох бөгөөд иргэн зөвхөн татгалзсан хариу өгсөн тэрхүү шийдвэрт гомдол, нэхэмжлэл гаргах боломжтой²⁰. Дүн шинжилгээ хийж буй хэргийн хувьд сумын Засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн байгаль орчны менежментийг баталсан тухай шийдвэр нь АМТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад зааснаар Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зүгээс хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бүрдүүлж ирэх баримтын нэг гэж үзэх үндэслэлтэй учраас захиргааны актад тооцогдохгүй. Энэ утгаараа захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх маргааны зүйлд хамаарахгүй байх тухайд онолын маргаан үүсэх боломжтой байсан. Гэвч тус хэргийн хувьд анхан болон давж заалдах шатны шүүх, түүнчлэн хяналтын шатны шүүх хариуцагч сумын Засаг дарга Ү-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан эс үйлдэхүй нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид шууд эрх зүйн үр дагавар үүсгэж байгаа эсэх буюу захиргааны акт мөн эсэхийг маргааны гол зүйл болгож үзжээр тус шийдвэрийг захиргааны акт гэж үзжээ. Энэ нь аль нэг захиргааны байгууллага захиргааны акт гаргахдаа өөр захиргааны байгууллагаас заавал зөвшөөрөл авах шаардлагатай бол гаргасан акт нь захиргааны актад тооцогдохгүй гэж үзэх онолын үндэслэлийг шүүх авч үзээгүй гэсэн үг юм.

Сумын Засаг дарга байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан шийдвэр гаргаснаар нэхэмжлэгч Х ХХК-ийн хувьд Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны

²⁰ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний) Анхны хэвлэл, УБ., 2017. 177 дахь тал

байгууллагад хандаж тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргахад бүрдүүлбэр дутуу болжээ. Үүний улмаас нэхэмжлэгч Х ХХК-ийн хувьд хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай шийдвэр гаргах эрх бүхий байгууллага болох Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэр, эсхүл тус хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах боломжгүй болж, улмаар АМтХ-ийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусаж, хайгуулын тусгай зөвшөөрөл дуусгавар болно. Тиймээс тэдгээр шийдвэр нь хуульд заасан журмын дагуу гарсан эсэх, нэхэмжлэгч Х ХХК-ийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн эсэх дээр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэхдээ сумын Засаг даргын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан шийдвэр нь хууль журмын дагуу гарсан эсэхийг тогтоолгох боломж байгааг үгүйсгэхгүй юм.

3.2. Нэхэмжлэгч Х ХХК нь цаашид тухайн хайгуулын тусгай зөвшөөрөл сунгагдсан нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжтой эсэх тухай

Тус хэргийг шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолын үндэслэл хэсэгт “...сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр тогтоолоор “Суманд ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа цаашид явуулахгүй байхыг дэмжиж, хурлаас гарсан тогтоол, багуудын иргэдийн гарын үсгийн баталгаажилт бүхий хавсралтууд, холбогдох бусад бичиг баримтыг бүрдүүлж зохих шатны эрх бүхий байгууллагад уламжлах”-ыг, 18 дугаар тогтоолоор “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудалд хориг тавьж ажиллах”-ыг сумын Засаг даргад үүрэг болгосон агуулгатай гарсан байх боловч эдгээр нь шинээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой гарсан гэж үзэхээр...” гэж дурджээ.

Зарчмын хувьд АМтХ-д зааснаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй (АМтХ 24.1.1). Тэгэхээр цаашид тус хэрэг дээр дурдагдаж буй сумын ИТХ-ын 2017 оны “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

асуудалд хориг тавьж ажиллах” тухай 18 дугаар тогтоолын дагуу нэхэмжлэгч Х ХХК-ийн эзэмшиж буй хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон талбай дээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл ирээдүйд олгогдох боломжгүй болсон байна.

Хэдийгээр тус маргаан дээр хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацааг сунгахад шаардлагатай баримт болох сумын Засаг даргын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахаас татгалзсан шийдвэрийг хууль бус гэж үзсэн боловч нэхэмжлэгч Х ХХК-ийн хувьд тухайн хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд үргэлжлүүлэн ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах боломжгүй буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдохооргүй байна. Дүн шинжилгээ хийж буй шүүхийн шийдвэрт энэ талаар тодорхой үндэслэл дурдагдаагүй тул уг асуудалтай холбоотойгоор шүүхийн байр суурийг илэрхийлэн тэмдэглэх боломжгүй байгаа болно.

Дүн шинжилгээ 2. Иргэн С.Доржпүрэвийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох захиргааны хэрэг²¹

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч иргэн С.Доржпүрэв (цаашид нэхэмжлэгч иргэн Х гэх) нь хариуцагч Ашигт малтмалын газрын харьяа ГУУКХ-ийн дарга (цаашид хариуцагч Ү гэх) Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Угдайн дунд ус гэх газарт алтны олборлолт эрхэлж буй Шинэ сансар ХХК (цаашид гуравдагч этгээд А ХХК гэх)-д олгосон 15170А дугаартай тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах шаардлага гаргажээ.

²¹ 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 221 /МА2017/0487, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1288/view>

Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл²²

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй. АМтХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1²³, 25 дугаар зүйлд^{24,25} заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч иргэн Х-ийн хариуцагч Ү-ийн 2009 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 720 тоот тушаалыг хүчингүй болгох, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Угдайн дунд ус гэх газарт алтны олборлолт эрхэлж буй А ХХК-д олгогдсон 15170А тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийджээ. Шийдвэрийн үндэслэл нь:

1. Нэхэмжлэгч иргэн Х нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2016 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн захирамжаар Угдайн дунд ус нэртэй газарт 700 кв газар эзэмшсэн байх боловч уг газар нь мэдээллийн санд ороогүй, цаг хугацааны хувьд гуравдагч этгээд А ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлөөс хойш олгогдсон байх тул үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.
2. Нэхэмжлэгч иргэн Х нь хариуцагч Ү-г Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ гаргаагүй байхад тусгай зөвшөөрөл олгосон гэж маргаж байх боловч АМтХ-ийн 25 дугаар зүйлд нарийвчилсан үнэлгээг өргөдөлдөө хавсаргах талаар заагаагүй, зөвхөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

²² 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, дугаар 255, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3126/view>

²³ 24 дүгээр зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага 24.1.Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй.

²⁴ 25 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам

²⁵ Тус маргаан нь Ашигт малтмалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн өмнө шийдвэрлэгдсэн байх тул Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх заалтын хувьд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “24.2” гэснийг тус тус хассугай. гэсэн хэсэг хамаарахгүй болно. Өөрөөр хэлбэл, тус маргаанд холбогдох Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг нь “Энэ хуулийн 24.1, 24.2-г заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана: ...” гэсэн томъёоллоор хэрэглэгдэж байгаа гэж ойлгох нь зүйтэй.

хийлгэсэн байхыг шаардсан байна. Иймээс Ашигт малтмалын газар нь нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн талаар хяналт тавих үүрэг хүлээхгүй.

3. АМТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар²⁶ ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж зааснаас үзэхэд тухайн орон нутгийн Засаг дарга болон ИТХ хяналт тавих үүрэг хүлээж байна.
4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдээс зөвшөөрөл авах талаар хуульд тусгайлан заагаагүй тул хариуцагчийг “тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн нутгийн иргэдээс нь урьдчилан асууж, тэдгээрт ямар хохирол учрах, тэдгээрийг хэрхэн яаж төлөх талаар тохиролцолгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон” гэж буруутгах үндэслэлгүй байна.
5. Хариуцагч Ү нь гуравдагч этгээд А ХХК-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо АМТХ-ийн 26 дугаар зүйлд²⁷ заасан журмын дагуу ажиллагаа явуулж, дээрх шийдвэрийг гаргасан байх бөгөөд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй байх тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.

Хоёр. Шүүхийн шийдвэрийн агуулга

Давж заалдах шатны шүүхийн магадлал, үндэслэл²⁸

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч Х-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхижээ. Магадлалын үндэслэл нь:

²⁶ 12 дугаар зүйл. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх 12.1.Ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

²⁷ 26 дугаар зүйл. Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа

²⁸ 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 221 /МА2017/0487, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1288/view>

1. Анхан шатны шүүх хариуцагч Ү нь А ХХК-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо АМтХ-ийн 26 дугаар зүйлд заасан журмын дагуу ажиллагаа явуулж, дээрх шийдвэрийг гаргасан байх бөгөөд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй гэж зөв дүгнэсэн байна.
2. Нэхэмжлэгч иргэн Х-ийн “ашигт малтмалын газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гаргуулсан боловч тухайн үнэлгээнд дурдагдсан “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гаргах шаардлагатай” гэсэн шаардлагыг харалгүй шууд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноор нэхэмжлэгчийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөн байтал шүүх энэ нөхцөл байдалд бодитой дүгнэлт өгөөгүй” гэсэн давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй. Учир нь АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахдаа хавсаргах баримт бичгийн жагсаалтыг зааж өгсөн бөгөөд уг жагсаалтад байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэж хавсаргасан байхыг шаардаагүй байна.
3. Нэхэмжлэгч иргэн Х-ийн эзэмшлийн газар болон гуравдагч этгээд А ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд давхацсан болох нь Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн үзлэг хийсэн тэмдэглэлээр тогтоогдож байх боловч гуравдагч этгээд А ХХК нь 2005 оноос эхлэн маргаан бүхий газрыг хайгуулын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эзэмшиж эхэлсэн бөгөөд 2009 онд уг газарт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан болох нь хариуцагчийн хариу тайлбар болон гуравдагч этгээд А ХХК-ийн хувийн хэрэгт авагдсан баримтуудаар, харин нэхэмжлэгч иргэн Х нь маргаан бүхий газарт 2013 оноос эхлэн хаваржиж амьдарсан болох нь нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн үндэслэл болон Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын 2 дугаар багийн Засаг даргын 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн албан бичгээр тус тус тогтоогдож байна.
4. Нэхэмжлэгч иргэн Х, гуравдагч этгээд А ХХК-ийн газар давхцаж байх боловч нэгэнт нэхэмжлэгч иргэн Х-г маргаан бүхий

газарт амьдарч эхлэхээс өмнө гуравдагч этгээд А ХХК-д ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгосон байх тул “маргаан бүхий газарт газар эзэмших хүсэлтийг хэдэн жилийн өмнө гаргасан, тухайн орон нутгийн засаг захиргаа нь асуудлыг шийдвэрлэхгүй байсан... нэхэмжлэгчийн амьжиргаа залгуулдаг эх үүсвэр нь мал аж ахуй бөгөөд түүнийг эрхлэн маллах гол хэрэгсэл нь өвөлжөө, хаваржааны газаргүй, мал маллагаа амьжиргаа залгуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн” гэх нэхэмжлэгчийн гомдлыг хүлээн авах боломжгүй.

5. Маргаан бүхий захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөгүй болох нь хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдож байх тул шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэв.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын агуулга, хэрэглээний тухайд

Тус маргаан нь 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн АМтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулахаас өмнө шийдвэрлэгдсэн маргаан болно. Иймд АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг нь “Энэ хуулийн 24.1, 24.2-г заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана...” гэсэн томъёоллоор хэрэглэгдэж байгааг анхаарах нь зүйтэй. Энэхүү хэрэг дээр маргааны зүйл нь АМтХ-ийн 25.1.7 дахь заалтын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хавсаргахаар хуульчилсан нь байгаль орчны ерөнхий үнэлгээ эсхүл байгаль орчны нарийвчилсан үнэлгээг мөн адил хамааруулсан заалт эсэх тухай юм.

Нөлөөллийн үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж,

түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тогтооно. Нөлөөллийн үнэлгээг ерөнхий үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ гэж ангилах бөгөөд ерөнхий үнэлгээг шинээр байгуулах болон ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, бусад хэлбэрээр байгалийн нөөц баялгийг ашиглах төсөл хэрэгжүүлж эхлэхээс өмнө хийлгэнэ. Харин нарийвчилсан үнэлгээ гэдэг нь ерөнхий үнэлгээний үргэлжлэл ажиллагаа бөгөөд түүнийг ерөнхий үнэлгээ хийсэн дүгнэлтэд тодорхойлон заасан бүх ажлын хүрээнд хийдэг²⁹.

Дүн шинжилгээ хийж буй хэргийн хувьд нэхэмжлэгч иргэн Х нь ашигт малтмалын газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ гаргуулсан боловч тухайн үнэлгээнд дурдагдсан “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гаргах шаардлагатай” гэсэн шаардлагыг харгалзалгүй шууд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байна. Үүнээс үүдэн нэхэмжлэгчийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөн байтал шүүх нөхцөл байдлыг бодитой дүгнээгүй гэж үзжээ. Анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх аль аль нь АМТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахдаа хавсаргах баримт бичгийн жагсаалтыг зааж өгсөн бөгөөд уг жагсаалтад байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хавсаргасан байхыг шаардаагүй байна гэж үзжээ³⁰. АМТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэсэн нь байгаль орчны ерөнхий үнэлгээ, эсхүл нарийвчилсан үнэлгээг мөн адил хийлгэсэн байхыг шаардсан зохицуулалт эсэх тухайд өөр бусад шүүхийн шийдвэрүүд дээр маргасан байдаг. Тухайлбал, Улсын дээд шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд АМТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтад “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэж заасан нь зайлшгүй байгаль орчны нарийвчилсан үнэлгээ байхыг ойлгохгүй бөгөөд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийгдсэн байхад хангалттай

²⁹ О.Амархүү, Монголын орчин цагийн экологийн эрх зүй, хоёр дахь хэвлэл, УБ., 2009, 270-271 дэх тал.

³⁰ 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, Дугаар 255, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3126/view>, 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 221 / МА2017/0487, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1288/view>

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хэмээн шийдвэрлэжээ³¹. Харин тус хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлалд “... байгалийн нөөц ашиглах тохиолдолд урьдчилан байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэх бөгөөд шинжээч байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэрхүү үнэлгээг хийлгэж, баталгаажуулсны дараагаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хавсарган өгөх ба ...” хэмээн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хавсаргах ёстой гэж үзсэн байдаг³². Эндээс бидний шинжилж буй хэргийн хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хавсаргах шаардлагагүй гэж шийдвэрлэсэн нь Улсын дээд шүүхийн байр суурьтай адил гэж дүгнэж болно.

Судлаачийн хувьд АМТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтад заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний баримт бичгийг хавсаргахаар заасан нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байхыг зайлшгүй шаардахгүй бөгөөд байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэсэн байхад хангалттай гэсэн Улсын дээд шүүхийн байр суурьтай санал нийлэхгүй байна. Учир нь байгаль орчны ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээний аль аль нь тухайн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулснаар байгаль орчинд учруулж болох нөлөөлөл, эрсдэл бүхий байдлыг тусгасан байх тул тусгай зөвшөөрөл олгогдохоос өмнө хийгдсэн байх нь байгаль орчны хамгаалал түүний үр нөлөө талаасаа зүйд нийцэх юм. Цаашид энэ талаарх маргааны зүйлийн

³¹ 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 532, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1164/view>. Энэхүү шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг уг судалгааны ажлын захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ 3 гэсэн хэсгээс дэлгэрүүлэн харах боломжтой.

³² 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 0710, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1500/view> Энэхүү шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг уг судалгааны ажлын захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ 3 гэсэн хэсгээс дэлгэрүүлэн харах боломжтой.

хувьд Улсын дээд шүүхийн тогтоолын дээрх жишгээр нэг мөр ойлгож хэрэглэх эсэх дээр байгаль орчны эрх зүйн болон захиргааны эрх зүйн салбарын судлаач нар санал, шүүмжлэлээ солилцох нь байгаль орчны үнэлгээтэй холбоотой маргаан бүхий асуудалд жишиг тогтоход ач холбогдолтой юм.

3.2. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон газартай давхардуулан иргэнд газар эзэмшүүлэх боломжтой эсэх тухайд

Нэхэмжлэгч иргэн Х-ийн хаваржааны газар нь А ХХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий талбайтай давхацсан хэдий ч цаг хугацааны хувьд иргэн Х-д олгогдсон газар эзэмших эрх хожим үүссэн болох нь хэргийн нөхцөл байдлаас харагдаж байна. Нэхэмжлэгч иргэн Х тухайн маргаан бүхий газрыг эзэмших эрхтэй, тэрхүү эрх нь хүчин төгөлдөр байгаа эсэхээс хамааран тус хэрэг дээр нэхэмжлэгч иргэний гаргаж болох нэхэмжлэлийн шаардлага өөрчлөгдөх юм. Тухайлбал, нэхэмжлэгч иргэн Х-ийн газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр гэж үзэх юм бол тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар эзэмшигч хоорондын тухайн газарт нэвтрэн орох, дамжин өнгөрөх, ашиглах талаар гарсан маргааныг шүүх хуульд заасны дагуу шийдвэрлэх учиртай³³. Түүнчлэн иргэн Х-ийн хувьд маргаан бүхий газарт газар эзэмшсэн байх учраас Иргэний хуульд (ИХ гэх) заасны дагуу өмчлөгчийн нэгэн адил эд хөрөнгө түүний эзэмшилд нь байгаа боловч эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн этгээд саад болж байвал уг саадыг арилгуулахаар шаардах эрхтэй гэсэн зохицуулалтыг хэрэглэх боломж бүрдэх юм (ИХ 92.1)³⁴.

Тус хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт гуравдагч этгээд А ХХК-ийн тайлбарт "...нэхэмжлэгч нь 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших эрхтэй болсон. Энэ захиргааны акт нь Газрын тухай

³³ 63 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэх

63.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд тухайн газарт нэвтрэн орох, дамжин өнгөрөх, ашиглах талаар гарсан маргааныг шүүх Иргэний хууль, Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

³⁴ 92 дугаар зүйл. Эзэмших, ашиглах эрх хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдлийг зогсоохыг шаардах 92.1. Шударга эзэмшигчийн эд хөрөнгө түүний эзэмшилд нь байгаа боловч эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн этгээд саад болж байвал уг саадыг арилгуулахаар өмчлөгчийн нэгэн адил шаардах эрхтэй.

хуулийн (ГтХ гэх) 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна гэсэн заалтыг зөрчсөн” гэсэн үндэслэл гаргасан байдаг³⁵. Гэхдээ тус хэргийн шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч иргэн Х-ийн маргаан бүхий газарт газар эзэмших эрхийн хүчин төгөлдөр эсэх дээр маргаан үүсээгүй байна. Иймд иргэн Х-ийн хувьд газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр, түүнчлэн газар эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд хэн нэгэн саад болж байгаа бол тэрхүү эрх зөрчиж буй үйлдэл, үйл ажиллагааг арилгуулахаар шаардлага гаргах эрх нь нээлттэй гэж үзэж болно. Тус хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлалын хянавал хэсэгт “... нэхэмжлэгч, гуравдагч этгээдүүдийн газар давхцаж байх боловч нэгэнт нэхэмжлэгч иргэн Х-ийг маргаан бүхий газарт амьдарч эхлэхээс өмнө гуравдагч этгээд А ХХК-д ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгосон байх тул “маргаан бүхий газарт газар эзэмших хүсэлтийг хэдэн жилийн өмнө гаргасан, тухайн орон нутгийн засаг захиргаа нь асуудлыг шийдвэрлэхгүй байсан ... нэхэмжлэгчийн амьжиргаа залгуулдаг эх үүсвэр нь мал аж ахуй бөгөөд түүнийг эрхлэн маллах гол хэрэгсэл болох өвөлжөө, хаваржааны газаргүй, мал маллагаа амьжиргаагаа залгуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн” гэх нэхэмжлэгчийн гомдлыг хүлээн авах боломжгүй” гэжээ. Гэвч энэ нь нэхэмжлэгч иргэн Х-ийн маргаан бүхий газрыг эзэмших эрхийн гэрчилгээ нь гуравдагч этгээд А ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газарт хожим олгогдсон гэдгийг дурдсанаас бус тухайн маргаан бүхий газартай холбоотой иргэн Х-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээ эсхүл гуравдагч этгээд А ХХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх дээр шүүхээс үнэлэлт өгөөгүй тул нэхэмжлэгч иргэн Х-ийн хувьд газар эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд саад болж буй үйлдлийг арилгуулахаар шаардах эрхийг хязгаарласан зүйл үгүй, нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй гэж үзэж байна.

³⁵ 31 дүгээр зүйл. Газар эзэмшүүлэхэд тавигдах шаардлага ... 31.3. Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.

Дүн шинжилгээ 3. Нэр бүхий хоёр компанид олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг илт хууль бус захиргааны акт болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргуулах тухай³⁶

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч иргэн Б.Болорчулуун, Х.Эрдэнэбилэг, Д.Баттөмөр, Н.Мөнхсайхан, Ю.Бизьяа, Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг дарга нар (цаашид нэхэмжлэгч Х нар гэх) хариуцагч АМГТГКХ (цаашид Ү гэх)-т хандаж “Оргил моунт” ХХК, “Монголын алт” ХХК (цаашид гуравдагч этгээд А, В ХХК гэх) олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг илт хууль бус болохыг тогтоолгох шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл³⁷

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангажээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002 он) (цаашид ЗХХШТХ гэх) 9 дүгээр зүйлийн 9.1.7³⁸, 9.1.9³⁹, ЗЕХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1.6⁴⁰, Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн

³⁶ 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 532, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1164/view>

³⁷ 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, дугаар 448, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3758/view>

³⁸ 9 дүгээр зүйл. Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргах

9.1. Захиргааны байгууллага, албан тушаалтан дараах тохиолдолд захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргана: 9.1.7. захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй;

³⁹ 9.1.9. захиргааны акт өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн.

⁴⁰ 47 дугаар зүйл. Захиргааны акт илт хууль бус болох

47.1. Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6. иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

26.3.2⁴¹, 49 дүгээр зүйлийн 49.10⁴², Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн (цаашид ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ гэх) 4 дүгээр зүйлийн 4.1⁴³, 4.5⁴⁴, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн (цаашид БОНБҮтХ гэх) 4 дүгээр зүйлийн 4.6.3⁴⁵-д заасныг баримтлан нэхэмжлэгч Х нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, хариуцагч Ү-ийн 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 930 дугаар шийдвэр, түүнийг үндэслэн олгосон МҮ-015651 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр шийдвэр, МҮ-020624 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг илт хууль бус болно гэж шийдвэрлэсэн байна. Шийдвэрийн тогтоох хэсгийн үндэслэл нь:

1. БОНБҮтХ-ийн (1998 он) 3 дугаар зүйлийн 3.1.1-д “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой

⁴¹ 26 дугаар зүйл. Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа
26.3. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.1, 26.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ: 26.3.2. хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх

⁴² 49 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх
49.10. Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон маргаан шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа бол шүүхийн шийдвэр гарах хүртэл тухайн тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглоно.

⁴³ 4 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох
4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.

⁴⁴ 4.6. Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.

⁴⁵ 4 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ
4.6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг шинжээч ажлын 12 өдөрт багтаан хийж дараах дүгнэлт гаргана: 4.6.3. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх; Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон атал тус шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт баримтлал болгосон байна.

нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ тогтоохыг” хэлнэ гэж, 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх бөгөөд энэхүү үнэлгээний хүрээнд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоож дүгнэлт гаргана” гэж заасан байна.

2. Харин МҮ2-015651 (маргаан бүхий тусгай зөвшөөрөл) тусгай зөвшөөрлийг 2010 оны 930 тоот шийдвэрээр анх олгоход болон олгосноос хойших хугацаанд хуулийн дээрх нөхцөл шаардлагыг хангасан буюу төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоосон, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг хэрхэн авах талаар эрх бүхий байгууллагын дүгнэлтгүй байгаа нь уг төслийг хэрэгжүүлэхэд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх нутгийн иргэд, ИТХ, Засаг даргын санал өгөх, хяналт тавих, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгаль орчинд учрах хортой нөлөөллийг багасгуулах зэрэг эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэжээ. Өөрөөр хэлбэл, ашигт малтмал олборлох явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөлөл урьдчилан тодорхойлогдоогүй, тодорхойлуулах талаар эрх бүхий байгууллагаас тавьсан нөхцөл шаардлагыг хангаагүй хүсэлтийг хүлээн авч ашигт малтмал ашиглах эрх олгосны улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигч нь удаа дараа олборлолт явуулж иргэдийн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөнд халдсан гэж үзэхээр байна.
3. Иймээс нэхэмжлэгчийн АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7-д “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэж шаардсан нь иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд учирч болох хор хөнөөлийг урьдчилан тогтоох зорилготой байхад түүнийг үл тоомсорлон ноцтой үр дагавар үүсгэсэн шийдвэр гаргасан,

БОНБҮтХ (1998 он)-ийн 3.1.1⁴⁶, 4.1⁴⁷, 5 дугаар зүйлийн 5.4.8⁴⁸-д “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчдийн саналыг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгана” гэж заасны дагуу тэдний эрхээ хамгаалуулах үндсэн баримт бичиг мөн гэж маргаж байгааг үгүйсгэх боломжгүй.

4. ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан “хилийн заагийг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолыг гаргах хүртэл олгохгүйгээр, түдгэлзүүлэх, хүлээх ёстой байсан бөгөөд гол мөрний болон Усны тухай хууль зэргээр нэхэмжлэгчийн эрх ашиг зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүсэхээр байхад түүнийг үл хайхран ашиглалтын тусгай зөвшөөрлийг яаравчлан олгосон нь буруу байна.
5. БОНБҮтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.6-д заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтээр 4.6.3-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх” гэж заасныг хангасан тохиолдолд тухайн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шинжээчид шийдвэрлэх, хэрэв боломжгүй гэж үзсэн тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үндэслэл бүрдэхээргүй буюу хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулах төсөлд тусгай зөвшөөрөл олгох

⁴⁶ 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээ тогтоохыг;

⁴⁷ 4 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ

4.1. Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх бөгөөд энэхүү үнэлгээний хүрээнд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоож дүгнэлт гаргана (Энэ хэсэгт 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон).

⁴⁸ 5 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ

5.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана: 5.4.8. төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн санал (Энэ заалтад 2001 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон).

хууль зүйн үндэслэлгүй болно. Ийм учраас АМтХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д “энэ хуулийн 24.1-д заасан этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө ...байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах” гэж заасан шаардлагыг хуульчилсан байна.

6. АМтХ-ийн 26 дугаар зүйлийн 26.3.2, ГМУБЭУСБГХБОСБГАМ ХАХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.5-д заасныг зөрчин, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг бүрэн хориглосон хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байхад А ХХК-д 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 930 дугаар шийдвэр МҮ 015651 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон нь анхнаасаа хуульд заасан хүрээнд бий болоогүй, эрх зүйн илт алдаатай, захиргааны байгууллага, албан тушаалтан хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчин хуулиас гадуур бүрэн эрхээ хэтрүүлэн гаргасан эрх зүйн акт байх тул ЗХХШтХ-ийн (2002 он) 9 дүгээр зүйлийн 9.1.7-д заасан “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй”, 9.1.9-д заасан “өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн”, ЗЕХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан “иргэн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах, хуульд заасан үндэслэл дугаар зүйлийн 47.1.6-д заасан “иргэн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах, хуульд заасан үндэслэл байгаагүй” үндэслэлээр илт хууль бус захиргааны акт болохыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.
7. Маргаан бүхий МҮ 015651 тоот тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахыг тухайн бүс нутгийн төрийн захиргааны байгууллагын удирдлага болон орон нутгийн иргэд эс зөвшөөрсөөр байхад хариуцагч Ү нь 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр шийдвэрээр АМтХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.3-т заасныг үндэслэн А ХХК-ийн МҮ 015651 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг Б ХХК-д шилжүүлэн бүртгэсэн нь хууль бус байна.
8. МҮ 015651 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон шийдвэр нь анхнаасаа хууль зөрчиж гарсан илт хууль бус акт тул түүнийг шилжүүлсэн шийдвэр нь мөн адил илт хууль бус шинжийг агуулж байгаа илт хууль бус акт гэж үзэв.

9. Тиймээс хариуцагч Ү-ийн 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн илт хууль бус 930 дугаар шийдвэрээр А ХХК-д олгосон МҮ 015651 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг хувааж олгогдсон МҮ 020624 тоот ашиглалтын зөвшөөрөл нь мөн илт хууль бус захиргааны акт болох юм.
10. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрүүдэд тусгагдсан зөрчлүүд арилаагүй байгаа төдийгүй Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэс зураг зүйн шүүлт хийхдээ “хориглосон талбайтай давхцалтай гэдгийг тогтоосон атлаа тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, шинээр тусгай зөвшөөрөл бий болгосон зэрэг захиргааны байгууллагын хуульд үндэслэх зарчмыг зөрчсөн, шийдвэр гаргах ажиллагаа нь анхнаасаа алдаатай байгаа нь илт хууль бус захиргааны актад тооцох үндэслэл болж байна.
11. Нэхэмжлэгч нар 2011 оноос хойш дээрх маргаан бүхий тусгай зөвшөөрлийн ашиглалтын үйл ажиллагааг зогсоох талаар хуульд заасан арга хэмжээнүүдийг авч байсан боловч хариуцагчийн эрх хэмжээг хуулиар хориглосоор байхад хуулиас давж “... Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн заагийг хэсэгчлэн тогтоосон Засгийн газрын тогтоол гараагүй байсан ...” гэх шалтгаанаар бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байхгүй байхад илтэд хууль эрх зүйн үндэслэлгүй хууль бус акт гаргасан. Улмаар дараа дараагийн эрх зүйн зөрчилтэй, илт хууль бус захиргааны акт гаргах үндэс суурийг тавьсанд нэхэмжлэгч нарын зүгээс өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзэж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах нь шударга ёсонд нийцэхгүй бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (цаашид ЗХШХШтХ гэх) 14 дүгээр зүйлийн 14.5-д “Захиргааны байгууллагын гаргасан акт, байгуулсан гэрээ илт хууль бус болох, эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох болон захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нэхэмжлэлд энэ хуулийн 14.1-14.4-д заасан хугацаа үл хамаарна” гэж заасны дагуу нэхэмжлэл хөөн хэлэлцэх хугацаа гаргах тасалдсан гэж үзэхээргүй байна.

Давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, үндэслэл⁴⁹

Давж заалдах шатны шүүхээс гуравдагч этгээд А, Б ХХК нарын давж заалдах гомдлыг хангаагүй бөгөөд үндэслэл нь:

1. Байгалийн нөөц ашиглах тохиолдолд урьдчилан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх бөгөөд шинжээч байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэрхүү үнэлгээг хийлгэж, баталгаажуулсны дараагаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хавсаргаж өгөх ба АМТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1.3-т заасны дагуу өргөдөл, түүнд хавсаргасан баримт нь шаардлага хангаж байгаа эсэхийг хариуцагч нягтлах үүрэгтэй байна.
2. Баянхонгор аймгийн ИТХ 2012 оны 16/02 дугаартай “Аймгийн тусгай хамгаалалттай газрын хилийн цэс шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор А, Б ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбай хамарсан газрыг тусгай хэрэгцээнд авсныг эс зөвшөөрч А, Б ХХК нэхэмжлэл гаргасныг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Улмаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2013 оны 122 дугаар тогтоолын дагуу хүчин төгөлдөр болсон. Үүнээс үзвэл тухайн газар нутаг нь аймгийн тусгай хэрэгцээнд авагдсан байх тул 2015, 2016 онуудад тусгай зөвшөөрлийг шилжүүлэн, талбайн зарим хэсгийг буцаан авч, олгох шийдвэрүүдийг хариуцагч гаргаж байгаа нь хууль бус байх бөгөөд нэхэмжлэгч нарын эрх зөрчигдөөгүй нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэх үндэслэлгүй юм.
3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн (цаашид БОХТХ гэх) 17 дугаар зүйлийн 1.1-д⁵⁰ заасны дагуу сумын ИТХ нутаг

⁴⁹ 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 0710, <http://new.shuukh.mn/zahirgaadah/1500/view>

⁵⁰ 17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих

дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах түүний баялгийг зохистой ашиглах, биелэлтэд хяналт тавих, 2.4-т⁵¹ сумын Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй.

4. Нэхэмжлэгч Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ болон Засаг дарга нар усны сан бүхий газрын эх ундарга, нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор, хуулиар хүлээсэн байгаль орчноо хамгаалах үүргээ хэрэгжүүлэн мөн тухайн суманд оршин сууж байгаа иргэд байгалийн тэнцвэр алдагдахаас сэргийлж нэхэмжлэл гаргасан байхад нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэх үндэслэлгүй юм.
5. Тусгай зөвшөөрлийн дагуу ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг явуулж, үр дагавар үүсгэж байгаа тул тусгай зөвшөөрлийг захиргааны акт биш гэж үзэх боломжгүй юм.
6. ЗЕХ-ийн 47.1-д утга агуулгын илэрхий алдаатай; бичгээр гаргасан захиргааны актыг баталсан байгууллага тодорхойгүй; тухайн захиргааны байгууллага өөрийн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар захиргааны акт гаргасан; захиргааны актыг гүйцэтгэх этгээд тодорхой бус; хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан; иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй; түүнийг бодит нөхцөл байдалд биелүүлэх боломжгүй бол илт хууль бус

⁵¹ 17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ (Энэ хэсэгт 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан) 4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх (Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан)

гэж үзэхээр зааснаас үзэхэд энэ хуулийн зохицуулалт нь сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актын хувьд хэрэглэгдэх ёстой гэж үзэхгүй.

Хоёр. Шүүхийн шийдвэр, үндэслэл

Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, үндэслэл⁵²

Хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ. Шийдвэрийн тогтоох хэсэгт:

Нэг. Анхан шатны шүүхийн шийдвэр, Давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.1.7⁵³, 26 дугаар зүйлийн 26.3.2⁵⁴, 9 дүгээр зүйлийн 49.3⁵⁵, 49.6.1⁵⁶,

⁵² 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 532, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1164/view>

⁵³ 25 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам
25.1. Энэ хуулийн 24.1-т заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана (Энэ хэсгийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан): ... 25.1.7. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; 25.1.8. улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн талбайд энэ хуулийн 24.2-т заасан сонгон шалгаруулалт явуулсан байгууллага, албан тушаалтны шийдвэр

⁵⁴ 26 дугаар зүйл. Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа
26.3. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.1, 26.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ: 26.3.2. хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх;

⁵⁵ 49 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх
49.3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно.

⁵⁶ 49 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх
49.6. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 49.5-д заасан ажиллагааг өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана: 49.6.1. хуульд харшлах шалтгаангүй бөгөөд холбогдох татварыг төлсөн тухай татварын алба тодорхойлолт гаргасан бол тусгай зөвшөөрөл шилжүүлснийг бүртгэж уг тусгай зөвшөөрөлд зохих тэмдэглэгээ хийх (Энэ заалтыг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

55 дугаар зүйлийн 55.1⁵⁷, 55.5⁵⁸ дахь хэсэгт тус тус заасныг баримтлан хариуцагч Ү-ийн 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 930 дугаарт шийдвэр, түүнийг үндэслэн олгосон МҮ-015651 тоот тусгай зөвшөөрөл, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр шийдвэр, 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр олгогдсон МҮ-020624 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг тус тус илт хууль бус болохыг тогтоолгох тухай нэхэмжлэгч Х нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

Хоёр. ЗХХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5, 109 дүгээр зүйлийн 109.2-т тус тус зааснаар Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг даргын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай хэмээжээ. Тогтоолын үндэслэл нь:

1. Анхан болон давж заалдах шатны шүүх маргааны үйл баримтыг зөв дүгнээгүй, холбогдох хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, зарим нэхэмжлэгчдийн эрх зүйн байдлыг буруу тодорхойлсон зэргээс шүүхийн шийдвэр, магадлал, хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагад нийцээгүй байна.
2. Анхан болон давж заалдах шатны шүүхүүд сум, дүүргийн ИТХ-ын байгаль орчныг хамгаалах талаар бүрэн эрхийг тодорхойлсон БОХтХ-ийн 17 дугаар зүйлийн 1, сум, дүүргийн Засаг даргын

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын “хайгуулын” гэсний дараа “болон энэ хуулийн 24.1-; зааснаас бусад тохиолдолд ашиглалтын” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “26.9” гэсний дараа, “60.9-д” гэж, 49 дүгээр зүйлийн 49.6.1 дэх заалтын “шалтгаангүй” гэсний дараа “бөгөөд холбогдох татварыг төлсөн тухай татварын алба тодорхойлолт гаргасан” гэж тус тус нэмсүгэй.

⁵⁷ 55 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгөх

55.1. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг энэ зүйлд заасан журмын дагуу өөрийн хүсэлтээр буцаан өгч болно.

⁵⁸ 55 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгөх

55.5. Энэ хуулийн 55.2-55.4-т заасан шаардлага хангасан бол төрийн захиргааны байгууллага өргөдлийг бүртгэж, тухайн тусгай зөвшөөрөлд зохих өөрчлөлтийг тусгах бөгөөд ингэснээр талбайн тодорхой хэсгийг буцаан өгсөнд тооцно.

байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлын хүрээнд бүрэн эрхийг нь тодорхойлсон мөн зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг дээрх асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй гэж дүгнэсэн нь буруу байна.

3. Учир нь байгаль орчныг хамгаалах талаар тухайн албан тушаалтнуудын бүрэн эрхийг тодорхойлсон дээрх хуулийн зохицуулалтыг шүүхэд төлөөлөн нэхэмжлэлийг гаргах үндэслэл болгосон нь ЗХХШТХ-ийн 1 дүгээр зүйлд заасан "...хуульд заасан болон захиргааны байгууллагаас...", 3 дугаар зүйлийн 3.1.3-д "нэхэмжлэл гэж ... тусгайлан заасан бол ... захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдож үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу захиргааны байгууллага нь хуульд заасан нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Захиргааны хэргийн шүүхэд объектив эрхийн асуудлаар хандах бөгөөд энэ тохиолдолд ИТХ, Засаг дарга ямар чиг үүрэг хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн нь тодорхойгүй байна.
4. МУЗЗНДНТУТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "з"-д⁵⁹ заасан Засаг даргын "... иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах хүрээнд дотоод, гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх" бүрэн эрх нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, дээрх ЗХШХШТХ-д нийцэж хэрэгжих учиртай.
5. Иймээс эрх бүхий захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг нэхэмжлэлд дурдсан үндэслэлээр хууль бусад тооцуулах тухай нэхэмжлэлийг Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нар гаргах эрхгүй гэж үзэж, тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зөв байжээ.

⁵⁹ 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх
29.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 29.1.6. хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар: з/ дотоод, гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;

6. Нэхэмжлэгч Х нар нь “... заавал нарийвчилсан үнэлгээ” байх шаардлагатай гэж маргаж байгаач “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ” авагдсан байгаа нь АМТХ-ийн 25.1.7-д⁶⁰ “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэж заасан шаардлагад нийцжээ.
7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлолтыг шууд явуулах эрх олгодоггүй бөгөөд тусгай зөвшөөрлөөр тогтоогдсон эдэлбэр талбайд уурхай болон боловсруулах үйлдвэр барьснаар олборлолт явуулах эрх үүснэ. 2015 онд Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Б ХХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл бүхий ордын уурхайг хүлээн авахаар томилогдсон Улсын комисс нь “орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх буюу нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй” гэж үзэж, уурхайг хүлээн авах боломжгүй гэж дүгнэснээр гуравдагч этгээд нь үйл ажиллагааг явуулах боломжгүй байжээ. Үүнээс үзвэл Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ анхнаасаа зайлшгүй шаардлагатай гэж үзэхээр биш байна.
8. ЗХХШТХ (2002)-ийн 9 дүгээр зүйлд⁶¹ заасан маргаан бүхий

⁶⁰ 25 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам
25.1. Энэ хуулийн 24.1-т заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана (*Энэ хэсгийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*): 25.1.7. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

⁶¹ 9 дүгээр зүйл. Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргах

9.1. Захиргааны байгууллага, албан тушаалтан дараах тохиолдолд захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргана: 9.1.1. захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай; 9.1.2. бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага, албан тушаалтан нь тодорхойгүй; 9.1.3. захиргааны акт гаргах эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан; 9.1.4. захиргааны актыг гүйцэтгэх субъект тодорхой бус; 9.1.5. хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан; 9.1.6. нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн; 9.1.7. захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй; 9.1.8. захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн; 9.1.9. захиргааны акт өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн. 9.2. Захиргааны актын аль нэг заалт илт хууль бус бөгөөд тухайн заалтгүйгээр захиргааны актын агуулга ойлгомжгүй болоход хүрвэл захиргааны актыг бүхэлд нь илт хууль бус гэж тооцно.

захиргааны актыг илт хууль бус гэж үзэх үндэслэлд хамаарахгүй, хуулиар олгосон эрхийнхээ дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон захиргааны байгууллагын шийдвэрийн улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэхээргүй, анхнаасаа тусгай зөвшөөрөл олгогдох ёсгүй байснаас анх олгосон тусгай зөвшөөрөлтэй хамааралтай бусад захиргааны актууд мөн илт хууль бус гэх нэхэмжлэгч иргэдийн тайлбар үндэслэлгүй.

9. Нэхэмжлэгч иргэн Х нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, харин Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ-ын дарга болон Засаг дарга нарын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.
10. Хяналтын шатны шүүхийн энэ тогтоол нь эрх бүхий этгээдээс хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд маргаан бүхий тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар гаргах шийдвэрт нөлөөлөхгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.
11. Нэхэмжлэгч иргэд нь ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ болон тусгай хэрэгцээнд байгаа газар гэх үндэслэлээр гаргасан тайлбарт шүүх дүгнэлт хийх шаардлагагүй, эдгээр үйл баримттай хамааралтай тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн байдлын асуудлаар захиргааны байгууллагаас гаргах шийдвэрийн тухайд холбогдох хуулиар тусгайлан зохицуулсан, энэ асуудал нь анхнаасаа тусгай зөвшөөрөл олгогдох ёсгүй байсан гэх нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлтэй холбоогүй байна.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон Засаг дарга нарын хувьд нэхэмжлэлд дурдсан үндэслэлээр захиргааны хэргийн шүүхэд хандах боломжгүй гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухайд

Дүн шинжилгээ хийж буй хэргийн хувьд нэхэмжлэгч Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг дарга нар нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх дээр захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэл гэж ойлгох уу, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс

гаргасан нэхэмжлэл гэж ойлгох уу гэдгээс хамаарч үр дүнгийн хувьд ялгаатай.

А. Захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэл гэж үзэх тохиолдолд

Улсын дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхүүд Сум, дүүргийн ИТХ-ын байгаль орчныг хамгаалах талаар бүрэн эрхийг тодорхойлсон БОХТХ-ийн 17 дугаар зүйлийн 1, Сум, дүүргийн Засаг даргын байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлын хүрээнд бүрэн эрхийг нь тодорхойлсон мөн зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг дээрх асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй гэж дүгнэсэн нь буруу гэж дүгнэсэн. Ингэж шийдвэрлэх үндэслэлээ байгаль орчныг хамгаалах талаар тухайн албан тушаалтнуудын бүрэн эрхийг тодорхойлсон дээрх хуулийн зохицуулалтыг шүүхэд төлөөлөн нэхэмжлэлийг гаргах үндэслэл болгосон нь ЗХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлд заасан “Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 3 дугаар зүйлийн 3.1.3-д “нэхэмжлэл гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу захиргааны байгууллага нь хуульд заасан нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Захиргааны хэргийн шүүхэд объектив эрхийн асуудлаар хандах бөгөөд энэ хэргийн хувьд ИТХ, Засаг дарга ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн нь тодорхой биш байна гэж үзжээ.

Ийнхүү Улсын дээд шүүхийн хувьд нэхэмжлэгч Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг дарга нарын гаргасан нэхэмжлэлийн тухайд БОХТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1 ба 17.2 дахь хэсэг нь тэдгээр субъектэд нэхэмжлэл гаргах эрхийг олгоогүй бөгөөд дээр дурдсанчлан ЗХШХШТХ-ийн дагуу ИТХ, Засаг дарга ямар чиг үүрэг хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн нь тодорхойгүй байна гэж шийдвэрлэсэн байна. Судлаачийн хувьд, Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ болон Засаг даргын гаргасан нэхэмжлэлийг ЗХШХШТХ-д заасан захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэл гэж үзэх тохиолдолд нэхэмжлэгч нь ИТХ нь БОХТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1 болон 17.2 дахь хэсэгт заасан нийтийн эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрхэн зөрчигдсөн, эсхүл тус хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд боломжгүйд хүрсэн тухайгаа үндэслэл бүхий гаргаж ирж чадаагүй тул нэхэмжлэл гаргах эрхгүй гэж Улсын дээд шүүхээс шийдвэрлэсэн нь үндэслэлтэй гэж үзэж байна.

Б. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэхэмжлэл гэж үзэх тохиолдолд

ЗХШХШТХ-д “захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг хэлнэ (ЗХШХШТХ 3.1.9) гэж заасан байдаг. Энэ тохиолдолд бидний шинжилж буй хэргийн хувьд сумын ИТХ болон Засаг дарга нь захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх хуулиар тусгайлан олгогдсон эрх бүхий этгээд мөн эсэхээ нотолж чадвал захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд болох юм. БОХТХ-д зааснаар Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцдаг (БОХТХ 17.2.8). Сум, дүүргийн Засаг дарга тус үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх (БОХТХ 17.2.9)-ээр заасан тул Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын хувьд байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд

учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргээ хэрэгжүүлэх үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь хуулиар нээлттэй байна.

Сумын ИТХ болон Засаг дарга нь нэхэмжлэл гаргах эрхтэй болох тухайд тус хэргийн давж заалдах шатны шүүхээс “нэхэмжлэгч Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ болон Засаг дарга нар усны сан бүхий газрын эх ундарга, нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах зорилгоор, хуулиар хүлээсэн байгаль орчноо хамгаалах үүргээ хэрэгжүүлэн мөн тухайн суманд оршин сууж байгаа иргэд байгалийн тэнцвэр алдагдахаас сэргийлж нэхэмжлэл гаргасан байхад нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэх үндэслэлгүй юм” гэж үзсэн.

Түүнчлэн анхан шатны шүүхээс нэхэмжлэл гаргах эрхийн тухайд “... БОХТХ-иар төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хүлээжээ. Түүнчлэн, уг хуулийн 17 дугаар зүйлийн 2-ын 4-т “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх” эрхийг Сум, дүүргийн Засаг дарга, дүүргийн ИТХ-ын болон Засаг даргад олгожээ. ...Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг дарга нар Төрийн захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалуулахаар дээрх хуульд заасан эрхээ эдэлж ЗХШХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан үндэслэл бүхий нэхэмжлэл гаргасан байна” гэж үзсэн.

Үүнээс гадна холбогдох бусад судалгааны бүтээлд дүн шинжилгээ хийж буй хэргийн тухайд Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг дарга нь “нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн буюу байгаль орчныг хамгаалах” агуулгаар нэхэмжлэл гаргасан гэж үзэх боломжтой⁶² талаар

⁶² П.Баттулга, Т.Мөнх-Эрдэнэ, Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, Нээлттэй Нийгэм Форум, Шүүхийн

тэмдэглэсэн болохыг дурдах нь зүйтэй.

Дүгнэвэл, Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын гаргасан нэхэмжлэлийн тухайд БОХТХ-ийн 17.2.9 дэх заалтын дагуу байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг шүүхэд нэхэмжлэл гаргах хэлбэрээр хэрэгжүүлэх боломж нээлттэй учраас ЗХШХШТХ-д заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авах боломжтой байна.

3.2. АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтад заасан байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэсэн нь байгаль орчны ерөнхий үнэлгээ, эсхүл нарийвчилсан үнэлгээний аль болох тухайд

Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримт бичгийн тухай зохицуулсан АМтХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтын шаардлага нь заавал байгаль орчны нарийвчилсан төлөвлөгөө байх шаардлагагүй бөгөөд байгаль орчны ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байхад хангалттай гэсэн тайлбарыг Улсын дээд шүүхээс илэрхийлсэн байна. Шүүхийн жишиг шийдвэр талаас харвал, Улсын дээд шүүхийн дээрх байр суурь нь цаашид АМтХ-д заасан 25.1.7 дахь заалтын агуулга нь зөвхөн байгаль орчинд нөлөөлөх ерөнхий үнэлгээ хийгдсэн байхад хангалттай гэж ойлгон хэрэглэх боломж олгосноороо ач холбогдолтой. Урьд нь АМтХ-ийн 25.1.7 дахь заалттай холбоотойгоор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримт бичигт дан ганц байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэсэн байхад хангалттай юу эсхүл нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай гэсэн ерөнхий үнэлгээний дүгнэлт байгаа тохиолдолд нарийвчилсан үнэлгээг мөн адил хийлгэсэн байхыг шаардах уу гэдэг дээр төсөөтэй маргаан хэд хэдэн удаа үүсэж байсан бол Улсын дээд шүүх тус асуудалд энэхүү тогтоолоороо хариулт өгсөн гэж үзэхээр байна.

Гэхдээ судлаачийн хувьд ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх авах шатанд, эсвэл тусгай зөвшөөрөл авсны дараа гэдгээс үл хамааран тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэсэн байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан

шийдвэрийн шинжилгээ, эмхэтгэл 1, УБ., 2018 он, 61 дэх тал. https://www.forum.mn/res_mat/2018/Shuukhiin_shiidveriin_analiz.pdf

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

л бол захиргааны байгууллагын зүгээс тусгай зөвшөөрөл олгохдоо нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байхыг шаардах нь байгаль орчныг хамгаалахад чиглэсэн урьдчилсан хамгаалалтын нэг хэлбэр болно гэж үзэж байна.

Дүн шинжилгээ 4. Нэр бүхий компаниудын тусгай зөвшөөрлүүдийг цуцлахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгах шаардлага бүхий хэрэг⁶³

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч иргэн Ж.Батбаяр (цаашид нэхэмжлэгч Х гэх) нь нэр бүхий компаниудын ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг цуцлахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газарт (цаашид хариуцагч Ү гэх) даалгах шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Нэхэмжлэгч Х нь “...тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нь 2013-2015 онд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг батлуулаагүй, хайгуул судалгааны ажлыг хийгээгүй. Хариуцагч Ү нь хуулиар тогтоосон дээрх чиг үүргээ хэрэгжүүлээгүй учраас өнөөдөр энэ олон тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компаниуд хууль бус үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр компанийн ашигт малтмалын хайгуул ашиглалтын ажиллагааг хийснээр Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг зөрчсөн дараах үйлдлүүд бий болж байна. Үүнд: Хайгуулын улмаас шороо тоос дэгдэх, бэлчээр талхлагдах, байгаль орчинд бохирдол үүсэх, зэрлэг ан амьтан дайжих, цооногт зэрлэг ан амьтан унаж эрсдэх асуудлууд мөн их гарна. Уул уурхайн нөлөөллөөс болж Алтайн нурууны урд талын хэсэг болох Тос тосон бумбын нурууны эко системийн хэвийн шинж, зэрлэг ан амьтдын биологийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна, мөн ... АМтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1

⁶³ 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 382, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/962/view>

дэх хэсэгт тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална гэж заасан. Хариуцагч Ү нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаагүй, цуцлах үндэслэл байсаар байтал цуцлаагүй эс үйлдэхүй гаргасан” гэж маргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл⁶⁴

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. АМТХ-ийн 33 дугаар зүйл⁶⁵, 56 дугаар зүйлийн 56.1, 56.1.1⁶⁶, 56 дугаар зүйлийн 56.1.5⁶⁷-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Х-ийн

⁶⁴ 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, дугаар 253, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3125/view>

⁶⁵ 33 дугаар зүйл. Хайгуулын ажлын зардлын доод хэмжээ, түүнийг баталгаажуулах
33.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон тухайн талбайн гектар тутамд дараах хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэнэ: 33.1.1. тусгай зөвшөөрлийн 2-3 дахь жилд 0.5 ам.доллар; 33.1.2. тусгай зөвшөөрлийн 4-6 дахь жилд 1.0 ам.доллар; 33.1.3. тусгай зөвшөөрлийн 7-9 дэх жилд 1.5 ам.доллар. 33.1.4. тусгай зөвшөөрлийн 10-12 дахь жилд 10 ам.доллар (Энэ заалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн) 33.2. Хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн геологи хайгуулын ажлын жилийн тайлан болон санхүүгийн тайлан тэнцэлд тулгуурлан төрийн захиргааны байгууллага баталгаажуулна. 33.3.Төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг газар дээр нь шалгана.

⁶⁶ 56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах
56.1. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр цуцална:

56.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон;

⁶⁷ 56.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан (Энэ заалтыг 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан) 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “56.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” гэж

нэр бүхий компаниудын ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг цуцлахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг хариуцагч Ү-д даалгах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ. Шийдвэрийн үндэслэл нь:

1. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авсан нэр бүхий компаниуд нь АМТХ-ийн 33 дугаар зүйлд заасан хайгуулын ажлыг хийж холбогдох тайлангаа төрийн захиргааны байгууллагад ирүүлж байсан болох нь Геологийн алба, Эрдэс баялгийн судалгааны тасгийн мэдээллийн сангаас гаргасан мэдээлэл, компаниудын хайгуулын ажлын тайлан зэргээр нотлогдож байх тул нэхэмжлэгчийн маргаж байгаа нь үндэслэлгүй байна.
2. Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Талбайг нөөцөд авах тухай” 512 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нурууны 652527.98 га газар бүхий талбайг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэх зорилгоор 3 жилийн хугацаагаар нөөцөд авч, хилийн заагийг тогтоосон байх бөгөөд уг нөөцөд авсан талбайд нэхэмжлэгчийн маргаж буй зургаан тусгай зөвшөөрлийн талбай давхцаж байна. Үүнээс үзэхэд уг тогтоолыг гарснаас хойш нэр бүхий таван компани нь тусгай зөвшөөрлийн талбайдаа хайгуулын ажил явуулах боломжгүй байсан байна.
3. Нэхэмжлэгч Х нь нэр бүхий компаниуд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг хийгээгүй нь маягт 7-р нотлогдож байна гэх боловч АМТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахаар заасан тул энэ талаар төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт гараагүй тул цуцлах үндэслэл болохгүй.

өөрчлөн найруулсан байна. Тус маргаан нь 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс өмнөх шийдвэрт хамаарах тул Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дэх заалтыг тус өөрчлөн найруулснаас өмнөх үеийн зохицуулалтаар авч үзэх нь зүйтэй.

4. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 35 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн “Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтох тухай” 91 дүгээр тогтоол зэргээр маргаж буй тусгай зөвшөөрлийн талбайнууд байрлах газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан, компаниуд хайгуулын ажил явуулах боломжгүй болсон, маргаан бүхий газрын үзлэгээр хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай байгалийн төрхөөрөө байгаа болох нь тогтоогдож байх тул нэхэмжлэгчийн “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг зөрчсөн” гэж маргаж байгаа нь үндэслэлгүй байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлал⁶⁸

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын 33 дугаар зүйл, 56 дугаар зүйлийн 56.1, 56.1.1, 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг тус тус гэснийг 31 дүгээр зүйлийн 31.1-д заасныг гэж өөрчилж, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

Хоёр. Шүүхийн шийдвэр

Улсын дээд шүүхийн тогтоол, үндэслэл⁶⁹

Улсын дээд шүүхээс нэхэмжлэгчийн гаргасан хяналтын шатны шүүх хуралдаанд гаргасан гомдлыг хангахгүй орхисон байна. Үндэслэл нь:

1. Давж заалдах шатны шүүхийн магадлал нь ЗХШХШТХ-ийн 120 дугаар зүйлийн 120.3⁷⁰-г заасантай нийцсэн тул магадлалыг хэвээр үлдээв.

⁶⁸ Тус хэргийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 221 магадлал нь шүүхийн шийдвэрийн цахим санд байршаагүй байна.

⁶⁹ 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 382, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/962/view>

⁷⁰ 120 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх болон өөрчлөх 120.3. Анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, эсхүл хууль буруу хэрэглэсэн бол давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь өөрчлөх эрхтэй.

2. АМТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална”, 56 дугаар зүйлийн 56.1-д төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлүүдийг, тухайлбал 56.1.1-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон”, 56.1.5-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан” тохиолдолд цуцлахаар тус тус заажээ. Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд нэр бүхий компаниуд нь АМТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д⁷¹ заасан шаардлагыг хангаж ажилласан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээгээ баталгаажуулж, холбогдох тайлан, мэдээгээ төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн, мөн байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар холбогдох байгууллагын дүгнэлт гараагүй байхад хариуцагчийг эдгээр компаниудын тусгай зөвшөөрлийг цуцлахгүй хууль бус эс үйлдэхүй гаргасан гэж буруутгах үндэслэлгүй. Тодруулбал, төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд л цуцлах үүрэгтэй.
3. Хариуцагч Ү-ийн шийдвэрүүдээр гуравдагч этгээд нарт олгосон тусгай зөвшөөрлийн талбайнууд нь Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний 512 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нурууны тодорхой хэмжээний га газар бүхий талбайг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэх зорилгоор хилийн заагийг тогтоож, 3 жилийн хугацаагаар нөөцөд авсан” талбайтай давхацсан. Улсын Их Хурлын 2016

⁷¹ 31 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах
31.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална.

оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 35 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн “Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай” 91 дүгээр тогтоолоор тус тус эдгээр тусгай зөвшөөрөл бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авчээ.

4. Эдгээр эрх зүйн актын улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нь зөвшөөрөл бүхий талбайдаа 2015 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй, шүүхээс хийсэн үзлэгийн тэмдэглэл, фото зургаар тухайн талбай нь байгалийн төрхөөрөө байгаа нь нотлогдож байхад нэхэмжлэгчээс Үндсэн хуулиар хамгаалагдсан миний “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” зөрчигдсөн гэж маргаж буй нь хууль бус байна.
5. Нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэхгүй байгаа хариуцагчийн буруутай, хууль бус эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдоогүй, хариуцагч төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд цуцлах үүрэгтэй тул шүүхүүдийн нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөгүй гэж дүгнэн, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.3⁷², АМТХ-ийн 31.1-д заасантай нийцсэн байна.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. Нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрх ба зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргах тухай

Энэхүү шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд судлаачийн хувьд маргааны зүйл нь нэхэмжлэл гаргагч иргэн Х нь нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд мөн эсэхээс эхлэх нь зүйтэй гэж үзэж байгаа хэдий ч тус

⁷² 37 дугаар зүйл. Захиргааны акт

37.3. Эс үйлдэхүй гэж иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага хуульд заасан хугацаанд биелүүлээгүй, эсхүл шийдвэрлэхгүй орхигдуулсныг ойлгоно.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хэргийн шүүхийн шийдвэрүүдэд нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрхийг маргааны зүйл болгоогүй. Улсын дээд шүүхээс нэхэмжлэгч иргэн Х-ийн хувьд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд мөн эсэхийг нягталж улмаар нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд биш гэж үзсэн бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдалгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгох юм. Шүүхийн шийдвэрт нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд мөн эсэх дээр маргаан үүсээгүй боловч нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэх дээр үнэлэлт өгсөн байна.

Тодруулбал, тус маргааны гуравдагч этгээд ХХК нараас “... нэхэмжлэгч иргэн Х-ийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөөгүй бөгөөд түүний ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон хайгуулын бүсэд амьдардаг эсэх нь тодорхойгүй. ... нэхэмжлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бодит нөхцөл байдал бүрдээгүй байх тул түүний нэхэмжлэл үндэслэлгүй” гэжээ. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч Х нь маргаан бүхий бүсэд амьдардаг эсэх нь тодорхойгүй байна гэсэн үндэслэл дэвшүүлсэн нь нэхэмжлэгч иргэн Х нь нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд биш гэдгийг илэрхийлэх гэсэн үндэслэл мэт боловч гуравдагч этгээд болон хариуцагч Ү-ийн зүгээс нэхэмжлэгч Х-ийн нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэн тайлбар, үндэслэлээ гаргасан эсэх нь шүүхийн шийдвэрээс харагдаагүй болно.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас “...эдгээр эрх зүйн актын улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нь зөвшөөрөл бүхий талбайдаа 2015 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй, шүүхээс хийсэн үзлэгийн тэмдэглэл, фото зургаар тухайн талбай нь байгалийн төрхөөрөө байгаа нь нотлогдож байхад нэхэмжлэгчээс Үндсэн хуулиар хамгаалагдсан миний “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” зөрчигдсөн гэж маргаж буй нь хууль бус байна” гэж үзсэн. Энэ нь шүүхийн зүгээс нэхэмжлэгч Х-г нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд гэж үзсэн боловч нэхэмжлэгчийн нэхэмжлэлд дурдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөөгүй тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн гэсэн агуулга юм.

Судлаачийн хувьд тус маргаан дээр маргааны гол зүйл нь анхнаасаа нэхэмжлэгч Х нь нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд мөн эсэх, нэхэмжлэгч Х нь өөрийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулахаар нэхэмжлэл гаргаж байна уу, эсхүл хариуцагч Ү захиргааны байгууллага нь хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа, түүнчлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий компаниудын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд бохирдол үүсэх эрсдэл байгаа учраас нэхэмжлэл гаргаж байна уу гэдгийг тодруулах шаардлагатай байсан гэж үзэж байна. Учир нь нэхэмжлэгч Х нь нэхэмжлэлдээ "...хайгуулын улмаас шороо тоос дэгдэх, бэлчээр талхлагдах, байгаль орчинд бохирдол үүсэх, зэрлэг ан амьтан дайжих, цооногт зэрлэг ан амьтан унаж эрстэх асуудлууд мөн их гарна. Уул уурхайн нөлөөллөөс болж Алтайн нурууны урд талын хэсэг болох Гост, тосон бумбын нурууны эко системийн хэвийн шинж, зэрлэг ан амьтдын биологийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна ..." гэж тэмдэглэсэн байна.

ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулга 2016 онд батлагдсантай холбоотойгоор захиргааны акттай холбоотой маргаан буюу тодорхой субъектийн эрхийн зөрчлөөс үүдсэн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, объектив эрхийн (нийтийн эрх ашгийн төлөөлөх, хуулиар тусгайлан маргах эрх олгогдсон этгээд түүнчлэн захиргаа хоорондын нийтийн эрх зүйн хүрээн үүссэн) маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг төрөлжүүлэн зохицуулж өгөх шаардлагатай байна. Субъектив эрхийн зөрчлөөс үүссэн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүх хэрэг үүсгэх үед нэхэмжлэл гаргаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол болон маргаж буй захиргааны үйл ажиллагааны хоорондын шалтгаант холбоо, уялдааг шалгах, уг захиргааны шийдвэр тэрхүү этгээдийн хувьд тухайлсан үйлчлэл бүхий эсэхийг тодруулсны үндсэн дээр захиргааны хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна. Харин объектив эрхийн маргаан буюу захиргааны шийдвэрийн үйлчлэл тодорхой субъектийн эрхийн зөрчил үүссэн эсэхээс үл хамааран хуулиар маргах эрх олгогдсон этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй тохиолдолд шүүх тэрхүү этгээд тухайн асуудлаар маргах, шаардах эрхтэй эсэхийг субъектив хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

адил судалж, шалгах шаардлагагүй байдаг⁷³. Үүнээс үзвэл, дүн шинжилгээ хийж буй маргааны хувьд нэхэмжлэгч иргэн Х-ийн хувьд өөрийн субъектив эрхийн зөрчлийг захиргааны хэргийн шүүхээр хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан уу, эсхүл хариуцагч захиргааны байгууллага Ү-ийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл өгөх үйл явц, түүний дараах хяналтыг буруу дутуу хэрэгжүүлсэн хуулийн зөрчлийг арилгахад чиглэсэн нэхэмжлэлийн шаардлага гаргасан эсэхийг шүүхээс нэн тэргүүнд тодорхой болгон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх нь зүйтэй байжээ.

Мөн ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдсанаар нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол бодитоор зөрчигдсөн зүйл байхгүй хэдий ч зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломж нээлттэй болсонтой холбоотойгоор цаашид зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ямар онцлог үүсэж болох тухай зэрэгт судалгааны бүтээл шаардлагатай гэж үзэж байна.

Дүн шинжилгээ 5. Иргэн Н.Эрдэнийн нэхэмжлэлтэй Баянзүрх дүүргийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг⁷⁴

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч иргэн Н.Эрдэнэ (цаашид Х гэх) нь Солонгос Улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Туулривер контри сайд” ХХК-д (гуравдагч этгээд А ХХК гэх) гольфийн талбайн зориулалтаар газар ашиглуулсан Баянзүрх дүүргийн Засаг даргын 2007 оны 130 дугаар захирамж нь ундны цэвэр усны нөөц дээр газар олгосон байна. Энэ нь Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5, арван зургаадугаар зүйлийн 2, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, 12.8.2, 12.8.3, Ариун цэврийн тухай хуулийн

⁷³ Ц.Цогт “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, Захиргааны эрх зүйн өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2016, 35-37 дахь тал.

⁷⁴ 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Улсын дээд шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 185. <http://old.shuukh.mn/zahirgaahyanalt/1420/view>

5 дугаар зүйлийн 5.1, 5.2, Хүнсний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5, ГтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 6 дугаар зүйлийн 6.2, 6.2.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.2.3, 21 дүгээр зүйлийн 21.5, 21.5.3, Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6, Усны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 31 дүгээр зүйлийн 31.2.1, 31.3, 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт зэрэг 6 хуулийн 20 гаруй заалтыг зөрчсөн. Энэ компани 2007 оны 6 дугаар сарын 5-ны өдөр гэрчилгээ авсан бөгөөд байгуулагдаагүй байхад газрын гэрчилгээ олгосон байна. Ус сувгийн удирдах газраас байцаагч нар ирж энэ компанийн үйл ажиллагааг зогсоосон. Иймд хариуцагч Баянзүрх дүүргийн Засаг даргын (цаашид Ү Засаг дарга гэх) 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 41-д заасан А ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Хариуцагч Ү Засаг дарга нь А ХХК-д 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжаар 50 га газрыг 10 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. Энэ шийдвэрийг гаргахдаа 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9/48 дугаар тогтоолоор батлагдсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, зориулалт гэсэн хоёрдугаар зүйлийн амралт сувилал, аялал жуулчлалын зориулалт бүхий хэсгийн 65 дугаарт Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгонд Туул голын урд, Баянзүрх уулын ар хормойд аялал жуулчлал, гольфийн талбайн зориулалтаар газар олгохоор тусгасныг үндэслэсэн. МУЗЗНДНТУТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.3-т зааснаар Засаг дарга газар ашиглуулах эрхтэй. 2008 оны Нийслэлийн Засаг даргын 386 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг усны эх үүсвэр бүхий газрыг тогтоосон. “Эко Натур” ХХК-ийн гүйцэтгэсэн А ХХК-ийн Спорт, аялал жуулчлалын цогцолбор бааз төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтээр уг хэрэгжүүлэх төсөл нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй гэж дүгнэсэн” гэжээ.

Гуравдагч этгээд А ХХК тайлбартаа “... ЗХХШтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т зааснаар төлөөлөгч томилох ёстой. Нэхэмжлэгч Х нь бусад нэхэмжлэгч нараа төлөөлөх эрх байхгүй. Мөн хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлага гаргаагүй байна. Засаг даргын уг захирамжаар нэхэмжлэгч иргэн Х-ийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

зөрчигдөөгүй. Туул голыг бохирдуулахгүйгээр үйл ажиллагаа явуулах юм. Бидний ашиглах гэж буй газар нь тусгай хамгаалалттай газар нутагт орохгүй. Улсын бүртгэлийн албанаас манай нэрийг өөрчилсөн бөгөөд газар эзэмшихээс өмнө байгуулагдсан...” гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл⁷⁵

ГтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2, 32 дугаар зүйлийн 32.1, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8.2, 12.8.3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч иргэн Х-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч Ү Засаг даргын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 41-д заасан А ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл нь:

1. Нэр бүхий 13 иргэн хариуцагч Ү Засаг даргын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 41-д заасан А ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл шүүхэд анх гаргажээ. Шүүх хуралдаан дээр нэхэмжлэгч иргэн Х бусад нэхэмжлэгч нарыг төлөөлж байгаа гэх боловч түүнд бусад нэхэмжлэгч нараас олгосон итгэмжлэл шүүхэд ирүүлээгүй, бусад нэхэмжлэгч нарын шаардлага адил байгаа тул зөвхөн Х-ийн нэхэмжлэлийн хувьд энэхүү захиргааны хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.
2. Хариуцагч Ү Засаг дарга 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжаар МУЗЗНДНТУтХ-ийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, ГтХ-ийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 3, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн (цаашид ГХОтХ гэх) 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтыг тус тус баримтлан Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Баянзүрх уулын ард А ХХК-д 500,000 м² газрыг аялал жуулчлал, гольфийн талбайн зориулалтаар 10 жилийн хугацаатай ашиглах эрх олгожээ. ГтХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.5-д “Гадаадын

⁷⁵ 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, дугаар 88. <http://judgment.admincourt.gov.mn/uploads/2009.02.19.88%20Erdene.pdf>

хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор, ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно”, 44.8-д “Газар ашиглах тухай хүсэлт гаргах, түүнийг хянаж шийдвэрлэх, газар ашиглах гэрээний агуулгыг тогтоох, түүнийг байгуулахад энэ хуулийн 32, 33.1.28 33.2, 34.1-34.5, 34.6.1-34.6.8, 34.6.10, 34.6.11, 34.7-34.10-г заасан журмыг баримтална гэжээ. Дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “иргэн, аж ахуйн нэгж байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан загварын дагуу гаргана” гэж заасны дагуу өргөдлөө гаргаагүй нь хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараар нотлогдож байна. ГТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заасан байна” гэж заасны дагуу Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 9/48 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн 2007 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Гачуурт тосгонд Туул голын урд Баянзүрх уулын хормойд аялал жуулчлал, гольфийн зориулалтаар 4 га газрыг эзэмшүүлж, ашиглуулж болохоор тусгасан байхад Баянзүрх дүүргийн Засаг дарга 50 га газрыг А ХХК-д ашиглуулахаар шийдвэрлэсэн нь Засаг дарга эрх хэмжээгээ хэтрүүлэн шийдвэр гаргасан гэж үзэх үндэслэлтэй бөгөөд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолд заагдаагүй газарт газар ашиглуулахаар захирамж гаргасан байна. Мөн хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн 12.8.2 “орон сууц, үйлдвэр үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих”, 12.8.3 “байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал тарих, бодис, арга технологи хэрэглэн хөнөөлт шавьж, мэрэгчийг устгах”-ыг ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсэн

заалтыг зөрчсөн болох нь Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2008 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 1172 дугаар захирамжаар томилогдсон шинжээчийн нэгдсэн дүгнэлт “Спорт амралт жуулчлалын цогцолбор баазын үйл ажиллагаа, байршил нь ... хүн амын унд, ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс тогтоох тухай Нийслэлийн Засаг даргын захирамж, Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрүүдийн тэжээлийн мужийн дэглэм зэргийг зөрчиж байна” гэдгээр тогтоогдож байна. Мөн аллювийн ус үеийн төв болон Туул голтой ойролцоох хэсэгт усны шүүрэлтийн хурд хоногт 20-95 метрт байгаа нь Улаанбаатар хотын усан хангамжийн эх үүсвэр болж, Туул гол, түүний газар доорх ус хялбархан бохирдох нөхцөлтэйг харуулж байна” гэсэн дүгнэлтээс үзвэл Баянзүрх дүүргийн Засаг даргын захирамж хууль зөрчсөн байна. Иймд хариуцагч Ү Засаг даргын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 41-д заасан А ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгох нь зүйтэй гэж шүүх дүгнэлээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн иргэн Х-ийн үндсэн эрх хөндөгдсөн байна. Иймээс гуравдагч этгээдийн өмгөөлөгчийн “нэхэмжлэгчийн эрх зөрчигдөөгүй” гэсэн тайлбарыг хүлээн авах боломжгүй байгааг дурдах нь зүйтэй.

Давж заалдах шатны шүүхийн магадлал, үндэслэл⁷⁶

Давж заалдах шатны шүүх хариуцагч Ү Засаг дарга, гуравдагч этгээд нарын давж заалдах гомдлыг хянаж үзээд шүүхийн шийдвэрийн зарим хэсэгт нэмэлт оруулж, шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 88 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтад “ГХОТХ-ийн 1 дүгээр зүйлийн 2, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг” гэж нэмж, бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэв. Магадлалын үндэслэл нь:

⁷⁶ 2009 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 146.
<http://judgment.admincourt.gov.mn/uploads/2009.04.28.146.N.ERDENE.pdf>

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2006 оны 2 дугаар сарын 19-ний 9/48 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн 2007 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгонд Туул голын урд Баянзүрх уулын хормойд Аялал жуулчлал, гольфийн талбайн зориулалтаар 4 га газар гэж заажээ.
2. Гэтэл А ХХК-аас газар ашиглах хүсэлт гаргаагүй байхад хариуцагч Ү Засаг дарга дээрх маргаан бүхий захиргааны актыг гаргаж, тус компанид 50 га газар ашиглуулахаар шийдвэрлэсэн нь газар эзэмшүүлэхэд (ашиглах) тавигдах шаардлага, хүсэлт гаргах, түүнийг хүлээн авч, хянан үзэх талаар ГтХ-ийн 31 дүгээр 31.2, 32 дугаар зүйлийн 32.3-32.5, 33 дугаар зүйлийн 33.4-т заасан зохицуулалтыг, өөрт олгогдсон эрхээ хэтрүүлж, илүү хэмжээтэй газар олгосон нь МУЗЗНДНТУтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг тус тус зөрчсөн болох нь хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдсон байна.
3. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн даргын 2007 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/2113 дугаар тушаалаар БНСУ-ын иргэн Бан Ён Жэ-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай А ХХК-ийг үүсгэн байгуулахыг зөвшөөрч гэрчилгээ олгосныг, улсын бүртгэлд 2007 оны 6 дугаар сарын 6-ны өдөр бүртгэснээс үзвэл, хариуцагч Ү Засаг дарга үүсгэн байгуулагдаагүй, хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсээгүй байсан этгээдэд газар ашиглуулахаар эрх олгосон нь ойлгомжгүй.
4. Хариуцагч Ү нь ГтХ-ийн нөхцөл журмыг зөрчиж, шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн дээд эх үүсвэрийн газар доорх усны нөөц үнэлсэн талбайд А ХХК-д аялал жуулчлал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх” тухай ГтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан зарчимтай нийцээгүй, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэр гаргасан тул нэхэмжлэлийг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй.

Хоёр. Шүүхийн шийдвэр, үндэслэл

Улсын дээд шүүхийн тогтоол, үндэслэл⁷⁷

Улсын дээд шүүхээс гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах үндэслэлгүй гэж үзэн Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 88 дугаар шийдвэр, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдааны 2009 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 146 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангахгүй гэж шийджээ. Тогтоолын үндэслэл нь:

1. ИХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1-д “хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно”⁷⁸, ГХОТХ-ийн 11 дүгээр зүйлийн 2-т “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь бүртгүүлсэн өдрөөсөө эхлэн Монгол Улсын хуулийн этгээд болох бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна”⁷⁹ гэж заасан байхад хариуцагч Ү Засаг дарга тус дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгонд Туул голын урд Баянзүрх уулын хормойд гэсэн байршилд 50 га газрыг үүсгэн байгуулагдаж улсын бүртгэлд бүртгэгдээгүй, дээрх зориулалтаар газар ашиглах хүсэлт гаргаагүй БНСУ-ын иргэн Ван овогтой Юн Жэ-гийн 100 хувийн хөрөнгө оруулалттай А ХХК-д ашиглуулахаар 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамж (холбогдох хэсэг)-ийг гаргасан нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогджээ.

⁷⁷ 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Улсын дээд шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 185. <http://old.shuukh.mn/zahirgaahyanalt/1420/view>

⁷⁸ 26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар 26.1. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

⁷⁹ 11 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь бүртгүүлсэн өдрөөсөө эхлэн Монгол Улсын хуулийн этгээд болох бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна (Энэ хуулийг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон).

2. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 9/48 дугаар тогтоолоор батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зөвхөн 4 га газрыг дээрх байршилд аялал жуулчлал, гольфийн талбайн зориулалтаар олгохоор тусгасныг хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтан анхаараагүй байна.
3. Хариуцагч Ү Засаг даргын 130 дугаар захирамжийн А ХХК-д холбогдох заалт ГтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2⁸⁰, 32 дугаар 32.3-32.5⁸¹, 33 дугаар 33.4⁸², МУЗЗНДНТУтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-т⁸³ заасныг зөрчсөн учир маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгож, нэхэмжлэгч иргэн Х-ийн нэхэмжлэлийг

⁸⁰ 31 дүгээр зүйл. Газар эзэмшүүлэхэд тавигдах шаардлага

31.2. Хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдсан байна.

⁸¹ 32 дугаар зүйл. Газар эзэмших тухай хүсэлт гаргах

32.3. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараах зүйлийг тусгана: 32.3.1. аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, харьяалал, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 32.3.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг; 32.3.3. газар эзэмших зориулалт, хугацаа. 32.4. Энэ хуулийн 32.2, 32.3-г заасан баримт бичгийг хавсаргасан хүсэлтийг хүлээн авмагцаа сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу бүртгэнэ. Бүртгэлд хүсэлтийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутаар тэмдэглэх бөгөөд энэ тухай тодорхойлолтыг хүсэлт гаргасан этгээдэд гаргаж өгнө (Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан). 32.5. Хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба нягтлан хянаж, шаардлага хангаагүй бол энэ талаарх үндэслэлийг хүсэлт гаргагч этгээдэд мэдэгдлээр өгч, бүртгэлээс хасна.

⁸² 33 дугаар зүйл. Газар эзэмшүүлэх шийдвэр гаргах

33.4. Хорих ангийн гадна хориотой бүс болон аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглоно (Энэ хэсэгт 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан). 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн “Аймаг” гэснийг “Хорих ангийн гадна хориотой бүс болон аймаг” гэж өөрчилсүгэй” гэжээ.

⁸³ 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх

29.2. Засаг дарга эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хангаж шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал үндэслэлтэй болжээ.

4. Давж заалдах шатны шүүх, ГХОТХ-ийн 11 дүгээр зүйлийн 2, 15 дугаар зүйлийн 1 гэсэн заалтыг шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт баримтлахаар зүйлчлэлд нэмэлт оруулсан нь буруу биш.
5. Шүүхүүд хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчөөгүй, ГТХ болон ГХОТХ-ийн холбогдох заалтуудыг зөв тайлбарлан хэрэглэсэн байх тул гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах үндэслэлгүй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. Нэхэмжлэгч иргэн Х-ийн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн тухайд

Энэхүү хэрэг дээрх нэхэмжлэгч иргэн Х-ийн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх үүссэн эсэхтэй холбоотой асуудлыг авч үзье. Уг маргаан нь 2016 оны ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө буюу 2002 оны ЗХХШТХ хүчин төгөлдөр үйлчилж байх үед хамаарах хэрэг юм. 2002 оны ЗХХШТХ-д нэхэмжлэл гэдгийг иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг (ЗХХШТХ 3.1.4). Энэхүү хууль нь нэхэмжлэгч зөвхөн өөрийн эрх, хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах зарчимд үндэслэгдэх ба бусдын эрх, хууль ёсны эрх ашиг зөрчигдсэн гэдэг үндэслэлээр нэхэмжлэл гаргах зарчим байдаггүй⁸⁴.

Дээрхээс үзэхэд, нэхэмжлэгч иргэн Х-ийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн тохиолдолд л захиргааны хэргийн шүүх тухайн хэргийг хянан хэлэлцэх үндсэн зарчимтай байтал уг хэрэг дээр нэхэмжлэгч иргэн Х-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн эсэх нь тодорхой бус байхад захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулснаараа онцлогтой юм.

⁸⁴ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (шүүгчид зориулсан гарын авлага), УБ., 2004 он, 55 дахь тал.

Нэхэмжлэгч иргэн Х нь анхнаасаа нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд биш болох тухайд хариуцагч болон гуравдагч этгээдийн зүгээс үндэслэлээ илэрхийлсээр байсан. Тухайлбал, хариуцагч Ү Засаг дарга давж заалдах гомдолдоо: Баянзүрх дүүргийн Засаг даргын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжийн А ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулахаар гаргасан нэхэмжлэлийг нэр бүхий 13 иргэн гаргасан боловч шүүх хуралдаанд зөвхөн иргэн Х өмгөөлөгчийн хамт бусад этгээдээс итгэмжлэл авалгүйгээр оролцсон. Гэтэл шүүх нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн шаардлага адил байна гэсэн үндэслэлээр хэргийг хянан хэлэлцсэн нь ЗХХШТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2-т заасныг, мөн тус захирамжаар “Туулривер контри сайд” ХХК-д газар эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн нь нэхэмжлэл гаргасан дээрх иргэдийн хууль ёсны эрх ашгийг ямар байдлаар хохироож, зөрчсөн нь тодорхой бус байхад захиргааны хэрэг үүсгэсэн нь холбогдох хууль тогтоомжуудад заасныг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч давж заалдах гомдолдоо: Анхан шатны шүүх нэхэмжлэгч Х нарын нэр бүхий 16 хүний нэхэмжлэлтэй хэргийг хянан хэлэлцэхдээ иргэн Х-д төлөөлүүлэгчээс итгэмжлэл олгогдоогүй байхад шүүх хэргийг хянан шийдвэрлэсэн нь ЗХХШТХ, ИХ-ийн холбогдох заалтуудыг зөрчжээ.

Анхан шатны шүүхэд гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар хариу тайлбартаа: “ЗХХШТХ-ийн 22.2-т зааснаар төлөөлөгч томилох ёстой. Х-д бусад нэхэмжлэгч нараа төлөөлөх эрх байхгүй байна. Х гомдол гаргах эрхтэй этгээд мөн үү биш үү, ЗХХШТХ-ийн 12-р зүйлд заасан шаардлага гаргаагүй эрхгүй этгээд байна. Уг захирамжаар Х-ийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдөөгүй. Эрхийг нь Засаг даргын захирамж хөндөөгүй...” гэх зэргээр хариуцагч болон гуравдагч этгээдийн зүгээс нэхэмжлэгч иргэн Х-ийг нэхэмжлэл гаргах эрхгүй хэмээн үзэж байсан.

Харин шүүхийн зүгээс нэхэмжлэгч иргэн Х-ийн нэхэмжлэл гаргах эрхийн тухайд үндэслэл бүхий тайлбарыг хийгээгүй бөгөөд хариуцагч Ү Засаг даргын маргаан бүхий захирамжийн улмаас нэхэмжлэгч иргэн Х-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тэр дундаа түүний ямар субъектив эрх зөрчигдсөн, захирамжийн улмаас түүнд ямар бодит хохирол учирсан, захирамж нь нэхэмжлэгч иргэн Х-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой хэрхэн яаж холбогдож байгаа талаар шүүх дүгнэлт

хийгээгүй байна⁸⁵. Тус тохиолдолд нэхэмжлэгч иргэн Х нь тус газарт газар эзэмших болоод өмчлөх эрхийн гэрчилгээгүй тул нэхэмжлэл гаргах эрхийг тус захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх нь зөрчигдсөн гэж үзэх юм бол нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргах эрхгүй болох юм. Харин хариуцагч Засаг дарга Ү нь Улаанбаатар хотын хүн амын ундны усны төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн нөөц бүхий талбайд газар ашиглах эрх олгож “хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд харшилсан” шийдвэр гаргасан байна. Мөн тус хууль бус шийдвэрийн үндсэн дээр дээрх хуулийн этгээд нь тус газарт үйл ажиллагаа явуулж улмаар үүний улмаас иргэдийн, түүний дотор нэхэмжлэгч иргэн Х-ийн ундны усны ус бохирдох, ширгэх буюу “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх” нь зөрчигдөхөөр байгаа тул иргэн Х-ийн нэхэмжлэлийг “дээрх захирамжийн улмаас түүний хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн” хэмээн хүлээж авах нь зүйтэй гэж зарим судлаач тэмдэглэсэн байдаг⁸⁶.

Дээрхээс нэгтгэн дүгнэвэл, 2002 оны ЗХХШтХ хүчин төгөлдөр үйлчилж байх үед буюу Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгч нь зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах зарчимд үндэслэгдэж байсан үед Захиргааны хэргийн шүүхээс хариуцагч Засаг дарга Ү нь Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн нөөц бүхий талбайд газар ашиглуулах шийдвэр гаргасан нь “хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх” тухай ГтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан зарчимтай нийцээгүй буюу маргаан бүхий акт нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байна гэж шийдвэрлэсэн. Энэ нь захиргааны хэргийн шүүхээс тухайн тусгай зөвшөөрөл бүхий гольфийн талбай нь нийт хүн амын ундны усны эрүүл ахуйд хамааралтай буюу нийтийн ашиг сонирхол зөрчигдөх үр дагавартай байх тул дан ганц нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол бус нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой шийдвэр болсон гэж дүгнэхээр байна.

⁸⁵ Ц.Цогт “Байгаль орчныг хамгаалах асуудалд захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо”, Захиргааны эрх зүй, өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2016 он, 27 дахь тал.

⁸⁶ Ц.Цогт “Ашигт малтмалын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх”, Захиргааны эрх зүй, өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2016 он, 243-244 дэх тал.

ХОЁР. ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ АСУУДЛААР НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Дүн шинжилгээ 1. “Онги голынхон хөдөлгөөн” ТББ-ын
нэхэмжлэлтэй Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд
холбогдох шүүхийн маргаан⁸⁷**

Нэг. Хэргийн агуулга:

Нэхэмжлэгч “Онги голынхон хөдөлгөөн” ТББ (цаашид хариуцагч Х ТББ гэх) 2001 онд байгуулагдсан бөгөөд Онги гол түүний сав газруудын голын урсцын талаар судалгаа хийх, бүс нутгийн иргэдийн дунд голын эргийн дагуу байгаль хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлдэг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага (цаашид НҮТББ гэх) бөгөөд хуульд заасан эрхийнхээ хүрээнд нийтийн эрх ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргажээ.

Нэхэмжлэгчийн зүгээс “Баярсгоулд” ХХК нь (цаашид гуравдагч этгээд А ХХК гэх) нь тусгай зөвшөөрлөө өөрчлөн дахин эзэмшсэн гэх үндэслэлээр Бөөрөлжүүтийн голын онцгой хамгаалалтын бүс дотор буюу голын эргээс 8-12 метрийн зайд ашигт малтмал олборлолт хийж голын голдирлыг эвдэж, урсцыг нь багасгаж байгалийн тэнцлийг асар ихээр алдагдуулсаар байна гэж үзэж буй бөгөөд хараа хяналтгүй уул уурхай, хууль зөрчсөн ашигт малтмалын олборлолтоос Бөөрөлжүүтийн сав газарт асар их бохирдол үүсэж, байгалийн тэнцэл ихээр алдагдаж иргэдийн “... эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах...” эрхийг зөрчиж байгаа хууль зөрчсөн үйлдлийг зогсоож байгаль орчинд учруулсан хохирлыг тооцон гаргаж, олон нийтэд мэдээлэхийг хүссэн албан бичгийг 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны сайдад хандан Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг

⁸⁷ Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 23 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1696/view>

Бөөрөлжүүтийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд болон тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчинд учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлж өгөхийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн байна.

БОАЖЯ-ны зүгээс манай байгууллагын хүсэлтийн хариут Өвөрхангай аймгийн Уянга сумын Засаг дарга Б.Доржтоогоо танаа гэсэн толгойтой, хувийг Онги голынхон хөдөлгөөн ТББ-д гэсэн хэлбэрээр ирүүлжээ.

Иймд БОАЖЯ-аас Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Бөөрөлжүүтийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлэхээс татгалзаж сумын Засаг даргын эрх хэмжээний асуудал мэтээр хандаж байгаа шийдвэрийг хууль бус гэж үзсэн учир уг шийдвэрийг хууль бусд тооцуулах, учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлэхийг БОАЖЯ (цаашид хариуцагч Ү гэх)-д даалгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргасан байна.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд

2.1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 128/ШШ2018/644 тоот шийдвэр⁸⁸

Анхан шатны шүүхийн зүгээс хариуцагч Ү нь байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах зэргээр бодлогын түвшинд шийдвэр гаргадаг захиргааны байгууллага бөгөөд уг чиг үүрэгт буюу байгаль орчныг хамгаалах гэдэгт хохирол тооцох үйл ажиллагаа хамаарна гэж тайлбарлаж байгааг хүлээн авах боломжгүй байна гэж дүгнэжээ.

⁸⁸ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэр, дугаар 644 <http://new.shuukh.mn/zahirgaanhan/5298/view> Шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан тус шүүхийн шийдвэрийн огноо нь 2018 оны 9 дүгээр сарын 16 гэсэн бичиглэлтэй орсон байгаа нь алдаатай байна гэж үзэх үндэслэлтэй. Учир нь тус хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдааны магадлал, тогтоолд 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гэсэн огноотойгоор тэмдэглэсэн байх тул энэхүү дүн шинжилгээнд анхан шатны шүүхийн шийдвэрийн огноог 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гэж үзсэн болно.

Мөн шүүхийн зүгээс дээрх асуудал нь аймаг, сумын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг хэмээн дүгнэсэн байна. Дээрх дүгнэлтийн хүрээнд шүүхээс БОХТХ-ийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7⁸⁹, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2⁹⁰, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4⁹¹, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4⁹², 26 дугаар зүйлийн

- ⁸⁹ 3 дугаар зүйл. Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томьёо
2. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 7/ “байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна (Энэ заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн)
- ⁹⁰ 15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 2/ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах (Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан).
- ⁹¹ 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх
2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх (Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан).
- ⁹² 17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх
2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх (Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан).

1 дэх хэсэг⁹³, 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1⁹⁴, 49 дүгээр зүйлийн 6⁹⁵, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3⁹⁶, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.6, 7.1.13⁹⁷ дахь заалтад заасныг тус тус баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

2.2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 221/МА2018/0630 тоот магадлал⁹⁸

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Давж заалдах гомдлын агуулга: “...Анхан шатны шүүхийн шийдвэрийг Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь хуульд үндэслэсэн байна гэсэн зохицуулалтыг зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн нотлох баримтыг буруу үнэлсэн, ...анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт баримталсан хуулийн заалтуудыг хэрэглэх ёсгүй байсан үзэж байгаа учраас нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй

⁹³ 26 дугаар зүйл. Байгаль орчны хяналт

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

⁹⁴ 27 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх, үүрэг

1. Улсын байцаагч дараах эрхтэй байна: 1/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

⁹⁵ 49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх

6. Энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 1, 2 дахь заалтад заасан хохирлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх авсан мэргэжлийн байгууллагаар хөлсийг төлж тооцуулна.

⁹⁶ 3 дугаар зүйл. Яам, түүний чиг үүрэг

3.3. Яам нь Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

⁹⁷ 7 дугаар зүйл. Яамны нийтлэг эрхлэх асуудал

7.1. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг ажил эрхэлнэ: 7.1.6. аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; 7.1.13. хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

⁹⁸ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн магадлал, дугаар 221/МА2018/0630 <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2544/view>.

болгохдоо хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байна” гэжээ.

Давж заалдах шатны шүүхээс “Байгаль орчинд учирсан хохирлыг тооцох чиг үүргийн тухайд БОАЖЯ нь хохирол тооцох аргачлалыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих; харин аймаг, сумын Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч нь байгаль орчинд учирсан хохирлыг тооцон гаргах ажлыг зохион байгуулж, нөхөн төлбөр ногдуулах, хохирлыг нөхөн төлүүлэх үүрэгтэй байна. Нэгэнт хариуцагч Ү-д Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Бөөрөлжүүтийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд учирсан хохирлыг тооцон гаргах бүрэн эрхийг хуулиар олгоогүй мөн тус хамгаалалтын бүсэд ямар хохирол учирсан нь тодорхойгүй энэ нөхцөлд БОАЖЯ-ыг энэ талаар нийтэд мэдээлэхийг даалгах боломжгүй” хэмээн магадлалынхаа үндэслэлийг тайлбарлаж, нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

2.3. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн шүүх хуралдааны 23 тоот тогтоол⁹⁹

Улсын дээд шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүх хуралдааны магадлалыг тус тус хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангаагүй. Хяналтын гомдлын агуулга: “Давж заалдах шатны шүүх ЗХШХШТХ-ийн 118 дугаар зүйлийн 118.3-т заасан үүргээ биелүүлээгүй учир Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 221/МА2018/0630 тоот магадлалыг хүчингүй болгуулах тухай” гэжээ.

Улсын дээд шүүхээс “БОАЖЯ нь хохирол тооцох аргачлалыг баталж, түүний хэрэгжилтийн байдалд хяналт тавих, аймаг, сумын Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч нь аргачлалыг хэрэгжүүлэх, байгаль орчинд учирсан хохирлыг тооцон гаргах ажлыг зохион байгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх үүрэгтэй байх бөгөөд хариуцагч Ү-д хохирол тооцон гаргах, түүнийг мэдээлэх бүрэн эрхийг хуулиар олгоогүй тул нэхэмжлэлийн шаардлагыг хангах үндэслэлгүй, энэ

⁹⁹ Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 23 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1696/view>

талаарх анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт зөв байна. Нэхэмжлэгчээс “Ү нь БОХТХ-ийн 15 дугаар зүйлийн 1-ийн 1, 2¹⁰⁰-т заагдсан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй учраас Бөөрөлжүүтийн голын хамгаалалтын бүсүүдэд хохирол учирсан...уг хохирлыг тооцон гаргах үүрэг нь хариуцагчид хуулиар олгогдсон” гэх агуулгаар маргасан ч байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг ажлыг хариуцан зохион байгуулах эрх бүхий этгээдийг мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2¹⁰¹-т тухайлан нэрлэн заасан,

¹⁰⁰ 15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах (*Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан*) 2/ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах.

¹⁰¹ 16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 2/ нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 3/ байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх; 4/ нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; 5/ нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах; 6/ аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж томилох, чөлөөлөх. 7/ нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; 8/ нөхөрлөлийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг

нэхэмжлэгчийн “...үнэлгээ хийлгэхийг даалгах...” шаардлагын хүрээнд хариуцагчийг хууль бус эс үйлдэхүй гаргасан хэмээх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангах боломжгүй юм. Дээрх үндэслэлүүдээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв” гэжээ.

Гурав. Дүн шинжилгээ

Тус маргааны үндсэн зорилго нь байгаль орчныг нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх болон иргэдийг мэдээллээр хангахад чиглэгдсэн чухал ач холбогдол бүхий маргаан байсан хэдий ч хууль хэрэглээний асуудлаас үүдэн маргааны үндсэн зорилго хангагдаагүй байна. Тухайлбал, тухайн маргааны хариуцагчийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх хууль зүйн боломжгүй хэмээн шүүхээс дүгнэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Бүх шатны шүүхийн шийдвэрийн хувьд ямар нэгэн байдлаар өөрчлөгдөөгүй бөгөөд хууль хэрэглээний асуудалд алдаа гараагүй хэмээн шүүхээс дүгнэсэн хэдий ч ЗЕХ-ийн тусгай зарчим болох шуурхай тасралтгүй байх зарчмын хүрээнд тус нэхэмжлэлийг хэлэлцэн шийдвэрлэх бодит боломж байсан эсэхэд шүүх дутуу дүгнэлт өгсөн байх магадлалтай байна.

Шүүхийн зүгээс хариуцагч Ү нь байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах зэргээр бодлогын түвшинд шийдвэр гаргадаг захиргааны байгууллага бөгөөд уг чиг үүрэгт буюу байгаль орчныг хамгаалах гэдэгт хохирол тооцох үйл ажиллагаа хамаарна гэж тайлбарлаж байгааг хүлээн авах боломжгүй байна гэж дүгнэжээ.

Мөн шүүхийн зүгээс дээрх асуудал нь аймаг, сумын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэг хэмээн дүгнэсэн байна.

зохион байгуулах; 9/ тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайланг ИТХ-д хэлэлцүүлэх; 10/ байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.

Шүүх тус хуулийг хэрэглэхдээ хангалттай хэмжээнд үндэслэлтэйгээр тайлбарлаагүйгээс шалтгаалан хуулийг хэт явцууруулан дүгнэлт гаргасан байх магадлалтай. Тухайлбал, БОХТХ-д заасны дагуу Байгаль орны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд байгаль орчныг хамгаалах чиг үүргийг хүлээдэг бөгөөд уг хуульд заасан хамгаалах чиг үүрэгт байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тогтоох, нөхөн төлүүлэх чиг үүрэг агуулгын хувьд бүрэн хамаарч байх ёстой. Нөгөө талаар, тус хуульд аймаг, сумын засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт уг асуудлыг хамруулсан байх хэдий ч төрийн захиргааны төв байгууллагын хувьд салбарын асуудлаа нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийнхээ хүрээнд тус маргаанд хариуцагч байх боломжтой эсэх тал дээр хангалттай хуулийн үндэслэл бүхий тайлбарыг хийгээгүй байна. Захиргааны байгууллага хариуцах харьяаллын хувьд ЗЕХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Тухайн асуудал хэд хэдэн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамаарч байвал анхан шатны захиргааны байгууллага, ижил түвшний захиргааны байгууллагын чиг үүрэгт хамаарч байвал анх хүлээн авсан захиргааны байгууллага өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлыг шийдвэрлэнэ” гэж заажээ. Үүнээс харахад, нэг асуудлыг хоёр байгууллага хариуцах тохиолдолд анхан шатны байгууллага буюу тухайн байгууллагын нэг бүтцийн анхан шатны нэгжийн хувьд хариуцахаар хуульд заасан бөгөөд зарим тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага буюу яам эсхүл төрийн захиргааны байгууллага буюу агентлагийн чиг үүргүүдэд давхар хамаатуулсан асуудлын хувьд анхан шатны нэгжийнхээ хувьд агентлаг хариуцах боломжтой байдаг. Гэвч тус маргааны хувьд уг зохицуулалтыг ашиглах боломжгүй бөгөөд Засаг даргын хувьд МУЗЗНДНТУТХ болон Засгийн газрын бүтцийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиудад заасны дагуу Засгийн газрын харьяа байгууллага биш юм. Түүнчлэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хувьд мөн дээрх бүрэлдэхүүнд хамаардаггүй Ерөнхий сайдын харьяа агентлаг гэх эрх зүйн статустай байгууллага юм.

Гэтэл шүүхийн зүгээс дээрх асуудлаар хангалттай үндэслэл бүхий тайлбарыг хийгээгүй байна. Уг асуудлын хувьд хуулиар хариуцах субъектийг өөр байдлаар тодорхойлсон байтал шүүхийн зүгээс яагаад нэг байгууллагад харьяалуулах талаар дүгнэлт хийгээгүй гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, БОАЖЯ нь байгаль орчинд учирсан хохирлыг

тооцон гаргах, нөхөн төлүүлэх асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээх, уг үүргээ бүрэн эрхийнхээ хүрээнд холбогдох байгууллагаар гүйцэтгүүлэх эрхийг хуулиар олгосон байна.

Шүүхийн шийдвэрийн ач холбогдол: Маргааны хувьд хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр бодит үр дүн гарахуйц асуудлыг хөндсөн хэдий ч шүүхийн шийдвэрийн дагуу бодит, хэрэгжихүйц, үр нөлөө бүхий шийдвэр гараагүй байна.

Судлаачийн байр суурь, шийдвэрт өгөх үнэлгээ: Судлаачийн хувьд бүх шатны шүүхийн шийдвэртэй хууль хэрэглээний асуудлаар санал нийлэх боломжгүй бөгөөд шүүхийн зүгээс хуулийг хэт явцууруулан тайлбарласан, ЗЕХ-ийн үндсэн зарчмыг баримтлаагүй, түүнчлэн нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалсан нэхэмжлэлийг ЗХШХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй ... гэх захиргааны нотлох ажиллагааг дутуу хийн шийдвэрлэсэн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхийн зүгээс хариуцагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, тухайн маргаанд хариуцагч болох эсэхэд дүгнэлт хийхдээ тухайн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгт нэхэмжлэлийн шаардлага хамаарч буй эсэхийг тодруулах, тайлбарлах үүрэгтэй бөгөөд уг үүрэг захиргааны нотлох чиг үүрэгт хамаарах юм.

Дүн шинжилгээ 2. “Хөвсгөл далайн эзэд” ТББ, иргэн Г.Даваачулуун, Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн даргад холбогдох шүүхийн маргаан¹⁰²

Нэг. Хэргийн агуулга

“Хөвсгөл далайн эзэд” ТББ, иргэн Г.Даваачулуун, Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав нарын зүгээс (цаашид нэхэмжлэгч Х ТББ, иргэн Х1 нар гэх) “Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын (цаашид хариуцагч Ү гэх) 2001 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 760

¹⁰² Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн тогтоол, дугаар 118, <http://www.shuukh.mn/zahirgaahyanalt/417/view>

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

дугаар шийдвэрийн “Талст маргад” ХХК-д (гуравдагч этгээд А ХХК гэх) 3999 А тоот, 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 155 дугаар шийдвэрийн А ХХК-д 11428А тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлүүдийг олгосон хэсгийг илт хүчин төгөлдөр бусад тооцуулах, ГУУКХ-ийн даргын 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 1996 дугаар шийдвэрээр А ХХК-д олгогдсон ашигт малтмалын хайгуулын 12633Х-12638Х тоот нийт 6 тусгай зөвшөөрлийг АМТХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.4-т заасны дагуу цуцлахыг хариуцагчид даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Нэхэмжлэлийн үндэслэлийн хувьд:

- дээрх тусгай зөвшөөрлийн дагуу цаашид фосфоритын хайгуул, ашиглалт явагдах тохиолдолд бүс нутгийн хүрээлэн буй орчин, ялангуяа хүн малын ундны усны цорын ганц эх үүсвэр болсон Дэлгэр мөрөн, Хядгийн гол болон рашаан маань үгүй болох, цаашлаад Байгаль далайд хор уршиг нь хүрч, хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, бидний өвөг дээдсийн үеэс уламжлан, төр засгийн түвшинд хамгаалж ирсэн түүх, соёлын дурсгалт зүйлс маань үнэлж баршгүй хохирол учрах аюул тулгарна.
- Хайгуулын 6 лицензийн хувьд: АМТХ-ийн 60 дугаар зүйлийн 60.4-т “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй” гэсэн зохицуулалтыг зөрчиж олгосон.
- Ашиглалтын 3 лицензийн хувьд: БОНБҮТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь ашигт малтмал ашиглах эрх авахын өмнө хийгдсэн” байх шаардлагыг зөрчсөн гэж маргажээ.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд

2.1. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 0568 тоот шийдвэр¹⁰³

Анхан шатны шүүхээс зарим нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгож, бусад нэхэмжлэлийн шаардлагуудыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Х ТББ-ын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, тус ТББ-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэгч Х1 нарын 4 иргэний гаргасан А ХХК-ийн ашигт малтмалын хайгуулын 12636Х, 12638Х тоот тусгай зөвшөөрлүүдийг АМТХ-ийн 56.1.4-т заасны дагуу цуцлахыг хариуцагчид даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзан, тус нэхэмжлэлийн шаардлагад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийн үлдэх хэсгийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Үүнийг дэлгэрүүлбэл, ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “нэхэмжлэл гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг” хэлнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл, Захиргааны хэргийн шүүх нь нэхэмжлэгчийн өөрийнх нь субъектив эрх бодитоор хөндөгдсөн маргааныг харьяалан шийдвэрлэдэг шүүх ба харин бусдын буюу нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар итгэмжлэлгүйгээр төрийн бус байгууллага нь захиргааны хэргийн шүүхэд хандах эрхгүй ба энэ тохиолдолд Х ТББ-ыг нэхэмжлэгч гэж үзэхгүй хэмээн дүгнэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Мөн нэхэмжлэгч Х1 нарын 4 иргэний гаргасан ашигт малтмалын хайгуулын 12636Х болон 12638Х тоот тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг хариуцагчид даалгах нэхэмжлэлийн шаардлагуудыг хүлээн авахаас татгалзсан байна. Учир нь нэхэмжлэгч иргэд нь Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын иргэд биш учраас хайгуулын 12636Х, 12638Х дугаартай тусгай зөвшөөрлүүдийг олгосон шийдвэрийн улмаас тэдгээрийн дээрх эрх нь хөндөгдөхгүй бөгөөд энэ талаар нэхэмжлэл гаргах эрхгүй гэж дүгнэжээ.

¹⁰³ Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн шийдвэр, дугаар 0568, <http://www.shuukh.mn/zahirgaanhan/1192/view>

Түүнчлэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгээгүй байхад олгосон ашиглалтын лицензүүдийг илт хууль бус гэж тооцуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг цуцлах тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. АМТХ-ийн (1997 он) 30 дугаар зүйлийн 1-д “Ашигт малтмал ашиглах лиценз авахын өмнө эсхүл авсны дараа тухайн лиценз эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг зохих хууль тогтоомжийн дагуу шуурхай боловсруулна” гэж гэж сонгох боломжтойгоор хуульчилжээ. БОНБҮТХ-ийн (1998 он) 4 дүгээр зүйлийн 4.2-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ нь ашигт малтмал ашиглах ... эрх авах болон төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө хийгдсэн байна” гэж хуульчилсан зэргээс дүгнэхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг заавал тусгай зөвшөөрөл авахаас өмнө хийхээр хуульчлаагүй бөгөөд тусгай зөвшөөрөл авсны дараа гаргуулах боломжтой байхаар хуульчилсан тул уг үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцлах боломжгүй гэж шүүхийн зүгээс шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарласан байна.

Эцэст нь орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ажиллагаа явагдаж буй газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон актыг цуцлахыг даалгах шаардлагыг мөн бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна. Учир нь тухайн газрын орон нутгийн тусгай хэрэгцээнээс гаргасан, тухайн орон нутгийн засаг даргын хувьд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаагүй гэж тайлбарласан байна.

Мөн шүүхээс нэхэмжлэгчдийн тайлбарласнаар дээрх ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл, үйл ажиллагаанаас үүдэн аливаа байдлаар иргэд, мал амьтан хохирол учруулж болзошгүй гэх тайлбарыг хүлээн аваагүй байна. Учир нь захиргааны хэргийн шүүх аливаа нэг бодит болсон факт дээр тулгуурлан шийдвэр гаргахаас бус ирээдүйд болох зүйлсийн таамаглал дээр үндэслэн шийдвэрлэх боломжгүй, нэхэмжлэгчийн зүгээс эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэх нотлох баримтыг гаргаагүй хэмээн үзсэн байна. Нөгөөтэйгүүр өнөөгийн үйлчилж буй ЗХХШТХ-ийн холбогдох заалтаар¹⁰⁴ бусдын зөрчигдөж

¹⁰⁴ ЗХХШТХ - 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх

болзошгүй эрхийг хамгаалсан шинэлэг зохицуулалт орсон бөгөөд цаашид дээрх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болохгүй юм.

2.2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 0078 тоот магадлал¹⁰⁵

Давж заалдах гомдлын агуулга: “Энэ шийдвэрээр хэн ч хууль зөрчиж болно, шүүх үүнийг мэдсэн ч хариуцлага хүлээхгүй гэдгийг тунхаглаж өгсөнд гомдолтой байна. Иймд, 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 568 дугаартай шийдвэрийг хүчингүй болгож, дахин журмын дагуу шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Давж заалдах шатны шүүхээс “нэхэмжлэгч Х ТББ, нэхэмжлэгч иргэд XI нарын давж заалдах гомдлын дагуу хэргийг хянаад анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Харин Давж заалдах шатны шүүхээс Анхан шатны шүүх АМТХ-ийн 60 дугаар зүйлийн 60.4¹⁰⁶ дэх хэсгийг буруу тайлбарласан гэж үзжээ. Уг

бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.3. “нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг;

106 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр, түүнийг гаргах

106.3. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана:

106.3.8. захиргааны хэм хэмжээний акт хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоох;

106.3.10. захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох;

¹⁰⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн магадлал, дугаар 0078 <http://www.shuukh.mn/zahirgaadavah/540/view>

¹⁰⁶ 60 дугаар зүйл. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

60.4. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

зүйлд буй “улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй” гэсэн заалт нь үгийн шууд утгаараа тайлбарлагдах бөгөөд өөр бусад этгээдэд ч хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй гэсэн агуулгатай болно. ЗХХШТХ-ийн агуулгаас үзэхэд захиргааны акт нь тухайн иргэн, хуулийн этгээдийн эрхийг зөрчсөн байхыг шаардах бөгөөд ийнхүү зөрчсөн болох нь нотлох баримтаар тогтоогдвол шүүх хүчингүй болгож шийдвэрлэдэг. Энэ тохиолдолд нэхэмжлэгч 4 иргэний эрхийг зөрчсөн эсхүл зөрчиж болзошгүй гэдэг нь одоогийн байдлаар нотлох баримтаар тогтоогдохгүй байна гэж шүүх үзсэн тул энэ үндэслэлээр хайгуулын 4 тусгай зөвшөөрөлд холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэх боломжгүй гэж дүгнэсэн байна.

2.3. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн шүүх хуралдааны 118 тоот тогтоол¹⁰⁷

Улсын дээд шүүхээс “Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулж, хэрэгт цугларсан нотлох баримтуудыг зөв дүгнэж, маргааны үйл баримтад холбогдох БОНБҮТХ, АМТХ-ийн холбогдох заалтуудыг зөв тайлбарлаж хэрэглэсэн, шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагад нийцсэн байна” гэжээ.

Гурав. Дүн шинжилгээ

Тус маргааны үндсэн зорилго нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэнд, ургамал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх, түүнчлэн түүхийн дурсгалт болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт олгосон зөвшөөрлийг цуцлуулах чиглэлээр гарсан нэхэмжлэл байна.

Гэвч шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагын хагасыг хүлээн аваагүй буюу нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдийн гаргасан нэхэмжлэлийг шүүх хэлэлцэхгүй хэмээн үзсэн байна. ЗХХШТХ-ийн үндсэн зорилгын хувьд аливаа захиргааны актаас үүдэн эрх

бүртгэлд бүртгэсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй.

¹⁰⁷ Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн тогтоол, дугаар 118, <http://www.shuukh.mn/zahirgaahyanalt/417/view>

нь зөрчигдсөн этгээд уг асуудлаар шүүхэд хандах эрхтэй байхаар хуульчилсан бөгөөд аливаа байдлаар эрх зөрчигдөөгүй этгээд нэхэмжлэл гаргах боломжгүй байдаг. Онолын хувьд уг зохицуулалт гарцаагүй байх зохицуулалт буюу бусдын дур зорго, өөрт шууд хамааралгүй асуудлаар бусдын эрхэд халдах оролдлогоос хамгаалах зорилготой байдаг. Уг зохицуулалтыг шүүхийн зүгээс үндэслэлтэйгээр тайлбарлан хэрэглэсэн байна. Гэсэн хэдий ч тухайн зөвшөөрөл олгогдсон баг, сум, дүүрэгт харьяалан амьдардаг эсэхээс хамааран нэхэмжлэл гаргах эрхийг шалгах байжээ. Тухайлбал, голын ус бохирдсон асуудлын хувьд хэт явцуу дүгнэлт хийсэн байж болзошгүй байна. Учир нь дийлэнх гол мөрний хувьд аливаа аймаг сумын нутаг дэвсгэрт харьяалагдаж урсдаггүй бөгөөд хэд хэдэн нутаг дэвсгэрийг дамнан урсдаг. Энэ тохиолдолд тухайн голын бохирдсон ус нь аль нутгийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байна гэдгийг тогтоох (тусгай мэдлэг шаардсан асуудлаар мэргэжлийн шинжээч томилон дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагаа хийх боломжтой эсэхэд дүгнэлт өгөөгүй) нь ач холбогдолтой бөгөөд тухайн уул уурхайн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгогдсон сумын нутгийн иргэд нэхэмжлэл гаргах эрхтэй, харин голын ус дамжин урсаж байгаа бусад сумын иргэд адилхан хохирч байгаа ч тухайн зөвшөөрөл олгогдсон баг, сумын харьяалалд биш гэх үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах эрсдэл үүсэхийг үгүйсгэхгүй юм. Нөгөө талаар, шүүх аливаа асуудлаар ирээдүйд үүсэж болзошгүй асуудлыг урьдаас таамаглан шийдвэрлэх боломжгүй тул нэхэмжлэгчийн зүгээс өөрт хохирол учирсан гэдгийг баримтаар нотлоогүй тохиолдолд хохирол учирч магадгүй гэх байдлаар хандан шийдвэрлэх боломжгүй юм. Шүүхийн зүгээс мөн тухайн харилцаанд холбогдох асуудлыг тухайн үед хэрэгжиж байсан эрх зүйн хэм хэмжээг баримтлан шийдвэрлэх ёстой бөгөөд өөр цаг үеийн асуудлыг одоо цагт хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нийцүүлэн шийдвэрлэх боломжгүй талаар үндэслэлтэй тайлбар хийжээ. Энэ нь ТББ-ын нэхэмжлэл гаргах эрх нээлтэй биш байсан үеийн шийдвэр байна. 2016 оны ЗХШХШтХ батлагдахаас өмнөх үед ТББ захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхгүй байсан ч БОХтХ-ийн 32 дугаар зүйлийн 1-ийн

1-д¹⁰⁸ заасны дагуу ЗХШ-д мөн адил нэхэмжлэл гаргаж болно гэсэн хандлага байсан. Мөн захиргааны хэргийн шүүхээс зөвхөн өөрийн ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд л шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн хандлага, эрх зүйн орчин байсан учраас ТББ-аас нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжгүй байжээ.

Нөгөөтэйгүүр өнөөгийн үйлчилж буй ЗХШХШТХ-ийн холбогдох заалтаар¹⁰⁹ бусдын зөрчигдөж болзошгүй эрхийг хамгаалсан шинэлэг зохицуулалт орсон бөгөөд цаашид дээрх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болохгүй юм. Аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд заасны дагуу нотлох баримтыг үндэслэн шийдвэрлэгдэх учиртай. 2016 оны ЗХШХШТХ-ийн 7 дугаар

¹⁰⁸ 32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох
Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно: 1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах

¹⁰⁹ 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.3. “нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг

106 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр, түүнийг гаргах

106.3. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана. 106.3.8. захиргааны хэм хэмжээний акт хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоох; 106.3.10. захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох;

зүйлд (2002 оны ЗХХШтХ-ийн 31 дүгээр зүйл) Шүүхийн нотлох зарчмыг тусгасан бөгөөд 7.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна” гэжээ.

Дээрх зохицуулалттай уялдуулан уг шийдвэрт шинжилгээ хийвэл, шүүхийн зүгээс тухайн орон нутгийн иргэдийн эрх ашиг зөрчигдөж болзошгүй талаар нотлох баримт байхгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлгүй байна. Дээрх хуулийн зохицуулалтын дагуу Захиргааны хэргийн шүүх нь өөрөө нотлох баримтыг цуглуулах үүрэг хүлээдэг бөгөөд иргэдийн эрх ашиг ирээдүйд зөрчигдөж болзошгүй талаар нотлох ажиллагаа хийгээгүй гэж үзэж байна. Шүүхийн зүгээс уг нотлох ажиллагааг хийснээр иргэдийн эрх ашиг заавал хөндөгдсөн байх ёстой гэж үзэхгүй бөгөөд гагцхүү хөндөгдөж болзошгүй талаар баримт цуглуулан тухайн баримтад дүгнэлт хийж иргэдийн эрх ашиг зөрчигдөж болзошгүй, эсхүл зөрчигдөхгүй гэх дүгнэлтийг хийх байжээ. Өөрөөр хэлбэл, шүүхийн зүгээс өөрийн хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй атлаа уг үүргийг нэхэмжлэгчид хамаатуулсан нь мөн алдаа болсон байна. ЗХХШтХ-ийн 7.2 дахь хэсэгт “Шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэх нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй” гэж заасан хэдий ч уг заалт нь захиргааны шүүхийн нотлох зарчмыг хэрэгжүүлэхгүй байх эрхийг олгосон заалт огт биш байна.

Дээрхээс дүгнэвэл, тус хэргийн хувьд шүүхийн зүгээс хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн судлаагүй, өөрийн хүлээсэн үүргээ биелээгүй буюу хэргийн нөхцөлд байдалд чухал ач холбогдол бүхий ажиллагааг хийгээгүй гэж үзэхээр байна. Маргааны хувьд хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр бодит үр дүн гарахуйц асуудлыг хөндсөн хэдий ч шүүхийн шийдвэрийн дагуу бодит, хэрэгжихүйц, үр нөлөө бүхий шийдвэр гаргаагүй байна. Энэ нь тухайн үед мөрдөгдөж байсан эрх зүйн орчны хүрээнд хүрээлэн буй орчны асуудлаар захиргааны хэргийн шүүхэд дээрх чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэгч ТББ зэрэгт нэхэмжлэл гаргах эрх нээлттэй биш байсантай холбоотой юм.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Судлаачийн хувьд бүх шатны шүүхийн шийдвэртэй хууль хэрэглээний асуудлаар бүрэн санал нийлж байгаа бөгөөд анхан шатны шүүх хуулийн зарим хэсгийг буруу тайлбарласныг давж заалдах шатны шүүхээс залруулан шийдвэрлэсэн байдал нь уг шийдвэр бүхэлдээ хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадсан гэж дүгнэхээр байна.

Дүн шинжилгээ 3. НУАХ ТББ нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн даргад холбогдох шүүхийн маргаан¹¹⁰

Нэг. Хэргийн агуулга

“НУАХ” НҮТББ-аас “...Монгол Улсын иргэдийн Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн. ...Монгол хүний өвөг дээдсийн шарил, бунхан, соёлын үнэт өв соёл, байгалийн үзэсгэлэнт газар, тогтоц, нуур цөөрөм, горхи булаг рашаан, ховор өвс ургамал, ан амьтан, араатан жигүүртэн, хүн малын амь нас эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах байдал зэрэг ...жам ёсны бүх эрхүүд алдагдан бүгд устан үгүй болох бодит нөхцөл үүсээд байна. ...тусгай зөвшөөрлүүд нь ГМУБЭУСБГХБОСБГАМХАХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3, 4.5¹¹¹, 5.3¹¹² дахь заалтуудыг зөрчсөн. ...Энэхүү газар нь ойн бүс болон усан сангийн эх урсац газарт хамрагддаг, байгалийн үзэсгэлэнт газар. ...хэрэв үйлдвэрлэл явагдвал ... хүнцэл, цианит зэрэг химийн хорт бодист уусан устах аюултай...” гэж үзэн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэгчийн зүгээс 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр “Ашигт малтмалын газрын

¹¹⁰ Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн тогтоол, дугаар 0458, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1663/view>

¹¹¹ 4 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно. 4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно. 4.5. Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

¹¹² 5 дугаар зүйл. Байгаль орчныг нөхөн сэргээх

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг ИТХ-ын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.

даргын шийдвэрээр “А” ХХК-д Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг “Г” гэдэг газарт олгогдсон ... тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл, ... тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан ба Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “НУАХ” ТББ-ын захирал О.Ц-ын “Нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх тухай” 2016 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 16/07 тоот албан бичгээр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаа “Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг “Г” гэдэг газарт “А” ХХК-ний эзэмшилд байгаа ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг Ү-д даалгаж өгнө үү” гэж нэмэгдүүлсэн байна.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд

2.1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 128/ШШ2018/361 дүгээр шийдвэр¹¹³

Тус маргааныг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр нь шүүхийн шийдвэрийн цахим санд байршаагүй байна. Шүүхийн шийдвэр нь олон нийтэд нээлттэй хэдий ч шүүхийн шийдвэрийн цахим санд байршаагүй, хэргийн шийдвэрийг маргааны оролцогч бус этгээд аливаа байдлаар танилцах боломжгүй байв.

Давж заалдах шатны шүүхийн магадлалаас үзэхэд анхан шатны шүүхийн шийдвэр дараах байдлаар гарчээ. Үүнд, АМТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.14¹¹⁴, 56 дугаар зүйлийн 56.1.7¹¹⁵-д заасныг баримтлан Х-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, АМГТГКХ-ийн шийдвэрээр “А” ХХК-д Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг “Г” гэдэг газарт олгогдсон ... дугаар бүхий ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг цуцлах тухай шийдвэр гаргахыг хариуцагч Ү-д даалгаж шийдвэрлэжээ.

¹¹³ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд тус хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр байршаагүй байна.

¹¹⁴ 11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг
11.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид энэ хуульд “төрийн захиргааны байгууллага” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 11.1.14. хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих

¹¹⁵ 56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах
56.1. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр цуцална: 56.1.7. хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон.

Дээрх хэргийн тухайд зарим судлаачид нэхэмжлэгч тал нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий этгээд болох нь хангалттай нотлогдоогүй байхад захиргааны хэрэг үүсгэн улмаар нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн хэмээн үнэлэлт өгсөн байдаг¹¹⁶.

2.2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 221/МА2018/0510 тоот магадлал¹¹⁷

Давж заалдах шатны шүүхээс Анхан шатны шүүх ЗХШХТХ-иар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөний улмаас хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байх тул шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна. Давж заалдах гомдлын агуулга: “1. Нэхэмжлэлийн шаардлагыг тодруулсан гэх үйл ажиллагаа хууль зөрчсөн, 2. Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлага хангаагүй гэж үзэн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 128/ШШ2018/361 дугаар шийдвэр хууль зүйн үндэслэлгүй байх тул уг шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Давж заалдах шатны шүүхийн зүгээс хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гуравдагч этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан “... 2016 оны 4 дүгээр сараас хойш 2 жил гаруй хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг маргаан бүхий хоёр захиргааны актыг хүчингүй болгуулах шаардлагын хүрээнд явуулсан, энэ хүрээнд холбогдох нотлох баримтууд цуглуулсан ... шүүх хэргийг шийдвэрлэж, шийдвэр гаргасан шүүх хуралдааны явцад ... шүүх нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилж байгаа эсэх талаар ... тодруулаагүй, ... нэхэмжлэгч өмнө гаргасан нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн тохиолдолд ... хуульд заасны дагуу энэ талаар

¹¹⁶ Р.Мөнхзул, Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн, Нээлттэй Нийгэм Форум, Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал (Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь зүйл заалтын агуулгын хүрээнд), УБ., 2019 он, 27 дахь тал.

¹¹⁷ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн магадлал, дугаар 221/МА2018/0510, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2463/view>

хэргийн бусад оролцогчдод албан ёсоор танилцуулж, шүүх хуралдааныг үргэлжлүүлэх боломжтой эсэх, эсхүл хэргийн бусад оролцогчдод тайлбар нотлох баримт гаргах боломжоор хангах үүрэгтэй ... шүүхийн шийдвэрт тусгагдсанаас үзвэл нэхэмжлэлийн шаардлага шүүх хуралдаан дээр өөрчлөгдсөн, тус нэхэмжлэлийн шаардлагад хэргийн бусад оролцогчдод тайлбар, нотлох баримт гаргах боломж олголгүйгээр хэргийг шийдвэрлэсэн нь ... шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн ... асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй гэсэн хуулийг зөрчсөн ..." гэх гомдол үндэслэлтэй гэж үзэн давж заалдах гомдлыг ханган шийдвэрлэжээ.

Түүнчлэн гуравдагч этгээд, түүний өмгөөлөгчийн "... шүүх нэхэмжлэгч Х-ын шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг, нягтлан үзэж, дүгнэлгүйгээр шийдвэр гаргасан" гэх давж заалдах гомдол үндэслэлтэй гэж шүүхээс үзсэн байна. Нэхэмжлэгч "Х нь уг төрийн бус байгууллагын эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн гэх агуулгаар биш харин ... нутгийн болон Монгол Улсын иргэдийн Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн ..." гэж нийтийн эрх ашгийг төлөөлөн 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр шүүхэд нэхэмжлэл гаргасан, шүүх 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр захиргааны хэрэг үүсгэсэн байна. Энэ талаар талууд маргасан байхад шүүхээс шийдвэртэй дүгнэлт хийгээгүй нь алдаа болсон гэжээ.

2.3. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн шүүх хуралдааны 0458 тоот тогтоол¹¹⁸

Улсын дээд шүүхээс "давж заалдах шатны шүүхийн "анхан шатны шүүхийн шийдвэр ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.2¹¹⁹-т заасантай нийцээгүй, нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг өөрчилсөн байхад шүүх нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тодруулж, хэргийн оролцогчдод танилцуулж тайлбар

¹¹⁸ Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 11 сарын 14-ний өдрийн тогтоол, дугаар 0458, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1663/view>

¹¹⁹ 106 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр, түүнийг гаргах 106.2. Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

гаргуулах, хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг цуглуулах ажиллагаа хийгээгүй, мөн нэхэмжлэлийн зарим шаардлагын үндэслэлд дүгнэлт хийлгүй хэргийг шийдвэрлэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн гэж дүгнэн, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан нь үндэслэлтэй байна”. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Г.Б-ын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй” гэжээ.

Гурав. Дүн шинжилгээ

Шүүхийн зүгээс тус хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаасан нь хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн шинжлэн судлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэх, талуудын зөрчигдсөн эрхээ сэргээхэд чухал ач холбогдол бүхий шийдвэр болсон байна.

Анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ноцтой зөрчсөн, шаардлагатай асуудлаар дүгнэлт хийгээгүй зэрэг алдааг гаргасан бөгөөд уг алдааг давж заалдах болон хяналтын шатны журмаар залруулах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлийг гаргасан гэж давж заалдах шатны шүүхээс үзжээ. ЗХШХШТХ-д заасны дагуу Давж заалдах шатны шүүхээс ажиллагаа хийн залруулах боломжгүй заавал анхан шатны журмаар хийгдэх ажиллагааг хийгээгүй тохиолдолд процессын ноцтой зөрчил гэж үзэн хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаадаг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талуудын тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцээний зарчим дээр тулгуурлан явагддаг. Талууд тэгш эрхтэйгээр мэтгэлцэх зарчмыг хангагдах гол нөхцөл нь талууд ямар агуулга бүхий маргаан хийж байгаа, хэн хэнээс юу хүсээд байна гэдэг нь ойлгомжтой байх учиртай. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл нь тодорхой байснаар хариуцагч талд татгалзлаа нотлох, хариу тайлбар өгөх боломжоор хангах гол нөхцөл болдог. Давж заалдах шатны шүүхээс талуудад хариу тайлбар гаргах хугацааг олгох боломжгүй учир тус шалтгаанаар хэргийг дахин хэлэлцүүлэхээс өөр аргагүй болно

Тус маргааны шийдвэрээс дүгнэлт хийхэд 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн шүүх хуралдааны явцад нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс “ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгохыг хариуцагчид даалгуулах” гэж нэхэмжлэлийн шаардлага болон үндэслэлээ өөрчилсөн байхад өөрчилсөн нэхэмжлэлийн шаардлагыг хэргийн бусад оролцогчдод танилцуулж, тайлбар гаргуулах, улмаар нэхэмжлэлийн өөрчлөгдсөн шаардлагатай холбогдуулан нотлох баримт цуглуулах ажиллагааг хийгээгүй нь ЗХШХТХ-ийн 32 дугаар зүйл, 56 дугаар зүйл, 57 дугаар зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд нийцээгүйн улмаас шүүхийн шийдвэр хуульд нийцсэн байх, үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй байна.

Нэхэмжлэлийн шаардлага, түүнийг өөрчилсөн болон нэмэгдүүлсэн шаардлагыг хариуцагчид хуульд заасан хугацаанд танилцуулж хариу тайлбар гаргах боломжоор хангах нь талуудын мэтгэлцэх эрхийг хангахад чухал ач холбогдолтой байдаг. Хариуцагчийн зүгээс өөрчилсөн шаардлагатай холбогдуулан шүүхэд нэмэлт ажиллагаа хийлгэх, нотлох баримт гаргаж өгөх боломжийг шүүхийн зүгээс олгох үүрэгтэй байдаг.

Мөн хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийн зарим шаардлагын үндэслэлд дүгнэлт хийлгүй хэргийг шийдвэрлэсэн гэжээ. Анхан шатны шүүхийн шийдвэрийн шүүхийн шийдвэрийн цахим санд бүртгэгдээгүй байгаа бөгөөд давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн магадлал тогтоолд уг асуудлыг дэлгэрэнгүй тусгаагүй учир судлаачийн зүгээс дүгнэлт хийх боломжгүй байна.

Маргааны агуулгын хувьд нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалахад чухал үр дүнтэй байх байсан хэдий ч нэхэмжлэгчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагаа зөв тодорхойлоогүй, хэрхэн зөв тодорхойлох аргаа олоогүй мэт харагдаж буй нь бодит байдалд үр дүнгүй ажиллагаа болсон байна.

Судлаачийн хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийн хувьд ЗХШХШТХ-ийг ноцтой зөрчсөн, хэргийг бүрэн дүүрэн судлаагүй буюу хууль ёсны байх шаардлагыг хангаагүй гэж үзэхээр байна. Харин давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн магадлал тогтоолын хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг алдаатай талыг зөв тодорхойлж, уг алдааг залруулахыг даалгасан үндэслэл бүхий шийдвэр гарсан байна.

Дүн шинжилгээ 4. Дэлхийн Монгол Ногоон нэгдэл ТББ нарын нэхэмжлэлтэй Ашигт малтмалын газрын кадастрын хэлтсийн даргад холбогдох шүүхийн маргаан¹²⁰

Нэг. Хэргийн агуулга

Дэлхийн Монгол Ногоон нэгдэл ТББ нь (цаашид Х ТББ гэх) нь БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасан байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг эрх үүргийн дагуу Монгол орныг байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажиллаж буй ТББ ажээ.

Хэнтий аймгийн Биндэр, Батширээт сумдын нутаг, Бурхан халдун уулнаас эх аван урсдаг Онон голын сав газар, ойн сан бүхий газарт Гутайн даваа ХХК-д (гуравдагч этгээд А ХХК гэх) 779 га талбай бүхий ашигт малтмал олборлох MV-019023 тоот тусгай зөвшөөрлийг Уул уурхайн яамны Ашигт малтмалын газраас 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр олгожээ.

Тус ТББ-ын зүгээс дээрх MV-019023 тусгай зөвшөөрлийг олгохдоо ГМУБЭУСБГХБОСБГАМХАХТХ зөрчсөн тул тусгай зөвшөөрлийг цуцалж өгнө үү” гэх шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд¹²¹

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 539 тоот шийдвэр¹²²

Тус маргааныг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн зүгээс

¹²⁰ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэр, дугаар 539 <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1598/view>

¹²¹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хэргийн оролцогч тухайн шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд хуульд заасан хугацаанд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байдаг. Тус хэргийн хувьд нэхэмжлэгчийн зүгээс дээрх гомдлыг гаргаж хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал тогтоол шүүхийн шийдвэрийн цахим санд байршаагүй байна. Иймд нэхэмжлэгчийн зүгээс уг шийдвэрт гомдол гаргаагүй гэж үзэхээр байна.

¹²² Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэр, дугаар 539 <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1598/view>

нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Шүүхийн зүгээс “Маргаан бүхий захиргааны акт болох Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 621 дүгээр шийдвэрээр АМТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.3.2¹²³-т заасныг үндэслэн 025303 дугаартай өргөдлийн дагуу Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутагт орших Шургадагийн гол нэртэй 779.32 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг А ХХК-д олгохоор шийдвэрлэсэн байна. АМТХ-ийн 24.1¹²⁴-д “Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй” гэж, мөн хуулийн 26.3.2-т “хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх” гэж заажээ. Хуулийн дээрх заалтуудаас үзвэл, А ХХК нь уг талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан байх ба энэ нь зөвхөн тус компанид хуулиар олгогдсон давуу эрх гэж үзэхээр байна. ... Мөн А ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргахдаа 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдөр БОАЖЯ-аас гаргасан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ”-г хавсаргаж өгсөн нь хуулийн дээрх заалтад нийцсэн байна. ... Иймд хариуцагч байгууллагаас гаргасан захиргааны актыг хүчингүй болгох хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна” гэж дүгнэсэн байна.

¹²³ 26 дугаар зүйл. Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа

26.3. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.1, 26.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ: 26.3.2. хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх

¹²⁴ 24 дүгээр зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага

24.1. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй.

Гурав. Дүн шинжилгээ

Аливаа этгээд хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэн өөрийн эзэмшиж буй хайгуулын талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх, холбогдох шаардлагыг ханган үйл ажиллагаа явуулах эрхийг АМТХ-иар олгосон байна. Тус маргааны хувьд гуравдагч этгээдийн зүгээс хуулиар олгогдсон онцгой эрхээ хэрэгжүүлэх хүсэлт гаргасныг, уг хүсэлтийг хуулийн дагуу хүлээн авч ханган шийдвэрлэсэн байдлыг хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхээргүй байна.

Гэвч шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг бүрэн тодруулаагүйн улмаас зарим асуудалд үндэслэл бүхий дүгнэлт хийлгүйгээр хэргийг шийдвэрлэсэн харагдаж байна. Тухайлбал, Хэнтий аймгийн Биндэр, Батширээт сумдын нутаг, Бурхан халдун уулнаас эх аван урсдаг Онон голын сав газар, ойн сан бүхий газарт “А” ХХК-д 779 га талбай бүхий ашигт малтмал олборлох MV-019023 тоот тусгай зөвшөөрлийг Уул уурхайн яам Ашигт малтмалын газраас 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр олгосон бөгөөд уг MV-019023 тусгай зөвшөөрлийг олгохдоо ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ зөрчсөн гэж нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлжээ.

Шүүхийн зүгээс “зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй” гэж, мөн хуулийн 26.3.2-т “хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх” гэж шийдвэртээ заажээ. Түүнчлэн “А” ХХК нь уг талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргасан байх ба энэ нь зөвхөн тус компанид хуулиар олгогдсон давуу эрх гэж үзэхээр байна... Мөн “А” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргахдаа 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдөр БОАЖЯ-аас гаргасан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ”-г хавсаргаж өгсөн нь хуулийн дээрх заалтад нийцсэн байна гэж дүгнэсэн байна. Энэхүү дүгнэлт нь гагцхүү тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх эрхийг (онцгой эрх) тайлбарласан зохицуулалт болохоос биш тусгай зөвшөөрөл олж авах

эрхийг олгосон заалт биш юм. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуульд заасан эрхийнхээ дагуу тусгай зөвшөөрөл хүссэн хэдий ч тухайн зөвшөөрлийг олгох боломжтой эсэхийг хуулийн хүрээнд хянан шалгадаг. Нэхэмжлэгчийн зүгээс ГМУБЭУСБГХБОСБГАМХАХТХ-ийг зөрчсөн гэж тайлбарлаж байтал шүүхийн зүгээс тухайн хуулийг хэрхэн зөрчөөгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг хийгээгүй байна. Гагцхүү тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргах эрхтэй талаар дүгнэлт хийсэн нь алдаа болсон буюу хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн шинжлэн судлаагүй гэж дүгнэхэд хүргэж байна.

Судлаачийн хувьд Шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль ёсны бөгөөд хангалттай үндэслэл бүхий гэж үзэхгүй байна.

Дүн шинжилгээ 5. “Ангир нүдэн мөндөөхэй хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлтэй БОАЖЯ-ны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл¹²⁵

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “Ангир нүдэн мөндөөхэй хөдөлгөөн” ТББ (цаашид Х ТББ гэх) нь хариуцагч БОАЖЯ-ны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл (цаашид Ү гэх)-ийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өрийн хуралдааны М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргажээ.

¹²⁵ 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, дугаар 40, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4287/view>

Хоёр. Шүүхийн шийдвэр, үндэслэл

Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл¹²⁶

1. БОНБУТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1¹²⁷, 8.2¹²⁸, 11 дүгээр зүйлийн 11.1¹²⁹, 11.2¹³⁰-т тус тус заасныг баримтлан нэхэмжлэгч Х ТББ-ын нэхэмжлэлтэй хариуцагч Ү-д холбогдох Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг дахин шинэ акт гаргал 2 сарын хугацаагаар түдгэлзүүлжээ.
2. ЗХШХШТХ-ийн 107 дугаар зүйлийн 107.6-д¹³¹ зааснаар шүүхээс тогтоосон хугацаанд захиргааны байгууллага шинэ акт гаргаагүй тохиолдолд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэр хүчингүй болно.

¹²⁶ 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, дугаар 40, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/4287/view>

¹²⁷ 8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

8.1. Энэ хуулийн 7.4.3-т заасны дагуу гарсан дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, хугацааг тодорхой заана.

¹²⁸ 8.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

¹²⁹ 11 дүгээр зүйл. Хянан магадлагаа

11.1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадалгаа хийнэ.

¹³⁰ 11.2. Хянан магадалгааны дүгнэлт гаргах хугацааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч тогтоож, холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тухай бүр ажлын хэсэг томилон ажиллуулна.

¹³¹ 107 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийн агуулга

107.6. Энэ хуулийн 106.3.11-д заасан шийдвэрийг гаргасан бөгөөд шүүхээс тогтоосон хугацаанд захиргааны байгууллага шинэ акт гаргаагүй бол уг маргаан бүхий актыг хүчингүй болгох талаар тогтоох хэсэгт тусгана.

Дээрх шийдвэрийн үндэслэл нь:

1. Хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн гэж үзэн захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй.
2. Х ТББ нь БОХТХ-ийн биелэлтэд хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, байгаль орчныг хамгаалах талаар саналаа холбогдох байгууллагад уламжлах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж аргачлал боловсруулах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авчээ.
3. Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар шинжээчийн дүгнэлт (хянан магадлах асуулга бөглөсөн дүгнэлт) хэлэлцүүлсэн эсэх, тус хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг тодруулахаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн архивын баримт бичигт үзлэг хийсэн боловч шинжээчийн дүгнэлт (хянан магадлах асуулга бөглөсөн дүгнэлт) хадгалагдаагүй, хуралдааны тэмдэглэл нь дуу бичлэгээр хадгалагддаг гэх боловч тэр баримт нь байхгүй, мэргэжлийн зөвлөлөөс маргаан бүхий асуудлаар шийдвэр гаргасан эсэх нь тодорхойгүй байх тул хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай бөгөөд ийнхүү нэмж тодруулах зүйл нь шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байх тул дахин шинэ акт гаргал Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг түдгэлзүүлэх нь зүйтэй.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан нь эрх зүйн үр дагавар бий болгодог тухайлсан харилцааг зохицуулдаг онцлогтой байна.
5. Гэтэл 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны тэмдэглэл нотлох баримтаар авагдсан боловч уг хуралдаанаар нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой асуудал хэрхэн хэлэлцэгдсэн нь тодорхойгүй, ирцийн бүртгэл дутуу,

шинжээчийн дүгнэлт (хянан магадлах асуулга бөглөсөн дүгнэлт) хэлэлцүүлсэн эсэх нь тодорхойгүй, хуралдааны тэмдэглэлийн эх баримт байхгүй байх тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэх тухайд хууль зүйн дүгнэлт хийх боломжгүй.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын 106 дугаар зүйлийн 106.3.11¹³² дэх заалтын хэрэглээ, тайлбарын тухайд

Шүүхийн шийдвэрт “...хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай бөгөөд ийнхүү нэмж тодруулах зүйл нь шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байх тул дахин шинэ акт гаргал... Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх үзлээ” гэсэн байдаг. Шүүх ингэж шийдвэрлэхдээ ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын 106 дугаар зүйлийн 106.3.11 дэх “Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана: шүүх хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн гэж үзвэл захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх” гэсэн заалтыг удирдлага болгосон болно.

2002 онд батлагдаж 2016 онд хүчин төгөлдөр бус болсон ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлийн 70.2.7 дахь заалтад “Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана: хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах

¹³² 106 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр, түүнийг гаргах

106.3. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргана. 106.3.11. шүүх хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн гэж үзвэл захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх.

шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх” гэж хуульчилсан байжээ. Монгол Улсын хуулийн хувьд ХБНГУ-ын хуулийн зохицуулалттай харьцуулахад захиргааны шүүхэд гаргасан гомдол нэхэмжлэл нь түдгэлзүүлэх үйлчлэл байдаггүй тул ийм боломж шүүхэд байх шаардлагатай¹³³. Дээрх зүйлд заасан “хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай” гэдгийг шүүх өөрийн санаачилгаар тогтоохгүй бөгөөд захиргааны байгууллага энэ талаар өөрөө санаачилж, шалгах хүсэлтээ шүүхэд гаргасан байх нөхцөл байдлыг ойлгоно¹³⁴. Практикт шүүх өөрөө хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж тогтоож байгаа нь буруу бөгөөд захиргааны байгууллагаас гаргасан акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд уг актыг гаргахдаа нөхцөл байдлыг тодруулж шалгах ажиллагаа дутуу байна гэж захиргааны байгууллага, албан тушаалтан өөрөө хүлээн зөвшөөрөөгүй бол уг актыг хууль бус гэж үзэх үндэслэл болох юм. Уг шийдвэр нь хариуцагч захиргааны байгууллага нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг биш бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн гаргасан захиргааны актын үндэслэлийг тодруулж, шалгах шаардлагатай гэж үзэж байгаа гэсэн үг юм¹³⁵. Ингэж үзэх үндэслэл нь Улсын дээд шүүхийн ЗХХШТХ-ийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 2006 оны тогтоолд “Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д заасан “...хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх” ажиллагааг хариуцагч өөрөө маргаан бүхий захиргааны актыг алдаатай гарсныг хүлээн зөвшөөрч, нөхцөл байдлыг шалган тогтоож, шинээр захиргааны акт гаргах боломжтой гэж үзсэн тохиолдолд хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд шүүх маргаан бүхий захиргааны актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх

¹³³ Хайнрих Шоллер, Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний) Анхны хэвлэл, УБ., 2017. 380 дахь тал.

¹³⁴ Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний) Анхны хэвлэл, УБ., 2017. 204 дэх тал.

¹³⁵ Мөн тэнд, 204 дэх тал.

бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтнаас шинээр гаргасан захиргааны актад хуульд заасан ердийн журмаар гомдол гаргаж болно” гэж тайлбарласан байдаг¹³⁶. Үндсэндээ Захиргааны хэргийн шүүхээс шалгах явцад хэргийн нөхцөл байдал бүрэн тодроогүй хэдий ч тухайн захиргааны актыг гаргасан үндэслэл хангалттай биш байх бөгөөд үүнийг захиргааны байгууллага хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч уг маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох үндэслэл бүрэн биш байх тохиолдолд хэргийн нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай гэж шүүх үзвэл, захиргааны байгууллагын зүгээс хэргийн нөхцөл байдлыг бүрэн гүйцэд тодруулсны үндсэн дээр шинээр захиргааны акт гартал уг захиргааны актыг түдгэлзүүлэх шийдвэр гаргах юм¹³⁷.

Дээрхээс дүгнэвэл, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2016 оны ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.11 дэх заалтын хувьд шүүх хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн, түүнчлэн тэрхүү нэмж тодруулах зүйлийн цар хүрээ шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байх гэсэн хоёр нөхцөл зэрэг хангагдсан тохиолдолд захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэхээр заасан тул шүүх өөрөө хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, тэдгээр нь шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн гэж үзсэн тохиолдолд хэрэглэгдэхээр байна. Харин 2002 оны ЗХХШТХ дахь дээрхтэй төсөөтэй заалтыг хэрэглэхдээ практикт шүүх өөрөө хэргийн нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай гэж тооцож байгаа нь буруу бөгөөд хариуцагч захиргааны байгууллага өөрөө маргаан бүхий захиргааны актыг алдаатай гарсныг хүлээн зөвшөөрч, нөхцөл байдлыг шалган тогтоож, шинээр захиргааны акт гаргах боломжтой гэж үзсэн тохиолдолд хэрэгжүүлнэ гэсэн Улсын дээд шүүхийн тайлбар үйлчилж байсан. Иймд цаашид ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.11 дэх заалтын хэрэглээний хувьд өмнөхтэй адилаар шүүх өөрөө хэргийн нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай гэж тогтоож байгаа нь буруу гэсэн судлаачийн тайлбар,

¹³⁶ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн дугаар 37 тогтоол, <https://www.legalinfo.mn/judicare/details/75?lawid=284>

¹³⁷ А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2014 он, 315 дахь тал.

хандлага үйлчлэх эсэх, түүнчлэн хариуцагч захиргааны байгууллага захиргааны актыг алдаатай гаргаснаа хүлээн зөвшөөрсөн, хүсэлт гаргасан тохиолдолд уг шийдвэр хэрэгждэг байх эсэх тухайд нэгдсэн санал, шийдэлд хүрэх нь цаашид уг зохицуулалтыг хэрэглэхэд гарах хүндрэлээс сэргийлэх боломжтой юм.

3.2. ЗХШХШтХ шинэчилсэн найруулгын 106 дугаар зүйлийн 106.3.11 дэх заалт ба нотлох ажиллагааны тухайд

ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.2-т “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэж заажээ. Мөн шүүхийн шийдвэр нь аливаа байдлаар хоёрдмол утгагүй, биелэгдэх боломжтой бөгөөд нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд гарах ёстой. Гэвч тус шүүхийн шийдвэр нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх зарчмыг хангаагүй гэж үзэх үндэслэлтэй.

Тодруулбал, Шүүхийн шийдвэрт “...Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар шинжээчийн дүгнэлт (хянан магадлах асуулга бөглөсөн дүгнэлт) хэлэлцүүлсэн эсэх, тус хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг тодруулахаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн архивын баримт бичигт үзлэг хийсэн боловч шинжээчийн дүгнэлт (хянан магадлах асуулга бөглөсөн дүгнэлт) хадгалагдаагүй, хуралдааны тэмдэглэл нь дуу бичлэгээр хадгалагддаг гэх боловч тэр баримт нь байхгүй, мэргэжлийн зөвлөлөөс маргаан бүхий асуудлаар шийдвэр гаргасан эсэх нь тодорхойгүй байх тул хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай бөгөөд ийнхүү нэмж тодруулах зүйл нь шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байх тул дахин шинэ акт гаргал Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны М ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг түдгэлзүүлэх нь зүйтэй” гэж дүгнэжээ. ЗХШХШтХ-ийн 7 дугаар зүйлд Шүүх нотлох зарчмыг тусгасан бөгөөд 7.1-т “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна” гэж мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т “Шүүх хэрэгт

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр өөрийн дотоод итгэлээр үнэлнэ” гэж, 34.2-т “Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ” гэж, мөн 6 дугаар зүйлийн 6.3-т “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн буруутай үйл ажиллагаа, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний талаар нотлох болон үгүйсгэх байдлаар мэтгэлцэнэ”, мөн хуулийн 106.4-т “Шүүхийн шийдвэр нь хэрэгт авагдсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтад үндэслэсэн байна” гэж тус тус заасан байна.

Дээрх хуулийн заалтуудаас дүгнэхэд Захиргааны хэргийн шүүх тухайн маргааныг хянан шийдвэрлэх нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд маргааныг хавтаст хэрэгт цугласан нотлох баримтын хүрээнд талуудын мэтгэлцээний зарчимд тулгуурлан хянан шийдвэрлэх үүрэгтэй байна. Захиргааны хэргийн шүүх нотлох ажиллагаа хийсэн хэдий ч шаардлагатай баримтууд цуглаагүй тохиолдолд талуудын гаргасан нотлох баримт, тайлбарыг үндэслэн хэргийг шийдвэрлэх боломжтой байдаг. Гэвч шүүхээс Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэх хууль зүйн дүгнэлт хийх боломжгүй гэсэн тайлбар хийж буй нь хэрэгт цугласан нотлох баримтыг үнэлээгүй, талуудын тайлбарт дүн шинжилгээ хийгээгүй, мөн нотлох үүргээ хэрэгжүүлээгүйг харуулж байна гэж үзэх боломжтой.

Холбогдох зарим судалгааны бүтээлд дээрх шүүхийн шийдвэр нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ нь нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл шүүхэд хандах боломжтой болохыг харуулсан шийдвэр¹³⁸ гэдэг талаас үнэлэлт өгсөн бол энэхүү дүн шинжилгээнд хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай бөгөөд шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байх тохиолдолд дахин шинэ акт гаргал маргаан бүхий шийдвэрийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн онцлог талаас нь голлон анхаарсан болно.

¹³⁸ Р.Мөнхзул, Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн, Нээлтгэй Нийгэм Форум, Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал (Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь зүйл заалтын агуулгын хүрээнд), УБ., 2019 он, 33 дахь тал. https://www.academia.edu/38551870/Нийтийн_Ашиг_Сонирхлыг_Хамгаалахтай_Холбоотой_Хэрэг_Хянан_Шийдвэрлэх_Ажиллагааны_Өнөөгийн_Байдал

ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дүн шинжилгээ 1. “Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ-ын нэхэмжлэлтэй “Петрочайна дачин тамсаг” ХХК-д холбогдох иргэний хэрэг¹³⁹

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ (цаашид Х ТББ гэх) нь хариуцагч “Петрочайна дачин тамсаг” (цаашид Ү ХХК гэх) ХХК-д холбогдуулан Дорнод аймгийн Матад сумын газар нутгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хангалтгүй явуулсан болохыг тогтоолгох, хариуцагч компанид байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг даалгах, байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөрт 1,356,622,460 төгрөг гаргуулж Дорнод аймгийн Матад сумын төсөвт оруулах тухай гурван шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр, үндэслэл¹⁴⁰

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2, ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.4, 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хариуцагч Ү ХХК нь Дорнод аймгийн Матад сумын 4 дүгээр багийн нутаг Тосон-Уулын 19 дүгээр талбайд газрын тосны үйл ажиллагаа явуулахдаа байгаль хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлээгүй болохыг тогтоож, Ү ХХК-иас нөхөн төлбөр 1,356,622,460 төгрөгийг гаргуулан Дорнод аймгийн Матад сумын орон нутгийн төсөвт оруулж, нэхэмжлэлийн шаардлагаас

¹³⁹ 2012 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Улсын дээд шүүхийн Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, дугаар 563, <http://old.shuukh.mn/irgenhyanalt/554/view>

¹⁴⁰ 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх хуралдааны шийдвэр, дугаар 854, <http://old.shuukh.mn/irgenanhan/33602/view>

байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг хариуцагч Ү ХХК-д даалгах тухай хэсгийг хэрэгсэхгүй болгожээ. Шийдвэрийн үндэслэл нь:

1. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж, БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх” гэж зааснаар нэхэмжлэгч Х ТББ нь шаардах эрхтэй байна.
2. Хариуцагч Ү ХХК нь Дорнод аймгийн Матад сумын нутаг Тосон-Уулын 19 дүгээр талбайд газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байхдаа АМТХ-ийн 37 дугаар зүйлийн 1-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ”, 38 дугаар зүйлийн 38.1.2-т “хүрээлэн байгаа орчныг бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээ авах” гэж, БОХТХ-ийн 21 дүгээр зүйлийн 1-ийн 1-д “хортой аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булах, устгах” гэж заасан үүргээ бүрэн биелүүлээгүй байх тул Дорнод аймгийн Матад сумын байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг хариуцах хууль зүйн үндэслэлтэй байна.
3. Хариуцагч Ү ХХК нь гуравдагч этгээд Газрын тосны газрын шүүхэд өгсөн тайлан болон “Эвдэрсэн газрыг нөхөн сэргээсэн тухай акт”-уудыг үндэслэл болгон байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн, Газрын тосны хаягдал шингэнийг булахдаа хятадын стандартаар булсан, тухайн үед стандарт байгаагүй гэж тайлбарлаж байгаа боловч АМТХ болон БОХТХ-

иар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн болохоо нотлох баримтыг шүүхэд гарган нотлоогүй байна.

4. Газрын тосны тухай хуулийн (ГТтХ гэх) 6 дугаар зүйлийн 6-д “хүн амын аюулгүй байдлыг хангах, ажиллагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эд хөрөнгө, байгалийн нөөц баялаг, газар, түүний хэвлий болон хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй байх, ашигласан талбайг сэргээх” гэж зааснаар хариуцагч Ү ХХК нь Дорнод аймгийн Матад сумын 4 дүгээр багийн нутагт газрын тосны үйл ажиллагаа явуулахдаа байгаль хамгаалах нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлээгүй болохыг тогтоож, Байгаль орчинд учирсан хохирол, нөхөн төлбөр 1,356,622,460 төгрөгийг хариуцагч Ү ХХК-иас гаргуулан Дорнод аймгийн Матад сумын төсөвт оруулах, нэхэмжлэлийн шаардлагаас Ү ХХК-ийг байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу байгаль хамгаалах ажиллагаа явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг хариуцагч Ү ХХК-д даалгах тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал, үндэслэл¹⁴¹

Баянзүрх дүүргийн шүүхийн 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 854 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн төлөөлөгчийн давж заалдсан гомдлыг хангахгүй орхисон байна. Магадлалын үндэслэл нь:

1. Анхан шатны шүүх зохигчдын гаргасан тайлбар болон нотлох баримтын хэмжээнд нэхэмжлэлийн зарим шаардлагын талаар дүгнэлт хийж хэргийг хянан шийдвэрлэсэн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (цаашид ИХШХШтХ гэх) 40 дүгээр зүйлийн 40.1-40.3, 116 дугаар зүйлийн 116.3 дахь хэсэгт нийцжээ.
2. БОХтХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх,

¹⁴¹ 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлал, дугаар 519, <http://old.shuukh.mn/irgendavah/1328/view>

илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэжээ. Нэхэмжлэгч Х нь дүрэмдээ зорилго, үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлохдоо байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж буй төр, засгийн бодлого, шийдвэрт нөлөөлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах гэсэн байх ба нийтийн эрх ашгийг төлөөлж хууль болон дүрэмд зааснаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзнэ.

3. Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагаа Монгол Улсын Засгийн газартай хариуцагч компанийн байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг 19 дүгээр талбайн зарим хэсэгт явуулж буй газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотойгоор гаргасан ба хариуцагч нь газрын тосны талаар үйл ажиллагаа явуулахдаа хуульд заасан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй болох нь Улсын мэргэжлийн хяналтын газрын албан шаардлагууд, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлгүүд болон бусад баримтаар нотлогдсон болно.
4. ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.2-т зааснаар хариуцагч гэм буруугүй болохоо нотолж чадаагүй тул 497.1-д заасны дагуу хариуцлага хүлээнэ. Хариуцагч нь олборлолт хийсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн, хийж байгаа гэх боловч шинжээчийн дүгнэлтээр 19 дүгээр талбайд олборлолт хийгдсэн газрын хөрс, бэлчээрийн газрын нөхөн сэргээлт технологийн дагуу зохих ёсоор хийгдээгүй болох нь тогтоогдсон байна.
5. 2010 оны 9 дүгээр сард гарсан шинжээчийн дүгнэлтээр хариуцагч Ү ХХК Дорнод аймгийн Матад суман дахь Тосон-Уулын 19 дүгээр талбай дээр явуулж буй газрын тос олборлох үйл ажиллагаа Монгол Улсын хуулийн дагуу явагдаж байна гэж үзэх үндэслэлгүй байгааг тогтоож, байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тооцон гаргасан байна. Дээрх шинжээчийн дүгнэлтийг үндэслэн нэхэмжлэлийн заримыг хангаж шийдвэрлэснийг буруутгах боломжгүй байна.

Хоёр. Шүүхийн шийдвэр, үндэслэл

Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, үндэслэл¹⁴²

Улсын дээд шүүх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн хяналтын гомдлыг хангах үндэслэлгүй гэж үзжээ. Тогтоолын үндэслэл нь:

1. Шүүх, ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасан зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэж, хариуцагчийн гэм бурууг тогтоон нэхэмжлэлийн шаардлагыг хангасан нь үндэслэл бүхий болжээ.
2. БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэсний дагуу нэхэмжлэгч Х ТББ энэхүү нэхэмжлэлийг гаргах эрхтэй байна. Нэхэмжлэгч Х ТББ нь дүрэмдээ зорилго, үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлохдоо байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж буй төр, засгийн бодлого, шийдвэрт нөлөөлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах гэсэн байх ба нийтийн эрх ашгийг төлөөлж хууль болон дүрэмд зааснаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шаардах эрхтэй гэж үзнэ.
3. Хариуцагч Ү ХХК нь 2005 оноос Дорнод аймгийн Матад сумын нутаг Тосон-Уулын 19 дүгээр талбайд газрын тосны олборлолтын ажиллагааг явуулахдаа газрын тосны хайгуул өрөмдлөгийн шингэн хаягдал, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санг саармагжуулж, хоргүйжүүлэхгүйгээр шууд шороогоор булснаас болж байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн, бэлчээрийн газаргүй болгосон, мөн стандартын үл нэвчих материал дэвсээгүйгээс шингэн хаягдал газрын хөрсөнд шингэж газрын хөрсийг бохирдуулсан, түүнчлэн стандартын шаардлага хангаагүй хайрган хучилттай олон салаа зам гаргаж, зүмпүүдийн хооронд 200-300-аад зам үүссэн, үүний улмаас маш их хэмжээний тоосжилт үүсэж

¹⁴² 2012 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Улсын дээд шүүхийн Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, дугаар 563, <http://old.shuukh.mn/irgenhyanalt/554/view>

ургамлын бүтцэд нөлөөлсөн, хүн, мал амьтны эрүүл мэндэд хохирол учруулсан хууль зөрчсөн буруутай ажиллагаа хийжээ. Хариуцагч Ү ХХК-ийн хууль зөрчсөн дээрх гэм буруутай үйл ажиллагааны улмаас Дорнод аймгийн Матад сумын нутагт байгаль орчинд 1,356,622,460 төгрөгийн хохирол учирсан болох нь зохигчид, бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тайлбар, шинжээч, гэрч нарын шүүхэд өгсөн мэдүүлэг, дүгнэлт зэрэг хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон байна.

4. Шүүх хөрөнгө үнэлгээний “Мөнх-Оргил” ХХК-ийн 2010 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 01/Э дугаар дүгнэлтийг нэхэмжлэлийн шаардлагыг хангах нэг үндэслэл болгожээ. Хариуцагчийн үйл ажиллагаанаас болж үүссэн экологи-эдийн засгийн хохирлын тооцоог гаргахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2010 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А-156 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ыг ашигласан байна. Аргачлалын дагуу хохирлыг автомашины олон салаа зам үүссэнээс үүдэн газрын хөрс, бэлчээр, эдэлбэр газарт учирсан хохирол болон газрын тосны хаягдлаар бохирдсоноос үүдэн газрын хөрс, эдэлбэр газарт учирсан хохирол гэж задлан тооцож нийт 1,356,622,460 төгрөг гэж үнэлжээ.
5. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шинжээчийн дүгнэлтийг үндэслэлгүй гарсан, гаднын шинжээч оролцуулсан гэж маргасан нь үндэслэлгүй болно. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “хөрөнгийн үнэлгээ хийхэд бусад үнэлгээчин болон мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр татан оролцуулах” гэж зааснаар “Мөнх-Оргил” ХХК дүгнэлт гаргахдаа мэргэжлийн хүнийг гэрээгээр ажиллуулсныг буруутгах үндэслэлгүй байна.
6. Хариуцагч нь олборлолт хийсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн, хийж байгаа гэх боловч шинжээчийн дүгнэлтээр 19 дүгээр талбайд олборлолт хийгдсэн газрын хөрс, бэлчээрийн газрын нөхөн сэргээлт технологийн дагуу зохих ёсоор хийгдээгүй болох нь тогтоогдсон ба шинжээчийн дээрх дүгнэлт гарах хүртэлх хугацаанд тэрээр 19 дүгээр талбайд хуулийн дагуу нөхөн сэргээх

үйл ажиллагаа явуулаагүй байжээ.

7. ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т зохигчид хэргийн үйл баримт, гэм буруу байгаа эсэхийг нотлох буюу үгүйсгэх замаар мэтгэлцэх эрхтэй, мөн хуулийн 25 дугаар зүйлд шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах, үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг цуглуулах, гаргаж өгөх үүргийг зохигчид хүлээх ёстой байхаар тус тус зохицуулсан ба үүний дагуу нэхэмжлэлийн шаардлагыг үгүйсгэх нотлох баримтуудыг шүүхэд ирүүлээгүй явдалд нэхэмжлэгч болон шүүхийг буруутгах үндэслэлгүй юм.
8. Байгаль орчинд гэм хор учруулсан хариуцагчийн гэм буруутай үйлдэл хууль бус болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогджээ. Иймээс түүний үйлдлийн улмаас байгаль орчинд учирсан хохирлыг шинжээчийн тусламжтайгаар учирсан гэм хорыг арилгахад зарцуулах зардлын хэмжээг бодитоор тооцож, төлбөрийг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн нь ИХ-ийн 228 дугаар зүйлийн 228.1-д¹⁴³ заасан шаардлагад нийцжээ.
9. Шүүх нэхэмжлэлийн шаардлагаас хариуцагч Ү ХХК нь Дорнод аймгийн Матад сумын 4 дүгээр багийн нутагт газрын тосны үйл ажиллагаа явуулахдаа байгаль хамгаалах нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлээгүй болохыг тогтоож, байгаль орчинд учирсан хохирол, нөхөн төлбөр 1,356,622,460 төгрөгийг хариуцагч Ү ХХК-иас гаргуулах шаардлагуудыг хангасан нь хууль зүйн үндэслэл бүхий болсон байна. Харин хариуцагчийн байгаль орчинд учруулсан хохирол 1,356,622,460 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор нэхэмжлэлийн шаардлагаас байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг хариуцагчид даалгах тухай шаардах шаардлагыг хэрэгсэхгүй болгосон нь түүнийг хуулийн дагуу гүйцэтгэх ёстой үүргээс бүхэлд нь чөлөөлсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

¹⁴³ 228 дугаар зүйл. Гэм хорыг арилгуулах эрх

228.1. Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. Нэхэмжлэгч Х ТББ-ын шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлийн тухайд

Улсын дээд шүүхээс нэхэмжлэгч Х ТББ-ын нэхэмжлэл гаргах эрхийн тухайд “...БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” гэсний дагуу нэхэмжлэгч Х ТББ энэхүү нэхэмжлэлийг гаргах эрхтэй, ...Нэхэмжлэгч Х ТББ нь дүрэмдээ зорилго, үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлохдоо байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж буй төр, засгийн бодлого, шийдвэрт нөлөөлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах гэсэн байх ба нийтийн эрх ашгийг төлөөлж хууль болон дүрэмд зааснаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шаардах эрхтэй ...” гэж үзсэн байна. Эндээс аливаа төрийн бус байгууллага байгаль орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн иргэний хэргийн нэхэмжлэл гаргахдаа БОХТХ-ийн 32.1.1 дэх заалтын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд нэхэмжлэгч төрийн бус байгууллага нь иргэний хэргийн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхийг тогтоох үндсэн шалгуур нь тухайн маргаан тус бүр дээр нэхэмжлэгч төрийн бус байгууллагын дүрэмдээ байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий эсэхийг шалган тогтооход оршиж байна.

Нэхэмжлэгч ТББ-ын зүгээс гаргах нэхэмжлэлийн төрөл нь БОХТХ-д заасны дагуу гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахад чиглэсэн нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагдах эсэхийг тодруулах хэрэгтэй. Хариуцагч талаас нэхэмжлэгч Х ТББ-ыг БОХТХ-д заасны дагуу зөвхөн хохирол нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй гэж эсэргүүцсэн байтал шүүхээс БОХТХ-ийн 32 дугаар зүйл нь зөвхөн хохирол нөхөн төлүүлэхийг шаардах эрхийг ТББ-д олгосон эсэх, даалгах нэхэмжлэлийг гаргах боломж байгаа эсэх зэрэг асуудал дээр шүүх тодорхой үнэлэлт өгөөгүй байна. Тодруулбал, Улсын дээд шүүхээс “...Харин хариуцагчийн байгаль орчинд учруулсан хохирол 1,356,622,460 төгрөгийг гаргуулахаар

шийдвэрлэсэнтэй холбоотойгоор нэхэмжлэлийн шаардлагаас байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг хариуцагчид даалгах тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгосон нь түүнийг хуулийн дагуу гүйцэтгэх ёстой үүргээс бүхэлд нь чөлөөлсөн гэж үзэх үндэслэлгүй байна...” гэж үзжээ. Эндээс Улсын дээд шүүхийн дээрх үнэлэлт нь БОХТХ-ийн 32.1.1 дах заалт нь нэхэмжлэгч ТББ-д зөвхөн гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахад чиглэсэн нэхэмжлэл гаргах эрх олгогдсон тул даалгах нэхэмжлэлийн төрөл гаргах нь нэхэмжлэгч ТББ-д хуулиар олгогдоогүй гэсэн байр суурийг илэрхийлээгүй учраас цаашид ТББ-аас гаргах иргэний хэргийн нэхэмжлэлийн төрлийн хувьд даалгах даалгах нэхэмжлэл, эрх зөрчсөн үйлдлийг зогсооход чиглэсэн нэхэмжлэл зэрэг хохирол нөхөн төлүүлэхээс өөр бусад төрлийн нэхэмжлэл гаргах боломжтой эсэх дээр тогтсон үзэл санаа байх нь зүйтэй.

Байгаль орчин, түүний бохирдолтой холбоотой хэрэг дээр байгаль орчинд учирсан хохирол нэгэнт үүссэний дараа мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр барагдуулах нь үр дүнгийн хувьд хохирол үүссэний дараах арга хэмжээ юм. Харин дээрх хэсэгт дурдсан эрх зөрчсөн үйлдлийг зогсооход чиглэсэн нэхэмжлэлийн шаардлага гаргах нь тэрхүү байгаль орчинд хохирол учруулж буй аливаа үйлдэл, үйл ажиллагааг таслан зогсоох үйлчлэлтэй байх тул үр дүнгийн хувьд илүү юм. Манай улсын хувьд эрх зөрчсөн үйлдлийг зогсооход чиглэсэн нэхэмжлэлийн шаардлагын тухайд тодорхой хуулийн зохицуулалт байхгүй боловч ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.2 дэх хэсэг, 92 дүгээр зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу эзэмших болон өмчлөх эрхэд суурилсан өмчлөх, эзэмших эрхийн хэрэгжилтэд саад болж буй үйлдлийг таслан зогсоохоор нэхэмжлэлийн шаардлага гаргах боломжтой. ГтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.7 дахь хэсэгт зааснаар өвөлжөө, хаваржааны доорх газрыг малчид хот айлаар дундаа эзэмшиж болохоор заасан. Дээрх зохицуулалтад үндэслэн хэрэв уул уурхайн компанийн үйл ажиллагааны улмаас малчин иргэний эзэмшиж байгаа өвөлжөө хаваржааны газарт хохирол учруулсан үйлдэл гарсан бол түүнийг зогсоохоор шаардаж болно. Гэхдээ энэ тохиолдолд жирийн малчин иргэний хувьд бэлчээр гол мөрөн гэх мэтийг өмчлөх, эзэмших эрх олгогдоогүй, түүнчлэн өмчлөгч, эзэмшигч этгээд л дээрх шаардлагыг гаргах эрхтэй байх тул үр нөлөөний хувьд ач холбогдол багатай, хязгаарлагдмал байж

болзошгүй. Манай улсын хувьд Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэснийг үндэслэл болгон амины эрхэд суурилсан таслан зогсоох нэхэмжлэл гаргах боломжтой. Энэ тохиолдолд дан ганц өмчлөх, эзэмших эрхтэй этгээдээр хязгаарлагдаагүй учраас нийт малчин иргэдийн хувьд үр нөлөөтэй арга гэж үзэж болно¹⁴⁴.

3.2. Иргэний хуулийн гэм хорын эрх зүйн зохицуулалт болон БОХТХ дахь байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөртэй холбоотой хуулийн зохицуулалтын харилцан хамаарлын тухайд

БОХТХ-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй (БОХТХ 49.1). Мөн хуульд зааснаар байгаль орчинд учруулсан хохирол гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлэх бөгөөд энэхүү үйлдэл, эс үйлдэхүйг хийсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлөгч гэж тодорхойлсон (БОХТХ 3.2.11, 3.2.13). Харин “байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны байгаль орчинд учруулсан хохирол, түүнийг арилгах болон цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны экологи-эдийн засгийн үнэлгээ, аргачлалын дагуу тогтоосон мөнгөн илэрхийллийг хэлдэг (БОХТХ 3.2.12).

Ийнхүү БОХТХ-д тухайн аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаа явуулж, үүний үр дүнд байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсдэг. Дүн шинжилгээ хийж буй хэргийн гурван шатны шүүх хуралдаан дээр БОХТХ-ийн дээрх зохицуулалт огт дурдагдаагүй байх бөгөөд ИХ-ийн 228, 497.1, 510.1

¹⁴⁴ С.Сүхчүлуун, Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт заасан шаардах эрхийн хүрээг өргөжүүлэх нь (Байгаль орчны бохирдолтой холбоотой хэрэг маргаан дээр хэрэглэх боломж), Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2019 оны 1 дүгээр улирлын дугаар, 159-160 дахь тал. <http://www.judoinstitute.mn/main/238--2019-.html>

зэрэг гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаарх үндсэн зохицуулалт хэрэглэгдсэн байдаг. Тодруулбал, Улсын дээд шүүхийн тогтоолын үндэслэл хэсэгт “...хариуцагч Ү ХХК-ийн хууль зөрчсөн дээрх гэм буруутай үйл ажиллагааны улмаас Дорнод аймгийн Матад сумын нутагт байгаль орчинд 1,356,622,460 төгрөгийн хохирол учирсан болох нь зохигчид, бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тайлбар, шинжээч, гэрч нарын шүүхэд өгсөн мэдүүлэг, дүгнэлт зэрэг хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдсон байна. ...Байгаль орчинд гэм хор учруулсан хариуцагчийн гэм буруутай үйлдэл хууль бус болох нь хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогджээ. Иймээс түүний үйлдлийн улмаас байгаль орчинд учирсан хохирлыг шинжээчийн тусламжтайгаар учирсан гэм хорыг арилгахад зарцуулах зардлын хэмжээг бодитоор тооцож, төлбөрийг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн нь ИХ-ийн 228 дугаар зүйлийн 228.1-д заасан шаардлагад нийцжээ” гэж үзсэн байдаг.

Давж заалдах шатны шүүхийн магадлалд “...2010 оны 9 дүгээр сард гарсан шинжээчийн дүгнэлтээр хариуцагч Ү ХХК Дорнод аймгийн Матад суман дахь Тосон-Уулын 19 дүгээр талбай дээр явуулж буй газрын тос олборлох үйл ажиллагаа Монгол Улсын хуулийн дагуу явагдаж байна гэж үзэх үндэслэлгүй байгааг тогтоож, байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тооцон гаргасан байна. Дээрх шинжээчийн дүгнэлтийг үндэслэн нэхэмжлэлийн заримыг хангаж шийдвэрлэснийг буруутгах боломжгүй байна...” гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэрт “...хариуцагч Ү ХХК нь Дорнод аймгийн Матад сумын нутаг Тосон-Уулын 19 дүгээр талбайд газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байхдаа АМТХ-ийн 37 дугаар зүйлийн 1-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ”, 38 дугаар зүйлийн 38.1.2-т “хүрээлэн байгаа орчны бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булаах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах”, “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-ийн 1-д “хортой, аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булаах, устгах” гэж заасан үүргээ тус тус бүрэн биелүүлээгүй байх тул Дорнод аймгийн

Матад сумын байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг хариуцах хууль зүйн үндэслэлтэй байна...” гэжээ.

Энэ хэсэгт товчхон харьцуулалт хэлэхэд, Япон Улсад байгаль орчинд учирсан хохирол, түүнийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийн тухайд тусгайлсан хууль байгаа тохиолдолд тэрхүү тусгай хуулийн зохицуулалт, хэм хэмжээг хэрэглэх бөгөөд тодруулбал, агаарын бохирдлын улмаас эрүүл мэндэд хохирол учирсан бол Агаарын бохирдлоос хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйл¹⁴⁵, усны бохирдлоос үүдсэн эрүүл мэндэд учирсан хохирлын тухайд Ус бохирдлоос хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйл¹⁴⁶, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн хохирлын тухайд Уул уурхайн үйл ажиллагааны тухай хуулийн 109 дүгээр зүйлийг¹⁴⁷ тус тус дурдах боломжтой ба эдгээр зохицуулалт нь бүгд гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчимд (япон 無過失責任, англи liability of without negligence) суурилсан зохицуулалт юм. Энэ утгаараа хохирогч талын зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн хамгаалахад ихээхэн ач холбогдолтой. Дээр дурдсан тусгай хуулийн зохицуулалт байхгүй тохиолдолд ИХ-д заасан гэм хорын эрх зүйн зохицуулалт үйлчилдэг¹⁴⁸.

Дээрхээс дүгнэвэл, бидний шинжилж буй хэргийн хувьд байгаль орчинд учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахад чиглэсэн нэхэмжлэлийн шаардлагатай хэрэг байх бөгөөд ИХ-д заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн тухай үндсэн зохицуулалтаас гадна тусгайлсан хуулийн хэм хэмжээний хүрээнд БОХТХ-д заасан байгаль орчинд учирсан хохирол, нөхөн төлбөртэй холбогдох заалт хэрэглэгдэх боломжтой байсан атал анхан шат, давж заалдах шат, хяналтын шатны

¹⁴⁵ Япон Улсын цахим Засгийн газрын нэгдсэн портал сайтыг ашиглан дэлгэрүүлж үзэх боломжтой.

https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=343AC000000097#392

¹⁴⁶ Япон Улсын цахим Засгийн газрын нэгдсэн портал вэб сайтыг ашиглан дэлгэрүүлж үзэх боломжтой. https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=345AC0000000138#222

¹⁴⁷ Япон Улсын цахим Засгийн газрын нэгдсэн портал вэб сайтыг ашиглан дэлгэрүүлж үзэх боломжтой. https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=325AC0000000289#663

¹⁴⁸ 吉村良一 『公害・環境訴訟講義』（法律文化社、2018）50頁。Ёошимүра Риеоичи, Байгаль орчны бохирдол, хүрээлэн буй орчны нэхэмжлэлийн лекц, Хорицү бункаша хэвлэл, 2018 он, 50 дахь тал.

шүүх хуралдаан дээр БОХТХ-д заасан холбогдох хэм хэмжээг хангалттай хэрэглээгүй гэж үзэхээр байна. Энэхүү хэрэг нь байгаль орчинд учирсан хохирол, нөхөн төлбөр гаргуулахтай холбоотойгоор гурван шатны шүүхээс нэхэмжлэгч ТББ-ын гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлтэй гэж үзэн, хариуцагч Ү ХХК-иас байгаль орчинд учирсан хохирол, нөөн төлбөрийг гаргуулахаар шийдвэрлэсэн нь байгаль орчинд учирсан хохирол, түүний нөхөн төлбөрийг шүүхийн журмаар иргэний хэргийн нэхэмжлэл гаргах замаар шийдвэрлэх эрх зүйн боломжтой гэдгийг нотолсон явдал нь тус шүүхийн шийдвэрийн ач холбогдол юм.

Дүн шинжилгээ 2. “Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ-ын нэхэмжлэлтэй “Таван толгой” ХК, “Нүүрсний зам” ХХК, “Энержи ресурс” ХХК-д холбогдох шүүхийн маргаан¹⁴⁹

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ (цаашид Х ТББ гэх)-ын зүгээс Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Таван толгой хэмээх газраас гурван сумын нутаг дэвсгэрийг дамжин Таван толгой, Гашуун сухайтын чиглэлд 245 км урттай сайжруулсан шороон замаар 2005 оноос хойш нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ хугацаанд 80-105 тонны даацтай 18-24 м урттай автомашин чиргүүлийн угсраа бүхий 6000 гаруй тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2011 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн тогтоол, Мэргэжлийн хяналтын газрын удаа дараа тавьсан шаардлага, акт, дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс олон салаа бүхий 40-90 метрийн өргөнтэй, 60-80 см гүн ховилтой эвдрэл ихтэй замууд үүсгэжээ. Мөн тоосжилтын улмаас харагдах орчин хязгаарлагдмал болж, замын арчилгаа засварыг стандартын шаардлагын хэмжээнд тухай бүрд хийдэггүйгээс тоосонцор RM10-Н дундаж агууламж 1386 мкг/м³, M.5-Н дундаж агууламж 1086 мкг/м³ хэмжээтэй болж хэвийн түвшнээсээ 21-50 дахин ихэсжээ. Замын дагуух карьеруудад нөхөн сэргээлт хийгээгүй, шаардлагатай газар замын тэмдэг хийгээгүй, хөдөлгөөний нягтрал ихтэй улмаас 24 осол гарч, 10 гаруй хүний амь нас эрсдэж, онц их

¹⁴⁹ Нийслэлийн шүүхийн иргэний шүүх хуралдааны 2013 оны 12 сарын 11-ний өдрийн магадлал, дугаар 965, <http://old.shuukh.mn/irgendavah/2786/view>

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

хэмжээгээр хөрсний элэгдэл бий болж, говийн экосистемд өөрчлөлт орж, цөлжилтийн эрчмийг нэмэгдүүлж, тухайн орчинд ажиллаж амьдарч байгаа мал амьтан, малчид иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл, байгалийн тэнцвэрийг алдагдуулж мал, амьтны бэлчээр нутгийг доройтуулж, тээвэрлэлтийн аюулгүй байдал хангагдах нөхцөлгүй болгож нийгэмд онц их хэмжээний хохирол учруулсан байна.

Хариуцагч байгууллагууд төрийн бодлого, хууль тогтоомж, эрх бүхий байгууллага албан тушаалтны гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс Авто замын тухай хуулийн (цаашид АЗтХ гэх) 15.1.1, 15.1.3, 17.3.4, ГтХ-ийн 50.1.1, 50.1.2, 50.1.3, БОНБҮтХ-ийн 6.1, 6.2, Ариун цэврийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.1, Газрын хэвлийн тухай хуулийн 22.3, 20.2.4, Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийн 2.12, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн (цаашид ТХШтХ гэх) 13.2 дахь заалт, Байгаль орчны тухай хууль, дүрэм, заавар, стандартуудыг зөрчсөн болох нь мэргэжлийн байгууллагын дүгнэлт үнэлгээ, актаар тогтоогдсон байна.

Мөн Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтийн улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг 2011 онд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын тушаалаар “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”, “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал”-ын дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тооцуулахад (анхны нэхэмжлэлд нийт 57,675,632,400 төгрөгийг дээрх компаниудаас нэхэмжилсэн) БОХтХ-ийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2, 3, 5 дахь хэсгийн 1, 2-г заасныг үндэслэн нэхэмжлэлийн шаардлагад өөрчлөлт оруулж, газрын хэвлийд учирсан хохирлын хэмжээг хоёр дахин ($55,174,400 \times 2 = 110,348,800$ төгрөг), хөрсөнд учирсан хохирлын хэмжээг гурав дахин ($20,457,120,000 \times 3 = 61,371,360,000$ төгрөг), амьтны аймагт учирсан хохирлын хэмжээг 2 дахин ($18,762,135,000 \times 2 = 37,524,270,000$ төгрөг), ургамлын аймагт учирсан хохирлын хэмжээг 5 дахин ($11,014,727,500 \times 5 = 55,073,637,500$ төгрөг) нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцон, хариуцагч нарын нүүрс экспортолсон цаг хугацаа, хэмжээг холбогдох газруудаас ирүүлсэн мэдээ тайланд үндэслэн мөн 49 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар хохирол тооцсон

ажлын зардал 7,361,100 төгрөгийг нэмээд нийт дүн нь 154,086,978,600 төгрөг болсон байна.

Экспортлолсон нүүрсний нь тоо хэмжээний хувьд, Ашигт малтмалын газраас 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Сүхбаатар дүүргийн шүүхэд ирүүлсэн нүүрс олборлолт, экспортын мэдээлэлд тулгуурлан үзвэл хохирол тооцсон 2011 оны байдлаар “Тавантолгой” ХК (хариуцагч Y1 ХК гэх) нийт 19,093.1 сая.тн, “Энержи ресурс” ХХК (хариуцагч Y2 ХХК гэх) 9,782.2 сая.тн нүүрс буюу нийт 28,875.3 сая.тн нүүрс экспортлолсон байна. Эдгээр өгөгдлүүдэд үндэслэн энгийн математик тооцооллын хувь тооцох аргаар тооцвол:

Хариуцагч Y2 ХХК $9,782.2 \text{ сая.тн} / 28,875.3 \text{ сая.тн} = 33.9\%$ буюу 52,235,485,740 төгрөг, хариуцагч Y1 ХК $19,093.1 \text{ сая.тн} / 28,875.3 \text{ сая.тн} = 66.1\%$ буюу 101,851,492,800 төгрөг тус тус төлөхөөр байна. Иймд Y1 ХК болон Y2 ХХК-иудаас байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн гаргуулж, Байгаль хамгаалах санд оруулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Харин “Нүүрсний зам” ХХК (хариуцагч Y3 ХХК гэх) нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй, нүүрс экспортлогч компани биш тул нэхэмжлэгчийн зүгээс хариуцагч Y3 ХХК-д холбогдох нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан байна.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд

2.1. Сүхбаатар дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 1542 тоот шийдвэр¹⁵⁰

Шүүхээс нэхэмжлэгч Х ТББ-ыг Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2¹⁵¹, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2¹⁵², БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1¹⁵³-д заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах, хохирол шаардах

¹⁵⁰ Сүхбаатар дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн шийдвэр, дугаар 1542 <http://old.shuukh.mn/irgenanhan/68078/view>

¹⁵¹ Зургаадугаар зүйл.

2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн

¹⁵² Арван зургаадугаар зүйл.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй

¹⁵³ 32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох

Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн

эрхтэй, хариуцагч Y1, X2-ууд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Тавантолгой-1, Ухаа худаг нэртэй газруудад нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж байхдаа АМТХ-ийн 37 дугаар зүйлийн 1¹⁵⁴, 38 дугаар зүйлийн 38.1.2¹⁵⁵, 39 дүгээр зүйлийн 39.1.4.4¹⁵⁶-т заасан үүргээ биелүүлээгүй байх тул Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн нүүрсний замаас Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг хариуцах хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэжээ. Байгаль орчны сайдын 2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 207 дугаар тушаалын хавсралтаар “Ашигт малтмал олборлох, боловсруулах явцад үүсэх хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, экологийн хохирол тооцох аргачлал”-ыг баталж, уг аргачлалыг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллага болох “Эко-Сфера” ХХК, “Санни трейд” ХХК-ууд Аялал жуулчлалын сайдын А-147 тоот тушаалаар томилогдож, 2011 онд Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн нүүрсний замаас байгаль орчинд учирсан хохирлыг тооцож, үнэлгээг гаргасныг шүүх бодит үнэлгээ гэж дүгнэсэн байна. Дээрх дүгнэлтийн хүрээнд шүүхээс Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2¹⁵⁷, ИХ-ийн 9 дүгээр

байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно: 1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах

¹⁵⁴ 37 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах

37.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

¹⁵⁵ 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.1.2. энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булаах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах

¹⁵⁶ 39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

39.1.4. байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэ хуулийн 39.1.3-т зааснаас гадна дараах зүйлийг тусгах: 39.1.4.4. энэ хуулийн 38.1.2-т заасан нөхөн сэргээх арга хэмжээ

¹⁵⁷ Арван зургаадугаар зүйл.

зүйлийн 9.4.2¹⁵⁸, 9.4.4¹⁵⁹, 497 дугаар зүйлийн 497.1¹⁶⁰, 510 дугаар зүйлийн 510.1¹⁶¹, БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1.1¹⁶², 49 дүгээр зүйлийн 49.1¹⁶³, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2¹⁶⁴-т зааснаар хариуцагч Y1 ХК-иас 101,851,492,835 төгрөг, Y2 ХХК-

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

^{2/} эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй

¹⁵⁸ 9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт

9.4. Иргэний эрхийг дараах аргаар хамгаална: 9.4.2. эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх

¹⁵⁹ 9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт

9.4. Иргэний эрхийг дараах аргаар хамгаална: 9.4.2. эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх

¹⁶⁰ 497 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

497.1. Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

¹⁶¹ 510 дугаар зүйл. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах

510.1. Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх (адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр) буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.

¹⁶² 32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох

1. Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно: 1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

¹⁶³ 49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг Байгаль орчин, уур амьсгалын сангаас буцаан олгоно.

¹⁶⁴ 12 дугаар зүйл. Байгаль орчин, уур амьсгалын сан

12.2. Энэ хуулийн 12.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

12.2.2. байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах

иас 52,235,485,736 төгрөгийг тус тус гаргуулан Байгаль хамгаалах санд олгохоор, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн байна.

2.2. Нийслэлийн шүүхийн иргэний шүүх хуралдааны 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 965 дугаар магадлал¹⁶⁵

Давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаах тухай шийдвэр гаргажээ.

Давж заалдах гомдлын агуулга: хариуцагч Y2 ХХК “...хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн, нэхэмжлэгч нэхэмжлэх эрхгүй этгээд, ...анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт баримталсан хуулийн заалтууд буруу, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн учраас анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү”, хариуцагч Y1 ХК “...хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, нэхэмжлэгч нэхэмжлэх эрхгүй этгээд, Y1 ХК хэргийн хариуцагч биш тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Давж заалдах шатны шүүхээс “Нэхэмжлэгч сэргээлтийн зардал болон хохирол нэхэмжилсэн эсэх, хохирол тооцсон ажлын зардал 7,361,100 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл тодорхойгүй, хэрэгт нотлох баримт авагдаагүй байхад шүүх уг шаардлагыг тодруулалгүйгээр хэргийг шийдвэрлэсэн, Тавантолгой-Гашуун сухайтын чиглэлийн нүүрсний замаас байгаль орчинд учруулсан хохирлыг Аялал жуулчлалын сайдын А-147 тоот тушаалаар томилогдсон үнэлгээний “Эко Сфера”, “Санни трэйд” ХХК-иуд 2011 онд тооцож гаргасныг нэхэмжлэгч үндэслэж нэхэмжлэлийн шаардлага гаргасан боловч анх нэхэмжлэл гаргахдаа Y1 ХК болон Y2 ХХК-ийн учруулсан хохирлыг төлөх хувь хэмжээг шинжээч томилуулах замаар тооцуулахыг хүсэж шүүхэд хүсэлт гаргасан, хүсэлтийг шийдвэрлээгүй, хариуцагч нар дээрх үнэлгээний тайланг үндэслэн тухайн компаниудад холбогдуулж хохирлыг тооцоход эргэлзээтэй талаар удаа дараа тайлбар гаргаж байсныг шүүх анхаараагүй, хариуцагч нарын замын арчилгаа, засвар үйлчилгээнд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн нь хэргийн шийдвэрлэлтэд ач холбогдолтой байхад энэ талаар

¹⁶⁵ Нийслэлийн шүүхийн иргэний шүүх хуралдааны 2013 оны 12 сарын 11-ний өдрийн магадлал, дугаар 965, <http://old.shuukh.mn/irgendavah/2786/view>

шүүх тодруулж баримтыг үнэлээгүй нь хуульд нийцээгүй. Мөн нэхэмжлэгчээс гаргасан шинжээч томилуулах, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх хүсэлтүүдийг шийдвэрлээгүй, хариуцагчид хэргийн оролцогчийн эрх үүргийг тайлбарлаагүй, хэргийн оролцогчдод хэргийн материалыг бүрэн танилцуулалгүй хэрэг хянан шийдвэрлэх журмыг ноцтой зөрчсөн байна” хэмээн магадлалынхаа үндэслэлийг тайлбарлаж, анхан шатны шүүхийн шийдвэрийн хүчингүй болгон, дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Гурав. Дүн шинжилгээ

Тус маргааны үндсэн зорилго нь байгаль орчныг нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх болон хохирлын хэмжээг тогтооходой холбоотой чухал ач холбогдол бүхий маргаан байна. Анхан шатны шүүхээс хариуцагч нарыг хуульд заасан үүргээ биелүүлээгүй, байгаль орчинд учирсан хохирлыг тогтоосон мэргэжлийн байгууллагын хохирлын хэмжээг үндэслэлтэй гэж дүгнэн хариуцагч нараас хохирлыг гаргуулахаар шийдвэрлэсэн ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн, ач холбогдол бүхий нотлох баримтыг анхаараагүйн улмаас уг хэргийг давж заалдах шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаажээ.

ИХШХШТХ-д заасны дагуу давж заалдах шатны шүүхээс ажиллагаа хийн залруулах боломжгүй, заавал анхан шатны журмаар хийгдэх ажиллагааг хийгээгүй тохиолдолд процессын ноцтой зөрчил гэж үзэн хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаадаг бөгөөд энэ тохиолдолд дараах шаардлагын улмаас анхан шатны журмаар дахин хэлэлцүүлэхээр шийдсэн байна. Үүнд:

1. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл тодорхойгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцээний зарчим дээр тулгуурлан явагддаг. Талууд тэгш эрхтэйгээр мэтгэлцэх зарчим хангагдах гол нөхцөл нь талууд ямар агуулга бүхий маргаан хийж байгаа, хэн хэнээс юу хүсээд байна гэдэг нь ойлгомжтой байх учиртай. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл нь тодорхой байснаар хариуцагч талд татгалзлаа нотлох, хариу тайлбар өгөх боломжоор хангах гол нөхцөл болдог. Давж заалдах шатны шүүхээс талуудад хариу тайлбар гаргах хугацааг олгох

боломжгүй учир тус шалтгаанаар хэргийг дахин хэлэлцүүлэхээс өөр аргагүй болно.

2. Шинжээч томилуулах, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх хүсэлтийг шийдвэрлээгүй. ИХШХШТХ-д заасны дагуу тусгай мэдлэг шаардлагатай буюу техник технологи, эсхүл тусгай тооцооллын дүгнэлт гаргах шаардлагатай тохиолдолд шүүхээс шинжээч томилох боломжтой. Хэргийн оролцогчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ нотлох эсхүл татгалзлаа нотлох зорилгоор нотолгооны хэрэгсэл ашиглах хүсэлт гаргахад шүүхийн зүгээс аливаа байдлаар шийдвэрлээгүй, дүгнэлт өгөөгүй нь хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн ажиллагаа болно. Уг хүсэлтийг хангаагүй тохиолдолд зохигчийн зүгээс өөр байдлаар ажиллагаа хийлгэх боломжтой бөгөөд харин шүүхээс уг боломжийг хязгаарласан гэж үзэж болохоор байна. Нөгөө талаар, шинжээч томилуулах тухай хүсэлтийг хангасан тохиолдолд тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзэх, хэргийг түдгэлзүүлсэн захирамжид талууд гомдол гаргах, гаргасан гомдлыг тус шүүхийн ерөнхий шүүгч бүрэлдэхүүний хамтаар хянан шийдвэрлэх зэрэг процесс ажиллагаа хийгдэх боломжтой байдаг. Анхан шатны шүүхийн зүгээс уг ажиллагааг хийх боломжийг олгоогүй байна.
3. Хариуцагчид хэргийн оролцогчийн эрх үүрэг болон хэргийн материалыг бүрэн танилцуулаагүй гэжээ. Хэрэв хэргийн аливаа оролцогчид эрх үүргийг танилцуулж гарын үсэг зуруулаагүй тохиолдолд тухайн шатны шүүхийн шийдвэр хүчингүй байна.

Давж заалдах шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөнөөс гадна анхан шатны шүүхийн шийдвэр бодит байдалд бүрэн тогтоогдоогүй гэж үзжээ. Тухайлбал, нэхэмжлэлд хохирлоос гадна нөхөн сэргээлтийн зардал багтсан эсэх, хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосонтой холбоотой гарсан зардлыг нэхэмжлэх хуулийн үндэслэл байгаа эсэх, хариуцагч нарын замын арчилгаа, засвар үйлчилгээнд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн нь хэргийн шийдвэрлэлтэд ач холбогдолтой байхад энэ талаар дүгнэлт хийгээгүй. Агуулгын хувьд хохирол учруулсан үйл баримт нь өөр өөр байгаа тохиолдолд шүүхийн зүгээс хохирлыг нийт дүнгээр тооцоолох нь алдаатай шийдвэр болно. Хохирлыг тус бүрд нь

дэлгэрэнгүй задалж, холбогдох нотлох баримтыг шинжлэн судлах, тухайн асуудлаар шаардлага гарах эрхтэй эсэхийг тус бүрд дүгнэлт өгөх үүрэгтэй байдаг.

Шүүхийн шийдвэрийн ач холбогдол: Маргааны хувьд хүрээлэн буй орчинд учирсан хохирлыг буруутай этгээдүүдээс гаргуулж, байгаль хамгаалах санд олгуулах, уул уурхайн компаниудын хариуцлагыг сайжруулахад нөлөөлөхүйц асуудлыг хөндсөн хэдий ч үр нөлөө бүхий шийдвэр гараагүй байна.

Судлаачийн байр суурь, шийдвэрт өгөх үнэлгээ: Судлаачийн хувьд давж заалдах шатны шүүхийн шийдвэртэй хууль хэрэглээний асуудлаар санал бүрэн нийлэхгүй байна. Хэргийг цааш нь шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр байхгүй байна.

Дүн шинжилгээ 3. “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох шүүхийн маргаан¹⁶⁶

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ (цаашид Х ТББ гэх) нь хариуцагч Монгол Улсын Засгийн газарт (цаашид хариуцагч Ү гэх) холбогдуулан Онги, Завхан, Туул, Хүдэр, Улз, Ерөө, Гацууртын болон Хангилцагийн голуудын сав газарт учирсан байгаль орчны хохирлын үнэлгээг хоёр сарын дотор тооцож олон нийтэд зарлахыг даалгах, эдгээр голын сав газарт учирсан байгаль орчны хохирлыг Засгийн газраар барагдуулах, мөн сав газрын байгаль орчныг нөхөн сэргээх ажиллагааг Х ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг хариуцагчид даалгуулах, 68,908,512 төгрөгийн хохирол гаргуулах, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан тогтоолыг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 15 хоногийн дотор гаргахыг даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Нэхэмжлэлийн үндэслэлийн хувьд:

¹⁶⁶ 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 493, <http://old.shuukh.mn/irgendavah/289/view>

1. Хариуцагч Ү нь Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т “Засгийн газар Монгол Улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 7 дугаар зүйлийн 2-т “...Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана...” гэсэн үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх ямар ч арга хэмжээ аваагүй. Үүний улмаас Онгийн гол тасарч Улаан нуур ширгэсэн, мөн Завхан голын эх Хар ус болон Шар усны голуудад ашигт малтмал олборлох зөвшөөрөл өгч хараа, хяналт тавиагүйгээс эдгээр гол ширгэсэн. Улз гол нь 40-50 км газар усгүй болж хатаж ширгэсэн, Хангилцагийн голын цутгал, Түргэний гол ширгэж багассан, Туул голд цутгадаг 5 цутгал гол устаж үгүй болсон бодит хохирол учирсан байна.

2. АМТХ-д заасан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэгт хяналт тавьж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий сум, дүүргийн Засаг дарга болон БОАЖЯ нь чиг үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас дээрх хохирол байгаль орчинд учирсан. ИХ-ийн 498.2-т зааснаар “...төрийн албан хаагч, албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүйн) улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана” гэсний дагуу Монгол Улсын Засгийн газар хохирлыг хариуцах үндэслэлтэй гэж маргасан байна.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд

2.1. Сүхбаатар дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2011 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 447 тоот шийдвэр¹⁶⁷

Анхан шатны шүүхээс Х ТББ-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Дэлгэрүүлбэл, нэр бүхий голууд болон түүнээс эх авч урсдаг, цутгадаг голуудад тасарсан, ширгэсэн, бохирдсон, голдирлыг нь өөрчилсөн байдлаар экологийн тогтолцоог нь алдагдуулан хохирол учирсан нөхцөл байдал тогтоогдох боловч Монгол Улсын Засгийн газар нь Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хууль, БОХТХ-д зааснаар байгаль орчныг хамгаалахтай холбоотой нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй ба уг үүргээ биелүүлээгүй гэх

¹⁶⁷ Сүхбаатар дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2011 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр, дугаар 447 <http://old.shuukh.mn/irgenanhan/3652/view>

эс үйлдэхүй баримтаар тогтоогдохгүй байх бөгөөд 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын А-156 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу Онги, Завхан, Туул, Хүдэр, Улз, Ерөө, Гацууртын болон Хангилцагийн, голуудын сав газарт учирсан байгаль орчны хохирлын үнэлгээг Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын томилсон мэргэжлийн багаар болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх үүрэг сум, дүүргийн Засаг даргад байна. БОХТХ-ийн 49 дүгээр зүйлийн 1-д¹⁶⁸ заасны дагуу байгаль орчинд учирсан хохирлыг төлөх субъект нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

АМТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.3¹⁶⁹, 39.3¹⁷⁰ дахь хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол баталгааны хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулах эрхийг сум дүүргийн Засаг дарга, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгожээ. Эдгээр байгууллага, албан тушаалтан нь хэзээ, ямар байдлаар энэхүү хуульд заасан үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүй гаргаснаар ямар, ямар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжгүй болсон байдал баримтаар тогтоогдохгүй байна.

¹⁶⁸ 49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

¹⁶⁹ 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

¹⁷⁰ 39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

39.3. Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

Иймд Монгол Улсын Засгийн газраар голуудын сав газарт учирсан байгаль орчны хохирлыг барагдуулах боломжгүй байна.

2008 онд Өвөрхангай аймгийн Уянга суманд “Баяргоулд” ХХК алт олборлох үйл ажиллагаа явуулсан үйлдэлд болон УИХ-аас 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр баталсан хуулийн төслийг Х ТББ иргэдэд таниулах ажиллагаа хийх болсон нөхцөл байдалд хариуцагч Ү-г гэм буруутай гэж үзэх үндэслэлгүй байна. Иймд нэхэмжлэгч Х ТББ-ын хохирол 68,908,512 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийг хангах боломжгүй юм.

Гэрээ байгуулах нь талуудын хүсэл зоригийн илэрхийлэл тул шүүх талуудад гэрээ байгуулахыг даалгах хууль зүйн үндэслэлгүй. Ү нь тусгай зөвшөөрлийг цуцлах эрх бүхий этгээд биш байх тул “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан тогтоолыг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 15 хоногийн дотор гаргахыг даалгах хууль зүйн үндэслэлгүй байна” гэж дүгнэжээ.

2.2. Давж заалдах шатны шүүхийн 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 493 тоот магадлал¹⁷¹

Анхан шатны шүүх Ү-г хариуцагч биш гэж үзсэн нь буруу боловч нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий болжээ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаарх бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь байгаль, байгалийн баялгийг хамгаалах, эзэмших, ашиглахтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгаль экологийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан мөрдүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг эрх зүйн орчныг сайжруулах ажил хийж байгаа талаараа хариуцагч тайлбарласан нь хэргийн 1678-1681 дүгээр талд авагджээ. Монгол Улсын Засгийн газраас тухайн гол мөрөн, ойн сав газарт ашигт малтмалын үйл

¹⁷¹ 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 493, <http://old.shuukh.mn/irgendavah/289/view>

ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг зогсоож, газрын кадастрыг гаргах, ашиглалтын тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох, учруулсан хохирлыг тооцох аргачлалыг гаргах, нөхөн сэргээлтийн зардлыг тооцоолж гаргаж байгаа зэрэг ажлууд цаг хугацааны хувьд удаашралтай байгаа боловч тодорхой шат дараалалтайгаар явагдаж байгаа нь хэргийн баримтаар тогтоогдсон байна.

Харин хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа, нэхэмжлэлийн шаардлагад дурдсан нэр бүхий голуудын сав газарт учирсан байгаль орчны хохирлын үнэлгээ гараагүй байхад Ү нь энэ мэдээллийг нэхэмжлэгчид одоогоор өгөх боломжгүй юм. Үнэлгээг гаргахаар БОНБҮТХ-ийг Улсын Их Хуралд оруулж батлуулсан. Хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу эрх авсан мэргэжлийн байгууллагаар дээрх гол мөрний ай сав газарт учирсан хохирлыг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 156 дугаар тушаалд заасан аргачлалын дагуу тооцуулж гүйцэтгүүлэн, улмаар холбогдох зардлыг гэм буруутай этгээдээр БОХТХ-ийн 49, АМТХ-ийн 38, 39 дүгээр зүйлд зааснаар нөхөн төлүүлэх ажиллагаа хийгдэнэ гэж тайлбар гаргаснаас үзэхэд энэ ажлын явц, үр дүн нь Улсын Их Хуралд хамааралтай болохоос нэхэмжлэгч уг ажлыг хугацаа тогтоож биелүүлэхийг шаардах эрхгүй болно. Мөн голуудын сав газрын байгаль орчныг нөхөн сэргээх ажиллагааг нэхэмжлэгч Х ТББ-аар гэрээний үндсэн 8, 39 дүгээр зүйлд зааснаар нөхөн төлүүлэх ажиллагаа хийгдэнэ гэж тайлбар гаргаснаас үзэхэд энэ ажлын явц, үр дүн нь Улсын Их Хуралд хамааралтай болохоос

Иймд анхан шатны шүүх нэхэмжлэгч Х ТББ-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлтэй тул шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв гэжээ.

Гурав. Дүн шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д зааснаар “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага”, Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын Засгийн газар нь Үндсэн хууль болон бусад хуулийг биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангана”, Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т “Засгийн газар Монгол

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

улсын хуулийг биелүүлж, аж, ахуй, нийгэм соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж тус тус хуульчлан заасан байна. Мөн БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар төрийн бус олон нийтийн байгууллагууд нь “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс нь байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” болохыг, мөн зүйлийн 2 дахь хэсэгт байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд Засгийн газар болон байгаль орчныг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын нэгдэлтэй харилцан ажиллах зарчмын талаар зааж өгсөн байна. Төрийн бус байгууллагын тухай хуулийн (цаашид ТББтХ гэх) 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон төрийн нууцад үл хамаарах мэдээлэл төрийн бус байгууллагад нээлттэй байна” гэж заасан байна. Дээрх хуулийн заалтуудаас дүгнэхэд, хариуцагч Ү нь өөр өөрийн чиг үүргийг хэрэгжүүлж, ТББтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь хэсэгт зааснаар төрөөс ТББ-ын хууль ёсны эрхийг хангах, харин ТББ нь төрөөс хараат бус үйл ажиллагаа явуулах зарчимтай. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6-д зааснаар Засгийн газар нь үйл ажиллагааныхаа тайланг Улсын Их Хуралд тайлагнаж, танилцуулах журамтай бөгөөд нэхэмжлэлд дурдсан гол мөрөн, ай сав газрын бодит хохирлын үнэлгээ болон ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ-ийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хуралд гаргаж танилцуулаагүй байх ба уг ажлуудыг хэрэгжүүлж байна гэжээ. Нэхэмжлэлийн шаардлага нь агуулгын хувьд ТББтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4-т заасан мэдээлэл авах бус харин байгаль орчныг хамгаалах талаар Монгол Улсын Засгийн газрын хийх үйл ажиллагаа, ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ-ийн дагуу хийх Засгийн газрын үйл ажиллагаа, хэрэгжилтийг шаардсан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-д заасантай нийцээгүйгээс гадна нэхэмжлэгч нь ийм шаардлага гаргах эрхгүй байхаар харагдаж байна. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар Засгийн Газар нь үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээдэг.

Түүнчлэн “ГМУБЭУСБГХБОСБГАМХАХтХ-ийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан тогтоолыг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 15 хоногийн дотор гаргахыг даалгах тухай нэхэмжлэлийн хувьд, дээрх хуулийн хэрэгжилтийг биелүүлэхийг Засгийн газарт уг хуулиар нь үүрэг болгосон байх тул Засгийн газарт хуулиар хүлээлгэсэн үүргийг нь шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хэрэгжүүлэхийг шаардах эрх зүйн үндэслэл байхгүй юм.

Мөн дээрх голуудын сав газрын байгаль орчныг нөхөн сэргээх ажиллагааг нэхэмжлэгч Х ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг хариуцагчид даалгуулах нэхэмжлэлийн шаардлагын хувьд агуулгын хувьд алдаатай шаардлага гэж үзэхээр байна. Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага уг үүргийнхээ хүрээнд шүүхэд нэхэмжлэл гаргасан атлаа өөртэй нь гэрээ байгуулахыг даалгах шаардлага гаргаж буй нь бусад этгээдийн буюу гэрээний үндсэн дээр хамтран ажиллах сонирхол бүхий этгээдүүдийн эрх ашгийг хөндөж болзошгүй байна. Түүнчлэн уг маргаантай хамт сонгон шалгаруулалтын маргаан явагдаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтын үндсэн дээр гэрээ байгуулан ажиллах этгээдийг сонгох, гэрээ байгуулахыг даалгах боломжгүй юм.

Маргааны хувьд хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр бодит үр дүн гаргахуйц асуудлыг хөндсөн хэдий ч шүүхийн шийдвэрийн дагуу бодит, хэрэгжихүйц, үр нөлөө бүхий шийдвэр гараагүй байна.

Судлаачийн хувьд бүх шатны шүүхийн шийдвэртэй хууль хэрэглээний асуудлаар бүрэн санал нийлж байгаа бөгөөд анхан шатны шүүх хуулийн зарим хэсгийг буруу тайлбарласныг давж заалдах шатны шүүхээс залруулан шийдвэрлэсэн байдал нь уг шийдвэр бүхэлдээ хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадсан гэж дүгнэхээр байна.

Дүн шинжилгээ 4. “Эрүүл байгаль, энх амьдрал, энэрэнгүй үйлс” НҮТББ-ын нэхэмжлэлтэй “Рэдхил Монголия” ХХК-д холбогдох шүүхийн маргаан¹⁷²

Нэг. Хэргийн агуулга

Нэхэмжлэгч “Эрүүл байгаль, энх амьдрал, энэрэнгүй үйлс” НҮТББ (цаашид нэхэмжлэгч Х ТББ гэх)-ийн зүгээс Канад Улсын хөрөнгө оруулалттай “Рэдхил Монголия” ХХК (цаашид хариуцагч Ү ХХК гэх)-ийг шаардлагатай тусгай зөвшөөрөл буюу усны зөвшөөрөл байхгүй, 2012 оны Байгаль хамгаалах төлөвлөгөө, 2012 оны тайлан, 2013 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны шинжилгээний төлөвлөгөөг батлуулалгүй хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан болон явуулж байгаа болохыг тогтоолгох, байгаль орчинд учруулсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоолгохын тулд “Чойбалсангийн охин” ХХК-иар хийлгэх байгаль орчны нарийвчилсан үнэлгээний төлбөр болох 1,300,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Нэхэмжлэлийг үндэслэл: хариуцагч Ү ХХК нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт 1231 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай боловч уг талбай нь Зэлтэр голын болон ойн хамгаалалтын бүстэй давхацсан байна. Энэ нь БОНХЯ-ны 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 6-2777 тоот албан бичигт “...Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт орших лиценз нь Засгийн газрын 194 дүгээр тогтоолоор баталсан ойн сан бүхий хилийн зааг, усан сан бүхий хилийн заагтай тус тус давхцалтай, мөн Зэлтэр голын хамгаалалтын бүстэй давхцалтай байна”, Усны газрын 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 4-592 тоот албан бичигт “...тусгай зөвшөөрөл бүхий талбай нь бүхэлдээ Зэлтэр хамгаалалтын бүсэд орсон тул ус ашиглуулах дүгнэлт гаргах боломжгүй” гэсэн албан бичгээр тогтоогдож байна. Гэтэл хариуцагч Ү ХХК Улаан-Овоогийн нүүрсний уурхайг ажиллуулж, олборлолт явуулан хууль зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсан гэж үзжээ.

¹⁷² Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн иргэний хэргийн шүүх хуралдааны шийдвэр, дугаар 3393, <http://www.shuukh.mn/irgenanhan/12719/view>

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд**Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 3393 дугаар шийдвэр¹⁷³**

Анхан шатны шүүхээс “Нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага үндэслэлгүй байна. Учир нь нэхэмжлэлийн шаардлагад дурдсан хариуцагч Ү ХХК-ийг шаардлагатай тусгай зөвшөөрөл буюу усны зөвшөөрөл, 2012 оны байгаль хамгаалах төлөвлөгөө, 2012 оны тайлан, 2013 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны шинжилгээний төлөвлөгөө зэргийг авсан болох нь хэрэгт авагдсан бичгийн баримтаар тогтоогдож байгаа бөгөөд нэхэмжлэгч Х ТББ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч Ү ХХК дээр очиж дээрх баримтуудтай танилцахад эдгээр зөвшөөрөл, тайлан, төлөвлөгөө байсан болох нь зохигчдын тайлбараар тогтоогдож байна. ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2¹⁷⁴, 38.1¹⁷⁵-д зааснаар нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлээ нотолсон баримтыг шүүхэд ирүүлээгүй байна. Хэрэгт авагдсан Байгаль орчин, ногоон хөгжлийн яам зэрэг эрх бүхий байгууллагуудаас хариуцагч Ү-д хүргүүлж байсан албан бичгүүдийг үндэслэн тус компанийг хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан гэж дүгнэх үндэслэлгүй. Түүнчлэн байгаль орчинд учруулсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоолгохын тулд “Чойбалсангийн охин” ХХК-иар хийлгэх байгаль орчны нарийвчилсан үнэлгээний төлбөр болох 1,300,000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан нь хууль зөрчсөн ажиллагааны улмаас ирээдүйд гарах зардал болох үнэлгээний төлбөр гаргуулахаар нэхэмжилж буй нь үндэслэлгүй бөгөөд БОХТХ-ийн 32

¹⁷³ Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн иргэний хэргийн шүүх хуралдааны шийдвэр, дугаар 3393, <http://www.shuukh.mn/irgenanhan/12719/view>

¹⁷⁴ 25 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн эрх, үүрэг
25.2. Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах үүрэг хүлээнэ:

25.2.2. шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх

¹⁷⁵ 38 дугаар зүйл. Нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх

38.1. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1¹⁷⁶-д хамаарахааргүй байна” гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Гурав. Дүн шинжилгээ

Шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болсон хариуцагч Ү ХХК-ийг үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрлүүд болох усны зөвшөөрөл, 2012 оны байгаль хамгаалах төлөвлөгөө, 2012 оны тайлан, 2013 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны шинжилгээний төлөвлөгөө нь хариуцагч Ү ХХК-д байгаа, нэхэмжлэгчээс нэхэмжлэлээ дэмжих нотлох баримтыг гаргаж өгөөгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Гэвч шүүхийн шийдвэрт зааснаар Ү ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт 1231 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Зэлтэр голын болон ойн хамгаалалтын бүстэй давхацсан эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй, мөн БОНХЯ-ны 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 6-2777 тоот албан бичигт “...Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт орших лиценз нь Засгийн газрын 194 дүгээр тогтоолоор баталсан ойн сан бүхий хилийн зааг, усан сан бүхий хилийн заагтай тус тус давхцалтай, мөн Зэлтэр голын хамгаалалтын бүстэй давхцалтай байна”, Усны газрын 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 4-592 тоот албан бичигт “...тусгай зөвшөөрөл бүхий талбай нь бүхэлдээ Зэлтэр хамгаалалтын бүсэд орсон тул ус ашиглуулах дүгнэлт гаргах боломжгүй” гэсэн албан бичгүүдийг хариуцагчид хандан хүргүүлсэн албан бичиг тул нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болохгүй гэж дүгнэсэн нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангаагүй гэж үзэхээр байна.

¹⁷⁶ 32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

1/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах

Иргэний хэргийн шүүхийн хувьд чухал ач холбогдолтой гэж үзсэнээс бусад тохиолдолд талуудын гаргасан нотлох баримтыг үндэслэн нэхэмжлэлийн хүрээнд хэргийг хянан хэлэлцдэг бөгөөд Захиргааны хэргийн шүүхийн адил нотлох үүргийг шүүх хүлээдэггүй. Гэвч тус шүүхийн шийдвэрийн хувьд төрийн захиргааны төв байгууллагын зүгээс тус хэргийн оролцогчид хүргүүлсэн албан бичгийг нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл, түүнийгээ нотлох баримт болохгүй хэмээн дүгнэсэн нь учир дутагдалтай байна. Төрийн байгууллагын зүгээс аливаа иргэн, хуулийн этгээдэд итгэл төрүүлэн, эрх хэмжээнийхээ дагуу албан ёсоор мэдэгдэл хүргүүлсэн нь иргэн, хуулийн этгээдийн хувьд хууль ёсны нотлох баримт болох учиртай. Өөрөөр хэлбэл, уг албан бичгийг нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ нотлох баримт болохгүй гэж дүгнэх бус нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болж, тус хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хэр ач холбогдолтой байх эсхүл огт ач холбогдолгүй байх талаас нь шүүх үндэслэл бүхий тайлбарыг хийгээгүй байна. Шүүхийн хувьд тухайн албан бичгийг нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болохгүй хэмээн тайлбарлах бус нэхэмжлэлийн шаардлагыг хангалгүй орхиход хэрхэн үнэлсэн талаас нь дүгнэлт өгөх байжээ.

Харин байгаль орчны нарийвчилсан үнэлгээний төлбөр болох 1,300,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн үндэслэлтэй санал нийлж байна. Иргэний хэргийн шүүхийн хувьд аливаа байдлаар ирээдүйд учирч болох асуудлын талаар дүгнэлт өгдөггүй (хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд) бөгөөд үр дагаврыг шийдвэрлэдэггүй онцлогтой.

Шүүхийн зүгээс хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн судлаагүй, өөрийн хүлээсэн үүргээ биелээгүй буюу хэргийн нөхцөлд байдалд чухал ач холбогдол бүхий ажиллагааг хийгээгүй гэж үзэхээр байна.

Маргааны агуулгын хувьд нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалахад чухал үр дүнтэй байх байсан хэдий ч нэхэмжлэгчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлээ зөв тодорхойлоогүй, хариуцагч талаас гаргасан баримттай танилцаад нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлээ өөрчлөөгүй нь бодит байдалд үр дүнгүй ажиллагаа болжээ.

Судлаачийн хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийн хувьд хэргийг бүрэн дүүрэн судлаагүй буюу хууль байх ёсны байх шаардлагыг хангаагүй гэж үзэхээр байна.

Дүн шинжилгээ 5. Прокурорын газрын нэхэмжлэлтэй нэр бүхий иргэдэд холбогдох байгаль орчинд учруулсан хохиролд нөхөн төлбөр гаргуулахыг хүссэн иргэний хэрэг¹⁷⁷

Нэг. Хэргийн агуулга

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Тамч багт оршин суух нэр бүхий иргэд бүлэглэн үйлдвэрийн зориулалттай ашигт малтмал болох гялтгануур чулууг тусгай зөвшөөрөлгүйгээр олборлож, байгаль орчинд 1,808,100 төгрөгийн хохирол учруулсан болох нь тус аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогджээ. Уг шийтгэх тогтоолд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаар хэлэлцээгүй тул нотлох баримтаа бүрдүүлэн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хохирлоо нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээсэн байна. Иймд хариуцагч Д.А, Н.М, С.Б, Ш.Т нараас (хариуцагч Ү нар гэх) 1,808,100 төгрөг гаргуулж, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг хохиролгүй болгож өгнө үү гэсэн нэхэмжлэлийг тус аймгийн Прокурорын газар гаргажээ.

Хоёр. Шүүхийн шийдвэрүүд

Анхан шатны шүүхийн шийдвэр

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Тодруулбал:

1. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасныг тус тус баримтлан хариуцагч Ү нарт холбогдуулан гаргасан үйлдвэрийн зориулалтын гялтгануур чулууг тусгай зөвшөөрөлгүйгээр олборлож байгаль орчинд учруулсан хохиролд 1,808,100 төгрөг гаргуулахыг хүссэн Говь-Алтай аймгийн Прокурорын газрын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.
2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т¹⁷⁸ зааснаар нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамжаас

¹⁷⁷ 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, дугаар 133 <http://new.shuukh.mn/irgenanhan/88719/view>

¹⁷⁸ 41 дүгээр зүйл. Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх 41.1. Шүүхэд гаргасан дараах нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө: 41.1.3. төсвийн

чөлөөлөгдсөн болохыг дурдсугай.

Энэхүү шийдвэрийн үндэслэлийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцээнд оролцож байгаа төрийн байгууллага өөрийн шүүхэд гаргавал зохих бичмэл нотлох баримтыг өөрөө баталгаажуулан шүүхэд гаргах боломжгүй юм. Учир нь төрийн байгууллага өөрөө мэтгэлцээний оролцогч тул шаардлагаа нотлохоор гаргасан баримтыг өөрөө баталгаажуулан гаргах нь шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэхгүй бөгөөд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүнийг болон хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй байх, эрх тэгш байх зарчимд үндэслэн явагддаг.
2. Хариуцагч Ү нарыг Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 37 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт¹⁷⁹ заасан хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон байх ба гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаар хэлэлцээгүй байх бөгөөд хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан 2583 кг гялтгануур чулууг улсын орлого болгож шийдвэрлэсэн байна.
3. Дээрх шийтгэх тогтоолоор хариуцагч Ү нарыг хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон байх бөгөөд уг гэмт хэргийн улмаас хохирогчид буюу байгаль орчинд хохирол учруулсан болохыг тогтоогоогүй байна. Өөрөөр хэлбэл, хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд

байгууллагын нэхэмжлэл

¹⁷⁹ 24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 1. Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (Энэ хэсэгт 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан).

хохирол учирсан болох нь хэргийн үйл баримтаар нотлогдон тогтоогдохгүй байна.

4. Гэм хор учирснаас хариуцлага хүлээх үндэслэл нь хохирогчид гэм хор учруулсан хууль бус үйлдэл, уг үйлдэл болон учирсан гэм хорын хоорондох шалтгаант холбоо тогтоогдсон байх явдал бөгөөд бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй гэж Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан.
5. Нэхэмжлэгч уг эрүүгийн гэмт хэргийн улмаас байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр буруутай этгээдээс шаардах эрхтэй боловч байгаль орчинд учирсан гэх хохирол хариуцагч нарын гаргасан гэм буруутай үйлдэлтэй шалтгаант холбоотой тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэл хангагдах хууль зүйн үндэслэл болно.
6. Нэхэмжлэгчийн гаргасан бичгийн нотлох баримтууд нь хуульд заасан бичгийн нотлох баримтын шаардлага хангаагүй байх бөгөөд хариуцагч нар гэмт хэргийн улмаас байгаль орчинд 1,808,100 төгрөгийн хохирол учруулсан болох нь хэргийн үйл баримтаар нотлогдон тогтоогдохгүй байх тул нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх үндэслэлтэй.
7. Улсын тэмдэгтийн хураамжийн тухайд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага хуульд зааснаар улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгддөг болохыг дурдах нь зүйтэй.

Гурав. Дүн шинжилгээ

3.1. Байгаль орчны хэрэг дээрх Прокурорын нэхэмжлэл гаргах эрхийн тухайд

Дүн шинжилгээ хийж буй хэрэгт “...Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь хариуцагч иргэн Ү нарт холбогдох иргэний хэргийн шүүх хуралд тус газрыг төлөөлж прокурорыг томилох тухай 153 дугаартай албан бичгийг Говь-Алтай аймгийн Прокурорын газарт 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдөр гаргасан ...” гэж тэмдэглэсэн байх тул тус хэрэг дээр нэхэмжлэгч

Прокурорын газар нь Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэг Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан гэж үзэхээр байна.

ИХХШТХ-ийн 31 дүгээр зүйлд зааснаар Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно гэж заасан¹⁸⁰. Мөн 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Прокурорын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар Прокурор хуульд заасан тохиолдолд захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно¹⁸¹. Түүнчлэн Прокурор нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох юм. Хэрэв Прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцох журамтай¹⁸².

¹⁸⁰ 31 дүгээр зүйл. Прокурор, бусдын эрхийг хамгаалж байгаа этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох

31.1. Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно. 31.2. Бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу оролцож болно. 31.3. Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос, эсхүл гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй.

¹⁸¹ 17 дугаар зүйл. Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох 17.1. Прокурор хуульд заасан тохиолдолд дараах шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно: 17.1.1. зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх; 17.1.2. эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх; 17.1.3. захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх.

¹⁸² 20 дугаар зүйл. Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах 20.1. Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно. 20.2. Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй. 20.3. Прокурор

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

Дээрх хуулийн зохицуулалтыг дүн шинжилгээ хийж буй хэргийн нөхцөлд авч үзвэл, Говь-Алтай аймгийн Прокурорын газар нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэн тус аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хүсэлтийн дагуу иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гарган оролцсон гэж дүгнэхээр байна. Харин нэхэмжлэгч Говь-Алтай аймгийн Прокурорын газар байгаль орчинд хохирол учруулсантай холбоотой асуудал яригдаж байгаа тул нийтийн ашиг сонирхолд зөрчигдсөн гэдэг үндэслэлээр төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэж тайлбарлах боломжтой. Зүй нь шүүхээс тусгай зөвшөөрөлгүйгээр гялтгануур чулууг олборлож байгаль орчинд 1,808,100 төгрөгийн хохирол учруулсан тул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг хохиролгүй болгож өгнө үү гэсэн Прокурорын газрын нэхэмжлэл гаргах эрхийн үндэслэлийг шалгаж, дээр дурдсан хуулийн зохицуулалтын чухам ямар үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд гэж үзсэн болохыг тайлбарласан бол илүү үндэслэл бүхий шийдвэр болох байжээ. Төгсгөлд нь Прокурорын байгууллагын зүгээс төрийн болон нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл захиргааны болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцох нь илэрхий Үндсэн хуулийн зөрчилтэй, хуучин “ерөнхий хяналт”, прокурор “шүүхийн шүүн таслах ажиллагаанд хяналт тавих” эрх хэмжээг агуулгаар нь дахин сэргээх хандлагатай хуулийн зохицуулалт болсон гэж үзэх судлаач буйг тэмдэглэх нь зүйтэй¹⁸³. Түүнчлэн “нийтийн ашиг сонирхол” хэмээх ойлголт нь цаг үеэ даган хувьсан өөрчлөгддөг ойлголт тул хуулиар шууд, тодорхой тайлбар хийх нь зохимжгүй байдаг¹⁸⁴ тул дүн шинжилгээ хийж буй хэргийн хувьд гялтгануур чулууг тусгай зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар түүсэн нь байгаль

иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. 20.4. Прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцоно.

¹⁸³ Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019 он, 66 дахь тал.

¹⁸⁴ Эрх зүйн боловсрол академи, Ханнс-Зайделийн сан, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, УБ., 2018 он, 182 дахь тал. https://mongolia.hss.de/fileadmin/user_upload/Projects_HSS/Mongolia/Dokumente/2018/Zakhirgaanii_yerenkhii_huuli_sudalгаа_niit.pdf

орчинд хохирол учруулсан, улмаар нийтийн ашиг сонирхолд харшилсан үйлдэл болсон гэж үзэхэд судалгаатай хандах хэрэгтэй.

3.2. Нэхэмжлэгч Прокурорын газрын нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн үндэслэлийн тухайд

Дүн шинжилгээ хийж буй шийдвэрийн тогтоох хэсэгт “...Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн болохыг дурдсугай” гэжээ. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтад “Шүүхэд гаргасан дараах нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө: төсвийн байгууллагын нэхэмжлэл” гэж заасан тул нэхэмжлэгч Говь-Алтай аймгийн Прокурорын газрыг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн байна.

Мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.14 дэх заалтад “прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн иргэний болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлүүлэхээр гаргасан нэхэмжлэл”-ийн хувьд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө гэж заажээ.

Судлаачийн хувьд дүн шинжилгээний эхний хэсэгт Говь-Алтай аймгийн Прокурорын газар нь төрийн ашиг сонирхол зөрчигдсөн хэрэг дээр тус аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хүсэлтээр иргэний хэргийн нэхэмжлэл гаргасан гэж дүгнэлтэд хүрсэн билээ. Иймд дүн шинжилгээ хийж буй хэргийн хувьд Говь-Алтай аймгийн Прокурорын газар нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлүүлэхээр гаргасан нэхэмжлэл гэж үзэх үндэслэлтэй тул улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх үндэслэл нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3 болон 41.1.14 дэх заалт байх үндэслэлтэй. Гэтэл дүн шинжилгээ хийж буй шийдвэрийн тогтоох хэсэгт Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтыг үндэслэсэн нь дутагдалтай болжээ.

ДӨРӨВ. ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд байгаль орчин, түүний бохирдолтой холбоотой шүүхийн шийдвэрийг захиргааны хэрэг, иргэний хэрэг, хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан захиргааны хэрэг гэсэн үндсэн гурван төрөлд хуваан нийт 15 шүүхийн шийдвэрийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болно. Ихэнх хэргийн хувьд Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар эцэслэн шийдвэрлэгдсэн хэрэг байх хэдий ч зарим хэргийн хувьд шүүхийн эцсийн шийдвэр нь хараахан гараагүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж буй шийдвэр багтсан болохыг анхаарах нь зүйтэй.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ тус бүрд тухайн хэрэгт хамаарал бүхий судлаачийн дүгнэлтийг оруулсан байх тул доорх хэсэгт энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хэмээх судалгааны ажлыг боловсруулахад нийтлэг ажиглагдаж буй асуудлыг дараах байдлаар тоймлон үзэх боломжтой байна. Үүнд:

- Байгаль орчин, хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн ТББ-ын зүгээс нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй байхаар хуульчилсан хэдий ч бодит байдалд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан ТББ-ын нэхэмжлэлийн шаардлага хангагдсан тохиолдол цөөн байгаа нь манай улсын хувьд дээрх асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй хэргийн бодит үр нөлөө, үйлчлэл ямар түвшинд байгаа тухайд судлан тогтоох шаардлагатай гэж үзэхээр байна. Тодруулбал, БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 2016 онд батлагдсан ЗХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.9 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтад үндэслэн байгаль орчинд учирсан хохирол, хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн

шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй хуульчилсан хэдий ч шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан ТББ-ын нэхэмжлэлийн шаардлага хангагдсан тохиолдол цөөн байна. ТББ-аас байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжилж, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу тэрхүү нэхэмжлэл хангагдсан тохиолдол нь “Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ-ын нэхэмжлэлтэй, хариуцагч “Петрочайна дачин тамсаг” ХХК-д холбогдох иргэний хэргээр хязгаарлагдаж байна. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан ТББ-ын нэхэмжлэлтэй хэргийн хувьд анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн боловч тухайн маргааны давж заалдах шатны шүүх хуралдаан эсхүл хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолоор нэхэмжлэгч ТББ-ын нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхих, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох зэрэг тохиолдол их байна.

- ЗХШХШТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдсанаар нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол бодитоор зөрчигдсөн зүйл байхгүй ч зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломж нээлттэй болсонтой холбоотойгоор цаашид зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд ямар онцлог нөхцөл үүсэж болох тухайд судалгаа хийх шаардлагатай.
- Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа зөв тодорхойлоогүй тохиолдол цөөнгүй байна. Аль ч шатны шүүхийн хувьд аливаа хэрэг маргааныг нэхэмжлэгчийн тодорхойлсон нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хянан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд уг шаардлагаас хальсан дүгнэлтийг гаргах нь хуулиар хориотой юм. Иймд нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагаа зөв тодорхойлох, нэхэмжлэлийн шаардлага ойлгомжтой байснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах, талуудын мэтгэлцэх эрх хангагдах гол нөхцөл нь болдог. Гэтэл

нэхэмжлэгчийн зүгээс нэхэмжлэлийн шаардлага нь тодорхойгүй, ойлгомжгүй, хариуцагч этгээдийн бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар нэхэмжлэл гаргах зэрэг тохиолдол цөөнгүй байгаа бөгөөд энэ нь нэг талаар нэхэмжлэгчийн зүгээс эрх зүйн хангалттай мэдлэггүйн улмаас үүсэж байгаа асуудал гэж үзэхээр байна.

- Иргэний хэргийн шүүхийн хувьд талуудын цуглуулсан нотлох баримтын хүрээнд маргааныг хянан шийдвэрлэдэг бол Захиргааны хэргийн шүүх нь өөрөө нотлох баримтыг цуглуулдаг онцлогтой. Гэтэл зарим хэргийн хувьд Захиргааны хэргийн шүүхийн зүгээс хуулиар хүлээсэн үүрэг болох нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх үүргээ хангалттай биелүүлэхгүй байгаа бөгөөд дутуу цугласан баримтын хүрээнд хэргийн хянан шийдвэрлэж байгаа нь тухайн шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчимтай харшилдахад хүргэж байна.
- Шүүхийн зүгээс хууль хэрэглээний хувьд алдаа гаргах тохиолдол багагүй байна. Тухайлбал, Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах тухай маргааны хувьд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн зүгээс АМТХ-ийг хэт явцууруулан тайлбарласан тохиолдол дүн шинжилгээний явцад ажиглагдаж байсан. Хэдийгээр анхан шатны шүүх хууль хэрэглээний хувьд алдаа гаргасан тохиолдолд дээд шатны шүүхээс уг алдааг залруулах боломжтой хэдий ч шүүхийн шийдвэр аль ч шатандаа үндэслэл бүхий бөгөөд алдаагүй гарах учиртай. Анхан шатны шүүхийн шийдвэрт дээд шатны шүүхийн зүгээс өөрчлөлт оруулж хэргийг эцэслэн шийдвэрлэсэн тохиолдол мөн цөөнгүй байна. Харин анхан шатны шүүхийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны буюу процессын алдаа гаргасан тохиолдолд дээд шатны шүүхээс үүнийг залруулах боломжгүй болж тус хэргийг дахин анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс өөр аргагүйд хүрдэг. Энэ нь шүүхийн үйл ажиллагааг хэт сунжруулах сөрөг үр дагавартай гэж үзэхээр байна. Тухайлбал, анхан шатны шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагыг тодруулаагүй, хэргийн оролцогчдод эрх үүрэг танилцуулаагүй, гэрч асуулгах хүсэлтийг шийдвэрлээгүй зэрэг процессын алдаа гаргасан байх

ба үүнийг давж заалдах журмаар нөхөн гүйцэтгэх боломжгүй учир хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан шийдвэрүүд байгаа болно.

Тус дүн шинжилгээг хийх явцад дээрх нийтлэг зүйлс ажиглагдаж байх бөгөөд эдгээр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, үндэслэлгүй шийдвэр гарч холбогдох этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг ноцтойгоор зөрчигдөх эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Иймд, нэхэмжлэгч этгээдийн эрх зүйн ойлголт, хууль зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай. Тухайлбал, байгаль орчныг хамгаалах чиглэл бүхий ТББ-ын хувьд энэ чиглэлээр төлөөлөн нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн шаардлага, шүүхээр гаргуулахыг хүссэн шийдвэр зэргээ холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зөвөөр тодорхойлох нь зүйтэй.

Мөн шүүхийн зүгээс хууль хэрэглээний тал дээр мэргэших буюу хуулийг явцуу утгаар бус агуулгын хувьд салаа утгагүй байхаар тайлбарлан хэрэглэх шаардлагатай байна. Нөгөө талаар, шүүхийн хувьд аль ч маргааныг хянан шийдвэрлэхэд процесс ажиллагааг хуулийн хүрээнд хийх шаардлагатай хэдий ч хэт хайхрамжгүй хандан алдаа гаргаж буй тохиолдлыг багасгах нь зүйтэй. Шүүхийн аливаа шийдвэрийн үндсэн дээр бусад этгээдийн хууль ёсны эрх, эрх ашиг сонирхол хөндөгдөх эсэх нь шийдэгддэг тул шүүхийн зүгээс хайхрамжгүй хандах тохиолдлыг бууруулахад анхаарах хэрэгтэй гэж үзлээ.

---оо0оо---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Захиргааны ерөнхий хууль, 2015 он.
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он.
4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он (Энэ хууль 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр хүчингүй болсон).
5. Иргэний хууль, 2002 он.
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
7. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он Ашигт малтмалын тухай хууль, 1997 он.
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он (Энэ хууль 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүчингүй болсон).
9. Ашигт малтмалын тухай хууль, 2006 он.
10. Газрын тухай хууль, 2002 он.
11. Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль, 1993 он.
12. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006 он.
13. Засгийн газрын сангийн тухай хууль, 2006 он.
14. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он.
15. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009 он.
16. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009 он.
17. Төрийн бус байгууллагын тухай хууль, 1997 он.
18. Прокурорын тухай хууль шинэчилсэн найруулга, 2017 он.
19. МУ-ын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 104 дүгээр тогтоол.
20. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2006 оны 7 дугаар

- сарын 3-ны өдрийн 37 дугаар тогтоол, <https://www.legalinfo.mn/judicare/details/75?lawid=284>.
21. Эрх зүйн боловсрол академи, Ханнс-Зайделийн сан, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, УБ., 2018 он. https://mongolia.hss.de/fileadmin/user_upload/Projects_HSS/Mongolia/Dokumente/2018/Zakhirgaanii_yerenkhii_huuli_sudalgaa_niit.pdf.
 22. Ц.Цогт “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, Захиргааны эрх зүйн өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2016 он.
 23. Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019 он.
 24. Р.Мөнхзул, Д.Баяр, Д.Бадамцэцэг, С.Билгүүн, Нээлттэй Нийгэм Форум, Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал (Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь зүйл заалтын агуулгын хүрээнд), УБ., 2019 он.
 25. Хайнрих Шоллер, Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний) Анхны хэвлэл, УБ., 2017 он.
 26. Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар (Судалгаа, хэрэглээний) Анхны хэвлэл, УБ., 2017 он.
 27. А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2014 он.
 28. О.Амархүү, Монголын орчин цагийн экологийн эрх зүй, хоёр дахь хэвлэл, УБ., 2009 он.
 29. П.Баттулга, Т.Мөнх-Эрдэнэ, Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, Нээлттэй Нийгэм Форум, Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, эмхэтгэл 1, УБ., 2018 он, 61 дэх тал. https://www.forum.mn/res_mat/2018/Shuukhiin_shiidveriin_analiz.pdf.
 30. Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (шүүгчид зориулсан гарын авлага), УБ., 2004 он.
 31. Ц.Цогт “Байгаль орчныг хамгаалах асуудалд захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо”, Захиргааны эрх зүй, өгүүлэл,

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

- нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2016 он.
32. Ц.Цогт “Ашигт малтмалын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх”, Захиргааны эрх зүй, өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл, УБ., 2016 он.
 33. 吉村良一 『公害・環境訴訟講義』 (法律文化社、2018).
 34. Ёошимүра Риёоичи, Байгаль орчны бохирдол, хүрээлэн буй орчны нэхэмжлэлийн лекц, Хорицү бункаша хэвлэл, 2018 он, 50 дахь тал.
 35. С.Сүхчулуун, Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт заасан шаардах эрхийн хүрээг өргөжүүлэх нь (Байгаль орчны бохирдолтой холбоотой хэрэг маргаан дээр хэрэглэх боломж), Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2019 оны 1 дүгээр улирлын дугаар. <http://www.judoinstitute.mn/main/238--2019-.html>.
 36. Япон Улсын цахим Засгийн газрын нэгдсэн портал вэб сайт, https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=343AC0000000097#392.
 37. Япон Улсын цахим Засгийн газрын нэгдсэн портал вэб сайт, https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=345AC0000000138#222.
 38. Япон Улсын цахим Засгийн газрын нэгдсэн портал вэб сайт, https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=325AC0000000289#663.

Ашигласан шүүхийн шийдвэрүүд

1. 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 540, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1160/view>.
2. 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 0750 <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1673/view>.
3. 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.09.07 Дугаар 60, <http://new.shuukh.mn/zahirgaahanhan/3642/view>.
4. 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 382, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/962/view>.
5. 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, Дугаар 253, <http://>

- new.shuukh.mn/zahirgaanhan/3125/view.
6. Монгол Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн 2019 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 23 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1696/view>.
 7. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн магадлал, дугаар 221/МА2018/0630 <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2544/view>.
 8. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэр, дугаар128/ШШ2018/644 <http://new.shuukh.mn/zahirgaanhan/5298/view>.
 9. 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, Дугаар 40, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/4287/view>.
 10. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн магадлал, дугаар 221/МА2018/0510, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2463/view>.
 11. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 11 сарын 14-ний өдрийн тогтоол, дугаар 0458, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1663/view>.
 12. 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 221 /МА2017/0487, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1288/view>.
 13. 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, Дугаар 255, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3126/view>.
 14. 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 532, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1164/view>.
 15. 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 0710, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1500/view>.
 16. 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 540 <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1160/view>.
 17. 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 0750 <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1673/view>.

18. 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, дугаар 60, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3642/view>.
19. 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 532, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1164/view>.
20. 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, Дугаар 0710, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1500/view>.
21. 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр, Дугаар 448, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3758/view>.
22. 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Улсын дээд шүүхийн Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, дугаар 185. <http://old.shuukh.mn/zahirgaahyanalt/1420/view>.
23. 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, дугаар 88. <http://judgment.admincourt.gov.mn/uploads/2009.02.19.88%20Erdene.pdf>.
24. 2009 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, дугаар 146. <http://judgment.admincourt.gov.mn/uploads/2009.04.28.146.N.ERDENE.pdf>.
25. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэр, дугаар 539 <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1598/view> 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх хуралдааны шийдвэр, дугаар 854, <http://old.shuukh.mn/irgenanhan/33602/view>.
26. 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлал, дугаар 519, <http://old.shuukh.mn/irgendavah/1328/view>.
27. 2012 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн Улсын дээд шүүхийн Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, дугаар 563, <http://old.shuukh.mn/irgenhyanalt/554/view>.
28. Сүхбаатар дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2013 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн шийдвэр, дугаар 1542 <http://old.shuukh.mn/irgenanhan/68078/view>.

29. Нийслэлийн шүүхийн иргэний шүүх хуралдааны 2013 оны 12 сарын 11-ний өдрийн магадлал, дугаар 965, <http://old.shuukh.mn/irgendavah/2786/view>.
30. Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн иргэний хэргийн шүүх хуралдааны шийдвэр, дугаар 3393, <http://www.shuukh.mn/irgenanhan/12719/view>.
31. Сүхбаатар дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2011 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр, дугаар 447 <http://old.shuukh.mn/irgenanhan/3652/view>.
32. Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны магадлал, дугаар 493, <http://old.shuukh.mn/irgendavah/289/view>.

**Дүн шинжилгээ хийхээр сонгосон шүүхийн шийдвэрийн
хялбарчилсан хүснэгт**

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр 1¹⁸⁵

	Анхан шатны шүүх ¹⁸⁶	Давж заалдах шатны шүүх ¹⁸⁷	Хяналтын шатны шүүх ¹⁸⁸
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2017.09.07 Дугаар 60	2017.10.25 Дугаар 0750	2017.12.20 Дугаар 540
Шүүх	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Чулуунбаатарын Цэнд-Очир	Ганзоригтын Билгүүн	Бямбаагийн Мөнхтуяа
Нэхэмжлэгч	Чулуун цаг ХХК	Чулуун цаг ХХК	Чулуун цаг ХХК
Хариуцагч	Завхан аймгийн Сантмаргац сумын Засаг дарга	Завхан аймгийн Сантмаргац сумын Засаг дарга	Завхан аймгийн Сантмаргац сумын Засаг дарга
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч Чулуун Цаг ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй байгаа хариуцагч Завхан аймгийн Сантмаргац сумын Засаг	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 60 дугаар шийдвэрийн	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 221/МА2017/0750 дугаар магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

¹⁸⁵ Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

¹⁸⁶ <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3642/view>

¹⁸⁷ <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1673/view>

¹⁸⁸ <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1160/view>

даргын	Тогтоох
татгалзал хууль	хэсгийн 1 дэх
бус болохыг	заалтаас “22
тогтоож,	дугаар зүйлийн
нэхэмжлэгч	22.1, 22.1.3”
Чулуун Цаг	гэснийг хасаж,
ХХК-ийн	шийдвэрийн
байгаль орчны	бусад заалтыг
менежментийн	хэвээр үлдээж,
төлөвлөгөөг	хариуцагчийн
батлахыг	итгэмжлэгдсэн
хариуцагч	төлөөлөг-
Завхан аймгийн	чийн гаргасан
Сантмаргаз	давж заалдах
сумын	гомдлыг
Засаг даргад	хангахгүй
даалгасугай.	орхисугай.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр 2¹⁸⁹

	Анхан шатны шүүх ¹⁹⁰	Давж заалдах шатны шүүх ¹⁹¹
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2017.04.10 Дугаар 255	2017.07.04 Дугаар 221/МА2017/0487
Шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
Шүүгч	Оюунбатын Оюунгэрэл	Бямбаагийн Тунгалагсайхан
Нэхэмжлэгч	С.Доржпүрэв	С.Доржпүрэв
Хариуцагч	АМГТГКХ	АМГТГКХ
Гуравдагч этгээд	Шинэ сансар ХХК	
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	АМТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1, 25 дугаар зүйлд заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч С.Доржпүрэвийн “Ашигт малтмалын газрын харьяа ГУУКХ-ийн даргын 2009 оны 09 сарын 18-ны өдрийн 720 тоот тушаалыг хүчингүй болгох, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Угдайн дунд ус гэх газарт алтны олборлолт эрхэлж буй Шинэсансар ХХК-д олгосон 15170А дугаартай тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 128/ШШ2017/0255 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

¹⁸⁹ Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

¹⁹⁰ <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3126/view>

¹⁹¹ <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1288/view>

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр-3¹⁹²

	Анхан шатны шүүх ¹⁹³	Давж заалдах шатны шүүх ¹⁹⁴	Хяналтын шатны шүүх ¹⁹⁵
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2017.06.07 Дугаар 448	2017.10.04 Дугаар 0710	2017.12.18 Дугаар 532
Шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Лхагвадуламын Батбаатар	Цолмонгийн Сайхантуяа	Лхүндэвийн Атарцэцэг
Нэхэмжлэгч	Б.Болорчулуун, Х.Эрдэнэбилэг, Д.Баттөр, Н.Мөнхсайхан, Ю.Бизьяа, Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг дарга нар	Б.Болорчулуун, Х.Эрдэнэбилэг, Д.Баттөр, Н.Мөнхсайхан, Ю.Бизьяа, Баянхонгор аймгийн Жаргалант сумын ИТХ, сумын Засаг дарга нар	Б.Б нар
Хариуцагч	АМГТГКХ	АМГТГКХ	АМГТГКХ
Гуравдагч этгээд	Оргил моунт ХХК Монголын алт ХХК	Оргил моунт ХХК Монголын алт ХХК	Оргил моунт ХХК Монголын алт ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын 2010 оны 8 дугаар	1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 128/ШШ2017/0448 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын “..020624 тоот	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 128/ШШ2017/0448 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн

¹⁹² Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

¹⁹³ <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3758/view>

¹⁹⁴ <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1500/view>

¹⁹⁵ <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1164/view>

сарын 31-ний өдрийн 930 дугаар шийдвэр, түүнийг үндэслэн олгосон МҮ-015651 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр шийдвэр, МҮ-020624 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг илт хууль бус болохыг тогтоосугай.	ашиглалтын тусгай зөвшөөрлийг илт хууль бус болохыг тогтоосугай” гэснийг “... “Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр олгогдсон МҮ-020624 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг тус тус илт хууль бус болохыг тогтоосугай” гэж өөрчлөн шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж, гуравдагч этгээд “М А” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Ж, “О” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Ц нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.	давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 221/МА2017/0710 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.1.7, 26 дугаар зүйлийн 26.3.2, 49 дүгээр зүйлийн 49.3, 49.6.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.5 дахь хэсэгт тус тус заасныг баримтлан Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 930 дугаар шийдвэр, түүнийг үндэслэн олгосон МҮ-015651 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл, 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр шийдвэр, 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар шийдвэрээр олгогдсон МҮ-020624 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг тус тус илт хууль бус болохыг тогтоолгох тухай иргэн Б.Б, Х.Э, Д.Б, Н.М, Ю.Б нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.
---	--	--

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр-4¹⁹⁶

	Анхан шатны шүүх ¹⁹⁷	Хяналтын шатны шүүх ¹⁹⁸
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2017.04.10 Дугаар 253	2017.10.18 Дугаар 382
Шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Оюунбатын Оюунгэрэл	Бямбаагийн Мөнхтуяа
Нэхэмжлэгч	Ж.Батбаяр	Ж.Батбаяр
Хариуцагч	Ашигт малтмал, газрын Кадастрын хэлтсийн дарга	Ашигт малтмал, газрын Кадастрын хэлтсийн дарга
Гуравдагч этгээд	Эф Эм Ай ХХК, Намуун тод ХХК, Мөнхийн номхон далай ХХК, Эн Си Ар Ай ХХК, Элбэг орд ХХК	Эф Эм Ай ХХК, Намуун тод ХХК, Мөнхийн номхон далай ХХК, Эн Си Ар Ай ХХК, Элбэг орд ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч Ж.Батбаярын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Дэжидийн “Эф Эм Ай” ХХК-ийн ХҮ-012472, “Намуун тод” ХХК-ийн ХҮ-013107, ХҮ-013108, “Мөнхийн номхон далай” ХХК-ийн ХҮ-013109, “Эн Си Ар Ай” ХХК-ийн ХҮ-014879, “Элбэг орд” ХХК-ийн ХҮ-014145 дугаар тусгай зөвшөөрлүүдийг цуцлахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгах” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 221/МА2017/0439 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

Тайлбар: Тус хэргийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 221 магадлал нь шүүхийн шийдвэрийн цахим санд байршаагүй байна.

¹⁹⁶ Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

¹⁹⁷ <http://new.shuukh.mn/zahirgaanhan/3125/view>

¹⁹⁸ <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/962/view>

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр-5¹⁹⁹

	Анхан шатны шүүх ²⁰⁰	Давж заалдах шатны шүүх ²⁰¹	Хяналтын шатны шүүх ²⁰²
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2009.02.19 Дугаар 88	2009.04.28 Дугаар 146	2009.10.19 Дугаар 185
Шүүх	Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх	Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Д.Дамдиндорж	Л.Атарцэцэг	Оросоогийн Зандраа
Нэхэмжлэгч	Н.Эрдэнэ	Н.Эрдэнэ	Н.Эрдэнэ
Хариуцагч	Баянзүрх дүүргийн Засаг дарга	Баянзүрх дүүргийн Засаг дарга	Баянзүрх дүүргийн Засаг дарга
Гуравдагч этгээд	“Туулривер контри сайд” ХХК	“Туулривер контри сайд” ХХК	“Туулривер контри сайд” ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч Н.Эрдэнийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 130 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 41-д заасан “Туул ривер контри сайд” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.	Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 88 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтад “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг” гэж нэмж, бусад заалтыг хэвээр үлдээсүгэй.	Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 88 дугаар шийдвэр, Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдааны 2009 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 146 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангахгүй орхисугай

Тайлбар: Шүүхийн шийдвэрийн цахим санд зөвхөн Улсын дээд шүүхийн шийдвэр байршсан байсан тул анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн цахим сан болох <http://judgment.admincourt.gov.mn> цахим хуудаснаас татаж авсан болно.

¹⁹⁹ Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

²⁰⁰ <http://judgment.admincourt.gov.mn/uploads/2009.02.19.88%20Erdene.pdf>

²⁰¹ <http://judgment.admincourt.gov.mn/uploads/2009.04.28.146.N.ERDENE.pdf>

²⁰² <http://old.shuukh.mn/zahirgaahyanalt/1420/view>

Хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг-1²⁰³

	Анхан шатны шүүх ²⁰⁴	Давж заалдах шатны шүүх ²⁰⁵	Хяналтын шатны шүүх ²⁰⁶
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2018.10.16 Дугаар 644	2018.12.12 Дугаар 221/ МА2018/0630	2019.01.28 Дугаар 23
Шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Лхагвадуламын Батбаатар	Ганзоригтын Билгүүн	Хөхийсүрэнгийн Батсүрэн
Нэхэмжлэгч	Онги голынхон хөдөлгөөн ТББ	Онги голынхон хөдөлгөөн ТББ	Онги голынхон хөдөлгөөн ТББ
Хариуцагч	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч “Онги голынхон хөдөлгөөн” ТББ-ын “Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг Бөөрөлжүүгийн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд учирсан хохирлыг тооцон гаргаж олон нийтэд мэдээлэхээс татгалзсан үйлдлийг хууль бус болохыг тогтоож, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 128/ШШ2018/0644 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн төлөөлөгч Ц.М-ын давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 128/ШШ2018/0644 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 221/МА2018/0630 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж,

²⁰³ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²⁰⁴ <http://new.shuukh.mn/zahirgaanhan/5298/view>

²⁰⁵ <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2544/view>

²⁰⁶ <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1696/view>

Бөөрөлжүүтийн
голын онцгой
болон энгийн
хамгаалалтын бүсэд
учирсан хохирлыг
тооцон гаргаж олон
нийтэд мэдээлэхийг
Байгаль орчин,
аялал жуулчлалын
яаманд даалгах”
шаардлага бүхий
нэхэмжлэлийг
бүхэлд нь
хэрэгсэхгүй
болгосугай.

нэхэмжлэгчийн
төлөөлөгчийн
хяналтын
журмаар гаргасан
гомдлыг хангахгүй
орхисугай.

Хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг-2²⁰⁷

	Анхан шатны шүүх ²⁰⁸	Давж заалдах шатны шүүх ²⁰⁹	Хяналтын шатны шүүх ²¹⁰
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2014.12.01 Дугаар 0568	2015.02.05 Дугаар 0078	2015.05.11 Дугаар 118
Шүүх	Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Мишигдоржийн Батзориг	Энхбатын Зоригтбаатар	Лхүндэвийн Атарцэцэг
Нэхэмжлэгч	“Хөвсгөл далайн эзэд” ТББ, иргэн Г.Даваачулуун, Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав нар	“Хөвсгөл далайн эзэд” ТББ	“Хөвсгөл далайн эзэд” ТББ, иргэн Г.Даваачулуун, Д.Мягмарчулуун, Ж.Базаррагчаа, О.Даваажав нар
Хариуцагч	Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга	Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэс	Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтэс
Гуравдагч этгээд	“Талст маргад” ХХК	“Талст маргад” ХХК	Талст маргад” ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	ЗХХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.7, 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасныг тус тус баримтлан “Хөвсгөл далайн эзэд” ТББ-ын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, тус ТББ-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай.	1. Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 568 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч “Хөвсгөл далайн эзэд” ТББ, нэхэмжлэгч иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.	Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 1-ний 568 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 78 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхисугай.

²⁰⁷ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²⁰⁸ <http://www.shuukh.mn/zahirgaanhan/1192/view>

²⁰⁹ <http://www.shuukh.mn/zahirgaadavah/540/view>

²¹⁰ <http://www.shuukh.mn/zahirgaahanalt/417/view>

Хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг-3²¹¹

	Давж заалдах шатны шүүх ²¹²	Хяналтын шатны шүүх ²¹³
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2018.09.13 Дугаар 221/МА2018/0510	2018.11.14 Дугаар 0458
Шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Ноостын Хонинхүү	Бямбаагийн Мөнхтуяа
Нэхэмжлэгч	“НУАХ” НҮТББ	“НУАХ” НҮТББ
Хариуцагч	АМГТГКХ	АМГТГКХ
Гуравдагч этгээд	Монгол Улсын Засгийн газар, “С м” ХХК	Монгол Улсын Засгийн газар, “С м” ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 128/ШШ2018/361 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцаасугай.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 221/МА2018/0510 дугаар магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

Тайлбар: Тус хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр нь шүүхийн шийдвэрийн цахим санд байршаагүй байна.

²¹¹ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²¹² <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2463/view>

²¹³ <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1663/view>

Хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг-4²¹⁴

Анхан шатны шүүх ²¹⁵	
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2016.07.22 Дугаар 539
Шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх
Шүүгч	Нарандашийн Дуламсүрэн
Нэхэмжлэгч	Дэлхийн Монгол Ногоон нэгдэл ТББ
Хариуцагч	Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга
Гуравдагч этгээд	Гутайн даваа ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч “Дэлхийн Монгол Ногоон нэгдэл” ТББ-аас Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргад холбогдуулан гаргасан “Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсээс хууль зөрчиж “Гутайн даваа” ХХК-д олгосон 019023 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулах” нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

²¹⁴ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²¹⁵ <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1598/view>

Хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг-5²¹⁶

	Анхан шатны шүүх ²¹⁷	Давж заалдах шатны шүүх ²¹⁸	Анхан шатны шүүх ²¹⁹
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2017.03.10 Дугаар 173	2017.05.24 Дугаар 221	2018.01.22 Дугаар 40
Шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх
Шүүгч	Доржготовын Чанцалням	Ноостын Хонинхүү	Бямбаагийн Мөнх-Эрдэнэ
Нэхэмжлэгч	Ангир нүдэн Мөндөөхэй хөдөлгөөн ТББ	Ангир нүдэн Мөндөөхэй хөдөлгөөн ТББ	Ангир нүдэн Мөндөөхэй хөдөлгөөн ТББ
Хариуцагч	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл
Гуравдагч этгээд	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК

²¹⁶ Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

²¹⁷ <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2901/view>

²¹⁸ <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1975/view>

²¹⁹ <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4287/view>

Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч “Ангир нүдэн Мөндөөхөй хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлээр БОАЖЯ-ны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлд холбогдуулан гаргаснаар “...Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны “Монголиа Гладвилл Увс Петролиум” ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг хүчингүй болгуулах”-ыг хүссэн шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 173 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.	Нэхэмжлэгч “Ангир нүдэн Мөндөөхөй хөдөлгөөн” ТББ-ын нэхэмжлэлтэй БОАЖЯ-ны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлд холбогдох Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны “М” ХХК-ийн Увс-1 газрын тосны хайгуул, судалгааны төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг баталсан шийдвэрийг дахин шинэ акт гартал 2 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
---------------------------------	--	---	--

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр-1²²⁰

	Анхан шатны шүүх ²²¹	Давж заалдах шатны шүүх ²²²	Хяналтын шатны шүүх ²²³
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2012.04.17 Дугаар 854	2012.07.02 Дугаар 519	2012.10.04 Дугаар 563
Шүүх	Баянзүрх дүүргийн шүүх	Нийслэлийн шүүх	Улсын дээд шүүх
Шүүгч	Дамдинжавын Солонго	Цэвээндоогийн Өрнөндэлгэр	Дагвадоржийн Тунгалаг
Нэхэмжлэгч	“Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ	“Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ	“Монголын байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл” ТББ
Хариуцагч	“Петро чайна дачин тамсаг” ХХК	“Петро чайна дачин тамсаг” ХХК	“Петро чайна дачин тамсаг” ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Хариуцагч "Петро чайна дачин тамсаг" ХХК нь Дорнод аймгийн Матад сумын 4 дүгээр багийн нутаг Тосон-Уул 19 дүгээр талбайд газрын тосны үйл ажиллагаа явуулахдаа байгаль хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлээгүй болохыг тогтоож, "Петро чайна дачин тамсаг" ХХК-иас нөхөн төлбөр 1,356,622,460 төгрөгийг гаргуулан Дорнод аймгийн Матад сумын орон нутгийн төсөвт оруулж, нэхэмжлэлийн шаардлагаас байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхийг хариуцагч "Петро чайна дачин тамсаг" ХХК-д даалгах тухай хэсгийг хэрэгсэхгүй болгосугай.	Баянзүрх дүүргийн шүүхийн 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 854 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн төлөөлөгчийн давж заалдсан гомдлыг хангахгүй орхисугай.	Баянзүрх дүүргийн шүүхийн 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 854 дүгээр шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 519 дүгээр магадлалыг тус тус хэвээр үлдээв.

²²⁰ Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

²²¹ <http://old.shuukh.mn/irgenanhan/33602/view>

²²² <http://old.shuukh.mn/irgendavah/1328/view>

²²³ <http://old.shuukh.mn/irgenhyanalt/554/view>

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр-2²²⁴

	Анхан шатны шүүх ²²⁵	Давж заалдах шатны шүүх ²²⁶
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2013.08.08 Дугаар 1542	2013.12.11 Дугаар 965
Шүүх	Сүхбаатар дүүргийн шүүх	Нийслэлийн шүүх
Шүүгч	Өлзийн Уянга	Гүррагчаагийн Алтанчимэг
Нэхэмжлэгч	“Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ	Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо” ТББ
Хариуцагч	“Таван толгой” ХК, “Нүүрсний зам” ХХК, “Энержи ресурс” ХХК	“Таван толгой” ХК, “Нүүрсний зам” ХХК, “Энержи ресурс” ХХК
Шийдвэрийн товч агуулга	1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.4, 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, БОХТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 49 дүгээр зүйлийн 49.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-т зааснаар “Таван толгой” ХК-аас 101,851,492,835 төгрөг, “Энержи ресурс” ХХК-аас 52,235,485,736 төгрөгийг тус тус гаргуулан Байгаль хамгаалах санд олгосугай 2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-д зааснаар нэхэмжлэгч “Байгаль орчны төлөө хуульчдын холбоо” ТББ нь хариуцагч “Нүүрсний зам” ХХК-д холбогдох нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсаныг баталж, “Нүүрсний зам” ХХК-д холбогдох хэргийг хэрэгсэх болгосугай.	1. Сүхбаатар дүүргийн шүүхийн 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 1542 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр тус шүүхэд буцаасугай. 2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-т зааснаар хариуцагч “Энержи ресурс” ХХК-ийн төлсөн 261,335,379 төгрөг, “Таван толгой” ХК-ийн төлсөн 509,415,414 төгрөгийг шүүгчийн захирамжаар тус тус буцаан олгосугай.

²²⁴ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²²⁵ <http://old.shuukh.mn/irgenanhan/68078/view>

²²⁶ <http://old.shuukh.mn/irgendavah/2786/view>

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр 3²²⁷

	Анхан шатны шүүх ²²⁸	Давж заалдах шатны шүүх ²²⁹
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2011.03.15 Дугаар 447	2011.06.10 Дугаар 493
Шүүх	Сүхбаатар дүүргийн шүүх	Нийслэлийн шүүх
Шүүгч	Намжилсүрэнгийн Оюунтуяа	Хээмчигийн Сонинбаяр
Нэхэмжлэгч	“Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ	“Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” ТББ
Хариуцагч	Монгол Улсын Засгийн газар	Монгол Улсын Засгийн газар
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Монгол Улсын Засгийн газарт холбогдох Онги гол, Завхан гол, Туул гол, Хангилцагийн гол, Хүдэр гол, Улз гол, Ерөө гол, Гацууртын голуудын сав газар дээр учирсан байгаль орчны хохирлын үнэлгээг хоёр сарын дотор тооцож олон нийтэд зарлахыг даалгах, уг голуудын ав газарт учирсан байгаль орчны хохирлыг Монгол Улсын Засгийн газраар барагдуулах, дээрх голуудын сав газрын байгаль орчныг нөхөн сэргээх ажиллагааг “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” Төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг хариуцагчид даалгуулах, хохирол 68,908,512 төгрөг гаргуулах, ГМУБЭУСБГХБО СБГАМХАХТХ-ийн дагуу аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан тогтоолыг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 15 хоногийн дотор гаргахыг даалгахыг хүссэн “Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн” Төрийн бус байгууллагын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 447 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч ТББ-ын гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

²²⁷ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²²⁸ <http://old.shuukh.mn/irgenanhan/3652/view>

²²⁹ <http://old.shuukh.mn/irgendavah/289/view>

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр 4²³⁰

Анхан шатны шүүх ²³¹	
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2014.08.15 Дугаар 3393
Шүүх	Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх
Шүүгч	Төмөртоогогийн Энхжаргал
Нэхэмжлэгч	“Эрүүл байгаль, энх амьдрал, энэрэнгүй үйлс” НҮТББ
Хариуцагч	“Рэдхил Монголиа” ХХК
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	Нэхэмжлэгч “Эрүүл байгаль, энх амьдрал, энэрэнгүй үйлс” НҮТББ-ын хариуцагч “Рэдхил Монголиа” ХХК-д холбогдуулан гаргасан “Канад Улсын хөрөнгө оруулалттай “Рэдхил Монголиа” ХХК-ийг шаардлагатай тусгай зөвшөөрөл буюу усны зөвшөөрөл байхгүй, 2012 оны Байгаль хамгаалах төлөвлөгөө, 2012 оны тайлан, 2013 оны уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны шинжилгээний төлөвлөгөөг батлуулалгүй хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан болон явуулж байгаа болохыг тогтоолгох, байгаль орчинд учруулсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоолгохын тул “Чойбалсангийн охин” ХХК-иар хийлгэх байгаль орчны нарийвчилсан үнэлгээний төлбөр болох 1,300,000 төгрөг гаргуулах тухай” нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

²³⁰ Дүн шинжилгээ хийсэн судлаач Л.Отгондорж

²³¹ <http://www.shuukh.mn/irgenanhan/12719/view>

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр 5²³²

Анхан шатны шүүх ²³³	
Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	2019.08.20 Дугаар 133
Шүүх	Говь-Алтай аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх
Шүүгч	Д.Янжиндулам
Нэхэмжлэгч	Говь-Алтай аймгийн Прокурорын газар
Хариуцагч	Иргэн Д.А, С.Б, Н.М, Ш.Т
Шүүхийн шийдвэрийн товч агуулга	1. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасныг тус тус баримтлан хариуцагч Д.А, С.Б, Н.М, Ш.Т нарт холбогдуулан гаргасан үйлдвэрлэлийн зориулалтын гялтгануур чулууг тусгай зөвшөөрөлгүйгээр олборлож байгаа байгаль орчинд учруулсан хохиролд 1,808,100 төгрөг гаргуулахыг хүссэн Говь-Алтай аймгийн Прокурорын газрын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

Тайлбар: Тус шүүхийн шийдвэр нь байгаль орчны хэрэг дээр Прокурорын зүгээс иргэний хэргийн нэхэмжлэл гаргасан онцлогтой байх тул сонгосон болно.

---oo0oo--

²³² Дүн шинжилгээ хийсэн судлаач С.Сүхчулуун

²³³ <http://new.shuukh.mn/irgenanhan/88719/view>

Хавсралт 2.

**Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах үед
тулгардаг бэрхшээлүүд (Холбогдох төрийн бус байгууллагаас
утсаар холбогдож авсан судалгааны товч үр дүн)²³⁴**

№	ТББ	Үйл ажиллагааны чиглэл	Хамрах орон нутаг	Бэрхшээл
1	Шинэ суурьшил аюулгүй орчин ТББ	Суурьшлын бүсэд хууль зөрчин элс, хайрга олборлож буй Боржигоны тал ХХК-ний суурьшлын бүс дэх тусгай зөвшөөрлийг цуцлуулах	Улаанбаатар	<ul style="list-style-type: none"> – Нотлох баримт цуглуулахад эрх мэдэл дутдаг – экологийн үнэлгээний дүгнэлт хууль бусаар гаргуулдаг, маш удаашралтай, – Мэдээллийн ил тод байдлын хууль хэрэгждэггүй. Шалтаг тоочдог. – Шүүх дээр бидний авсан зураг, Бичлэг зэрэг нь нотлох баримтын шаардлага хангадаггүй. – Хууль бусаар ажиллаж байхад нь ороход биднийг зөрчлийн хуулиар торгодог.
2	Онон Улз голынхон ТББ	“Байгаль орчныг хамгаалах журмыг зөрчсөнөөс үүдэлтэй хохирлыг тогтоолгож, нөхөн сэргээлтийг шүүхийн журмаар хянан шийдвэрлүүлэх”	Хэнтий	<ul style="list-style-type: none"> – Экологийн Үнэлгээ хийлгэхэд зардлыг өөрсдөө төлдөг. Зардал үнэтэй. Төр хийх ёстой байхад ТББ-аар хийлгэдэг. Үүнийг хуульчлах хэрэгтэй.

²³⁴ Судалгаа хийсэн Л.Отгондорж

Шүүхийн шийдвэрийн шинжилгээ

3	Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ	Газрын тосны хууль тогтоомжийн хэрэгжилт	Дорнод аймаг –	Гуравласан гэрээ байгуулах тухай УДШ-ийн тогтоол гарсан. Шүүхийн шатанд асуудал гайгүй
4	Хөвсгөл далайн эзэд ТББ	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах		<ul style="list-style-type: none"> – Нэхэмжлэх эрх хязгаарлагдмал – Экологийн хохирол өндөр бол зардал нь мөн өндөр гардаг – Өмгөөлөгчийн хөлс өндөр боловч энэ чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгч ховор – Шүүгч нарын хандлага өөр байдаг. Нөгөө талд нь мөнгө, эрх мэдэлтэй хүмүүс байдаг.
5	Монголын байгаль эхийн аврал сан	Увс аймгийн Хяргас суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Хорико-ваметал”-ХК-ны гаргасан зөрчлийг таслан зогсоох		<ul style="list-style-type: none"> – Материал бүрдүүлэлт чирэгдэл ихтэй, – Бүрдүүлбэр дутуу гээд хэрэг үүсгээгүй, бүрдүүлэлтээ хийж байгаа. – Цаг хугацаа алддаг. – Зардал асуудалтай. Хөдөө орон нутгаас материал авахад зардал өндөр гарна.

---oo0oo---

ISBN 978-9919-9645-8-0



9 789919 964580